

Ногоон хөгжлийн төлөө

# MONGOLIAN ECONOMY



Нэрийн данс хоосон биш,  
хувьцаатай байг

Улс төрд олзлогдсон Оюутолгой

Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн сэтгүүл

2011. 10 сар. №008

[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)



Улаанбаатар-Санхүүгийн  
төв болж чадах уу

Nissan Motors Co., Ltd.  
www.nissauk.com



# PRINCIPLES OF LEADERSHIP.

BMW 7 Series. Inspired by the core principles that take leaders from success to success.

# SWAROVSKI



## *Wings of Fantasy*

NEW COLLECTION  
FALL/WINTER 2011/12

© SWAROVSKI 2011



Swarovski boutique-1: 4 давхар, Наран Плаза тов,  
Чингсийн өргөн чөлөө #29  
Swarovski boutique-2: 2 давхар, Сэнтрал Тауэр,  
Сүхбаатарын талбай  
Утас: 32 88 41



Хөрөнгийн зах зээл болон бусад санхүүгийн үйлчилгээ хөгжихөд хүмүүсийн мэдлэг, ур чадвар л хамгийн чухал юм.....7



Хөрөнгө оруулалт, экспортын орлого гэх шогшготой “ноён доллар” манайд саатаж чадахгүй, тоног төхөөрөмж, түлш, шатахуун болж хувирахын тулд гараа даллаад алга болж байна.....10



Сэтгүүл зүй тэр дундаа эдийн засгийн сэтгүүл зүйн салбарт том шинэчлэл гарсан гэдгийг олж харсан. Энэ нь “Mongolian Economy” сэтгүүл юм.....25

## Санхүүгийн зах зээл

- 6 Үзэгчийн суудлаас...
- 7 М.Болд: Монголын банк, даатгалын салбарынхан хурдан суралцаж, авхаалжтай ажиллах хэрэгтэй байна
- 10 “Ноён доллар”, та хаачих нь вэ?
- 13 Улаанбаатар-Санхүүгийн төв болж чадах уу?
- 14 Нэрийн данс хоосон биш, хувьцаатай байг
- 16 Даатгалын салбарын шинэ боломжууд
- 17 Хөгжлийн банкны бондод хөл ургаад, хилийн дээс алхаасай
- 19 “Магадлал бага” буюу “хэзээ ч”...
- 20 Үрэх үү, өсгөх үү

## Эдийн засаг

- 23 Төсөв, мөнгөнд төрийн бодлого үгүйлэгдэж байна
- 25 Грэм Уоттс: Та бүхэн Монголын эдийн засгийн сэтгүүл зүйд том шинэчлэл авчирчээ
- 26 Хөгжил өөд хөдөлмөрлөгчид
- 29 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үндсэн зарчим, зорилго алдагдаж байна
- 30 Хийн хоолой ба хөршүүдийн сонирхол
- 31 Давосын зуны чуулганд Монголыг “гайхуулжээ”

## Ногоон эдийн засаг

- 32 Салхитай Монгол
- 34 Атомщикүүдтай маргах нь

## Уул уурхай

- 36 Улс төрд олзлогдсон Оюутолгой
- 39 “Рио Тинто” компани Монголын уул уурхайд тодорхой бус байдалтай тулгарлаа
- 40 Зэсийн үнэ огцом уруудсаар
- 41 Тулгын гурван чулуу байж гэмээнэ тогоо тавьж, хоол болно
- 42 Б.Ариунсан: Төрөөс хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх бодитой алхмууд хийж байна

## Бизнес

- 44 Зөв газраа зөрүүд зангаа гаргаж яваа хүн
- 46 Нийгмийн хариуцлага “урт нас бэлэглэнэ”
- 49 Логистикийн салбарыг хөгжүүлэх алхмыг хийлээ
- 51 Зан чанар амжилтын бүрэлдэхүүн хэсэг



Засгийн газраас КНХ-ыг хөгжүүлэх хөшүүрэг, эрх зүйн орчныг бий болгох замаар дэмжиж ажиллах нь хамгаас чухал гэдэгтэй мэргэжилтнүүд санал нэгдэж байлаа.....46

ᠮᠠᠨᠠᠢ ᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ,  
Үддөёя+: Ä.Äүдäауd  
9999 4248

ᠮᠠᠨᠠᠢ ᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ,  
Ídëiä+ Ýdðëýä+:  
È.Ídäiíæäðääë  
8800 6228

Àíáèè ðýëíéé däääèdòð:  
Terrence Edwards

ᠨᠢᠶᠠᠨᠠᠶᠢᠨᠠᠨᠠᠭᠤᠨ:  
Ä.Í'íð+èiyä  
Ö.Öóëäí  
Ý.Çíðëäò  
Ä.Ääýdòíäòíð

Íð+óóëää+:  
Ý."èçéëdäi

Äèçäéíäð:  
Ø.Ípóíäü

Íäðëäòèíäéí íäíäæäð:  
Ä.Ääðëäíæäð  
8880 0825  
Ä.Ýíðöýöýä  
9901 5476

Öäýä:  
Óëäíäíäàdòd, ×Ä IV dðíí,  
Àíëäðääéí äóääíæ-23  
Öíä Öäóýd-604 dðíð

15160 Óëäíäíäàdòd,  
Ö"ä óóääí, ø/ d-2762

Ódän/Öäèñ: 976 - 7011 5476

www.mongolianeconomy.mn  
info@mongolianeconomy.mn

“Улаанбаатар принт”  
ХХК-д хэвлэв  
www.ubprint.mn

Äíðëöóëäð öýäᠯᠯä:

"Èíöäð íí"  
"Öýöýä d"ä"  
"Çëä çää" ääöíñäðäèñ  
"Íëäë íëäçä"  
"Äèääíðçèdòçèd" ííüí äýëäᠯᠯd  
"Ííëí" ñóíäðíäðèäèéí äçd ñäçääd  
"Íäèñ" ñóíäðíäðèäèéí äçd ñäçääd  
"Ídänñí" ñóíäðíäðèäèäò  
BTSI ñóíäðíäðèäèäò  
"Äç íð+èí" ííüí äýëäᠯᠯd  
"Äèçýä" èð äýëäᠯᠯdèéí ííüí dänää  
"Ädäíä Íëäçä" ääöü ñóíäðíäðèäèäò

"Íèð" ííüí äýëäᠯᠯdèéí  
"Grand plaza"  
"Metro mall"  
"Sky" ñóíäðíäðèäèäò  
"Óëäíäíäàdòd" èð äýëäᠯᠯd äýd ñäçääd

## Эрхлэгчийн зурвас

Санхүүгийн зах зээлийг нэг сайн ойлгомоор байна аа. 20-иод жилийн бизнесийн авьяас ухаанд минь санхүү, эдийн засгийн боловсрол дутаад байна” хэмээн “Нарантуул” захад наймаа эрхэлдэг нэгэн танил маань нухацтай гэгч нь ярив. Хөрөнгө мөнгө, бэл бэнчин, наймааны ухаанаараа ч захын наймаачид дотроо дээгүүрт тооцогдох тэрбээр сүүлийн үед ийн санаашрах болж. Зөвхөн захаар зогсохгүй “Гурван гал”, “UB mart”, “Metro mall” зэрэг хотын төвийн шил толь болсон томоохон дэлгүүрт ч барааныхаа лангууг нээж амжсан овсгоотой танилыгаа санхүүгийн зах зээлийн талаар боломжийн түвшний мэдлэгтэй нэгэн байх гэж таамаглаж байсан минь ташаа байжээ.



“Зэсийн үнэ унадаг үе нь ирчихсэн үү, өнгөрсөн жилүүдэд манай Засгийн газар тэгээд зэсийнхээ орлогоос овоо мөнгө цаашаа хийж чадсан болов уу” гэж сэтгүүлч найзаасаа сүрхий сониучирхана, тэр. Түүнчлэн брокер дилерийн компани байгуулахад юу бүрдүүлж, хаана ханддаг юм бол оо гэж хүртэл лавлана.

Хөгжих үү, эс хөгжих үү гэдэг салаа замын уулзварт байгаа Монголын өнөөгийн байдлын толины ойлт тусгалын нөгөө тал нь захын наймаачин танилын маань хэлсэнчлэн санхүүгийн боловсрол юм. Хүн бүр өнөөдөр хүссэн хүсээгүй үүнийг ойлгох учиртай. Ойлгох гэж биеэ дайчлахгүй хичээхгүй аваас улсын хөгжил, эдийн засгийн өсөлтийн алиных нь ч амтыг мэдрэхийг хүсэхгүй ойд тойрсон сармагчин лугаа болмой. Уг нь бол танил маань өнөөдрийн байгаа амьдралдаа тийм ч их санаашраад байхаар биш. Тас хар өнгөтэй “Land-200” маркын машин хөлөглөж, “Баянмонгол” хороололд гурван өрөө байртай. Бас болоогүй ээ, тариалангийн газар, зуслангийн хаус, эмч эхнэр, Америкт сурдаг охин гээд дутуу юмгүй дүүрэн амьдардаг баячуулын л адил. Харин түүнд “Эдээр биеэ чимхээр эрдмээр биеэ чим” гэдэгчлэн эдийн засаг, санхүүгийн боловсрол дутаж байгааг өөрөө мэдэрчээ. Баяжихдаа гол нь биш, даатгалын салбарыг, хөрөнгийн зах зээлийг ойлгохыг хичээж байна тэр. Ингэснээр эх орныхоо хөгжил цэцэглэлттэй хөл нийлүүлэн алхахыг хүсэж байна. Харилцан хамаарал нь улам бүр нэгдэн нийлж буй хавтгай дэлхийн хөгжилтэй хөл нийлэхийг эрмэлзэж байгаа хэрэг.

Манай сэтгүүл энэ удаагийнхаа дугаарын голлох мэдээ мэдээллийг энэ чиглэлд хандуулахыг хичээлээ. Санхүүгийн зах зээлийн талаар мэдлэг мэдээллийг олон нийт, нийгэм шаардаж байна. “Mongolian Economy” сэтгүүлийн шинэ дугаарын зочин “Тэнгэр санхүүгийн нэгдэл”-ийн гүйцэтгэх захирал М.Болдын ярилцлага уншигч танд банк, санхүүтэй холбоотой ойлголт, олон шинэ мэдээллийг хүргэнэ. Түүнчлэн манай сэтгүүлчийн бичсэн “Нэрийн данс хоосон биш, хувьцаатай байг” гарчигтай нийтлэлээс таны нийгмийн даатгалд сар бүр суутгуулдаг мөнгө хэрхэн өсөж үрждэгийг, үр шимийг нь жинхэнээсээ хүртвэл ямар байх гээд сонирхол татна. Бас нэгийг бодуулах вий.

Мөн даатгалын салбарын шинэ боломжууд, байгууллагын эрсдэлийн менежментийг хэрхэн хэрэгжүүлэх вэ, айсуу сонгуультай холбоотой Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт хийх гэж буй болон Төсвийн тогтвортой байдлын тухай хууль уланд гишгэгдэхээр болж байгаа тухай зэрэг сэдвээр мэргэжлийн эдийн засагч, санхүүч, шинжээч нарын үгийг хүргэж байна.

Орлогч эрхлэгч И.Отгонжаргал

# Санхүүгийн зах зээл



Онцлох сэдэв

## Үзэгчийн суудлаас...

Эдийн засгийн өсөлтөөрөө Монгол Улс дэлхийд тэргүүлж байна. Энэ оны хоёрдугаар улиралд ДНБ 17.3 хувиар нэмэгдсэн нь дэлхийг алмайруулав. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ гэрлийн хурдаар өсөж, он гарсаар гурав дахин нэмэгдсэн тухай мэдээлэл цацагдлаа. Монголын чоно эдийн засгаас гаднын хөрөнгө оруулагчид од шүүрэх боломжийг хэдийнэ олж харжээ. Харин монголчууд өөрсдөө үүнийг мэдэхгүй, мэдрэхгүй байгаа нь харамсалтай.

Лондон, Нью-Йорк, Торонто, Хонконг зэрэг томоохон хөрөнгийн биржид Монгол Улсын уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг гаднын компаниуд хувьцаагаа гаргаж, монголчуудын толгойд ч орж ирэхээргүй хэмжээний их мөнгө босгож чадаж байна. “Айвенхоу майнз”-ын зах зээлийн нийт үнэлгээ л гэхэд 15 тэрбум ам.доллар байгаа нь Монголын ДНБ-ийг хоёр нугалсан хэмжээ гээд бод доо. Ашигт малтмалын ханш тэнгэрт хадсан өнөө үед хэвлийдээ асар их баялаг нуусан Монголын нутаг моодонд орж, хөрөнгө оруулагчдын аазгайг хөдөлгөнө. Үүнийг ашиглан гадаадын компаниуд “Яндаж болдоггүй далай шиг яасан баян нутаг вэ” хэмээн баярлаж, зэгсэн хөрөнгө

босголоо. Хөрөнгийн зах зээл болон олон төрлийн санхүүгийн үйлчилгээ хөгжсөн орнуудад бизнесийн шинэ санаа олоод, ирээдүйтэй төлөвлөгөө боловсруулчихсан байхад л хөрөнгө, мөнгөөр дутагдана гэсэн гачаалал байдаггүй нь юутай сайхан. Харин Монголд 80 төрлийн ашигт малтмалын 1170 орд, 8000 орчим илэрц байгаа ч тэднийгээ эдийн засгийн эргэлтэд оруулах ч мөнгө алга. Одоо бидэнд сонголт хийх цаг иржээ. “Алтан дээр суусан гуйлгачин” хэвээр үлдэх үү, эсвэл санхүүгийн зах зээлээ хөгжүүлэх үү?

Олон улсын жишгээр бол санхүүгийн зах зээл дэх хөрөнгө оруулалтыг арилжааны банк, хөрөнгийн зах зээл нь тэнцвэртэй бүрдүүлж байх ёстой. Гэтэл Монголын санхүүгийн салбарын 95.6 хувийг банкны салбар дангаараа эзэлдэг бөгөөд үлдсэн 4.4 хувийг л үнэт цаасны зах зээл, даатгал зэрэг бусад салбарынхан эзэлж байгаа юм. Энэхүү гаж тогтолцоог хэрхэн өөрчлөх тухай санал бодлоо “Тэнгэр” санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал Магваны Болд “Mongolian Economy” сэтгүүлтэй хувцаалцсан юм.

Өдөр бүр Улаанбаатарт өндөр өндөр барилга шинээр сүндэрлэнэ.

- 10 “Ноён доллар”, та хаачих нь вэ?
- 13 Улаанбаатар-Санхүүгийн төв болж чадах уу?
- 14 Нэрийн данс хоосон биш, хувьцаатай байг
- 16 Даатгалын салбарын шинэ боломжууд
- 17 “Магадлал бага” буюу “хэзээ ч” ...
- 18 Үрэх үү, өсгөх үү
- 19 Та хувьцаа авсан уу?

Шил толь болсон тэдгээр оффисын зориулалттай байранд ихэвчлэн гаднын уул уурхайн компани байрлах ажээ. Тэдний толгой ажилладаг юм болохоор Монголд үйл ажиллагаа явуулж байгаагаа ашиглан хөрөнгөжиж чадсан. Харин монголчууд үзэгчийн суудалдаа суухдаа сэтгэл хангалуун байх шиг. Уул уурхай, барилгын ажил эрчимжиж, гаднын хөрөнгө оруулалттай компанид өндөр цалинтай ажилд орж буй монгол хүний тоо ч олширч буй. Монголчуудын орлого нэмэгдэж байна. Гэвч гэртээ LED зурагт тавьчихаад, LEXUX хөлөглөж, НТС барьж байгаагаа бэл бэнчинтэйд тооцож, сэтгэл ханаж байвал сэтгэлгээгээ өөрчлөх цаг болжээ. Монголд орж ирэх валютын урсгал эрчимжихийн хэрээр импортын хэмжээ огцом нэмэгдэж байгаагийн дотор автомашины тоо суга өсөж буй нь монголчуудын үрэлгэн, хэрэглээнд дуртай сэтгэхүйг шууд илтгэнэ. Мөнгөний бараа харав уу, үгүй юү түүнийгээ үрэх тухай биш, хөрөнгийн зах зээлд эргэлдүүлэх замаар өсгөх тухай бодох цаг болсныг “Үрэх үү, өсгөх үү” нийтлэлээс уншаарай.

Үүний зэрэгцээ Монголын арилжааны банкууд дахь нийт хадгаламж өнгөрсөн долдугаар сард ▶▶

► өмнөх оныхоос 73 хувиар өсөж, 2.6 их наяд төгрөгт хүрсэн бол гадаад валютын хадгаламжийн хэмжээ 867 тэрбум төгрөгөөс давжээ. Энэ нь нэг талаас бидэнд хуримтлал байгааг харуулна. Нөгөө талаас монголчуудын идэвхгүй, санаачилгагүй байдлыг илтгэж байна гэвэл нэг их буруудахгүй. Яагаад энэ мөнгийг хөрөнгийн зах зээлд эргэлдүүлж болохгүй гэж? Засаглал, ил тод байдал гэдгийг уландаа гишгэсэн монгол компаниудын хувьцааг худалдаж авах нь эрсдэл ихтэй гэдэг үнэн. Гэвч ахиу ашиг олохын тулд их эрсдэл хүлээх нь гарцаагүй. Үүнээс үүдээд монголчууд эрсдэлээ удирдаж сурна, санхүүгийн мэдлэгтэй болно. Эрсдэлээс зайлсхийх хөрөнгө оруулагчдын сонирхлыг дагаад даатгалын салбар өргөжин тэлнэ. Энэ мэтчилэн гинжин холбоогоор санхүүгийн зах зээл бүхэлдээ босож ирэх учиртай.

Эдүгээ монгол хүн бүр “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцаа эзэмшигч буюу хөрөнгө оруулагч болсон. Гэхдээ гурван монгол хүний нэг нь нэн ядуугийн ангилалд багтаж байгаа, нийт иргэдийн санхүүгийн мэдлэг дорой өнөө үед үнэгүй авсан хувьцаагаа хүмүүс хамгийн анхны боломжоор зарна хэмээн мэргэжилтнүүд анхааруулж буй. Товчхондоо, цэнхэр ягаан тасалбарын сургамж давтагдах эрсдэлтэй бөгөөд энэ удаад гаднынхан хамаг хувьцааг хамж аваад, монголчууд хоосон хоцрох магадлал өндөр. Гаднаас хэт хамааралтай болох нь ямар муу талтайг, түүнээс урьдчилан сэргийлэхийн хажуугаар иргэдийнхээ ирээдүйн баталгааг найдвартай болгох үүднээс Тэтгэврийн сангийн мөнгийг эргэлтэд оруулах хэрэгтэйг “Нэрийн данс хоосон биш, хувьцаатай байг” нийтлэлээр хүргэхийг зорив.

“Hearst Magazines International” компанийн захирал Дункан Эдуардс “Cosmopolitan” сэтгүүлийн монгол хувилбарыг хэвлүүлэх санаагаа яаж олсон тухай түүх сонирхол татдаг. Зүгээр л “Louis Vuitton”-ы захиралтай хоолонд орж байхдаа Монголд салбараа нээсэн тухай нь сонсоод, энд асар их боломж байгааг олж харсан гэдэг. Монгол Улс удахгүй үсрэнгүй хөгжилд хүрнэ гэсэн хүлээлт гаднын бизнес эрхлэгчдийн арааны шүлсийг асгаруулж буй. Улаанбаатарт “McDonald’s” ч үүдээ нээж амжаагүй байхад “Louis Vuitton”, “Burberry”, “Zegna”, “Emporio Armani” зэрэг тансаг зэрэглэлийн брэнд зах зээлээ хэдийнэ олчихлоо. Монголд бизнесийн боломж

асар их байгааг ажиглаж, боломжийг ашиглахын тулд монголчууд өөрсдөө авхаалж самбаатай байх хэрэгтэй ажээ.

Гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ огцом нэмэгдэж байгааг буруутгах гэсэнгүй. Харин ч түүнийг дагаад олон улсын стандарт, дэвшилт технологи нэвтрэх учиртай. Тухайлбал, Лондоны

хөрөнгийн биржийн удирдлага дор манай хөрөнгийн зах зээл 100 жилийн хоцрогдлоо аль болох богино хугацаанд арилгана гээд байгаа шүү дээ. Гэвч монголчууд өөрсдөө идэвх санаачилгатай болж байж л Монголд орж ирэх тэр их мөнгө, дэвшилт технологи, ноу-хауг хөрсөндөө буулгах буй за. Үзэгчийн суудлаас босож, тоглоомын талбайд гарах цаг иржээ. ■

**Банкир ярьж байна**

## М.Болд: Монголын банк, даатгалын салбарынхан хурдан суралцаж, авхаалжтай ажиллах хэрэгтэй байна

Д.Мөнх

**Тэнгэр” санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал Магваны Болдтой ярилцлаа. Олон улсын эдийн засагч мэргэжилтэй тэрбээр АНУ-ын Колумбын их сургуульд олон улсын харилцааны магистрын зэрэг хамгаалсан ажээ. Банкны салбарт 20 гаруй жил ажилласан М.Болд АНУ-ын Вашингтон хотод Дэлхийн банк, Олон улсын валютын сангийн зөвлөх, түүнчлэн хэсэг хугацаанд Афганистан улсын Төвбанкны зөвлөх хийж байв. 1996-2000 онд Монголбанкны дэд ерөнхийлөгчийн албыг хашиж байсан тэрбээр эдүгээ “ХасБанк”, “ХасЛизинг”, “Тэнгэр Даатгал”, “Тэнгэр Сольюшнс”, “ХасСекьюрити”, “Тэнгэрлиг Инвестментс” компанийг өөртөө багтаасан санхүүгийн том хөлөг онгоцыг жолоодож яваа хүнийхээ хувьд Монголын банк, санхүүгийн салбар, мөнгөний бодлогын талаар сонирхолтой яриа дэлгэсэн юм.**

**-Монголын санхүүгийн салбарын эрүүл мэнд ямаршуу байгаа вэ?**

-Эдүгээ манай санхүүгийн салбарт банк давамгайлж байгаа шүү дээ. 10-20 жилийн өмнөхийг бодвол банкуудын үйл ажиллагаа илт сайжирч, эрүүл явж байна. Олон улсын түвшинд хүрэх болоогүй ч гэсэн ойртож яваа гэж хэлж болно. Харин хөрөнгийн зах зээл, даатгалын салбарын хөгжил дорой, үр хөврөл төдий л байгаа.



Фотог Э.Зоригт

**-Манай санхүүгийн салбарын 95 гаруй хувийг банкны сектор дангаараа эзэлдэг гэдэг. Хөрөнгийн зах зээл, даатгалын үйлчилгээ яагаад хөгжихгүй байна вэ?**

-Хөрөнгийн зах зээл болон бусад санхүүгийн үйлчилгээ хөгжихөд хүмүүсийн мэдлэг, ур чадвар л хамгийн чухал юм. Тухайлбал, даатгалын компаниудад ажиллах хүнийг бэлтгэх боловсролын систем байх хэрэгтэй. ►

► Мөн тэдгээрийг хянаж, шалгах багийн мэдлэгийг олон улсын түвшинд хүргэх шаардлагатай байна. Ер нь бүхий л зүйл хүнээс хамаарч байдаг шүү дээ. Үүний хажуугаар хөрөнгийн зах зээл хөгжих хууль эрх зүйн үндэс Монголд байхгүй гэхэд болно. Хувьцаат компаниуд олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт нэвтрүүлээгүй, ил тод байдал хангадаггүй, санхүүгийн тайлангаа зохих журмаар гаргадаггүй учраас хөрөнгө оруулагчдын итгэлийг төрүүлэхгүй байна. Мөн бизнесийн маргаан гарлаа гэж бодоход түүнийг шударгаар түргэн шуурхай шийдвэрлэх шүүхийн тогтолцоо ч тааруу байна шүү дээ. Энэ бүх асуудлыг цогцоор нь шийдэж байж л хөрөнгийн зах зээл, даатгалын компаниуд хөгжиж чадах болов уу.

**-Эрдэс баялгийн салбар тэлж байгаа нь санхүүгийн зах зээлд сайнаар нөлөөлнө гэсэн хүлээлт бий. Гэвч Монголд ажиллаж байгаа гадаадын уул уурхайн компаниуд даатгал болон бусад санхүүгийн үйлчилгээгээ хилийн чанадаас авч байгааг юу гэж боддог вэ?**

-Санхүүгийн байгууллагууд харилцагчгүйгээр дангаараа оршин тогтнох үндэс байхгүй учраас уул уурхайн хөгжил санхүүгийн салбарт тодорхой хэмжээгээр нэмэр болно. Гэвч өнөөдөр Монгол Улсад хэрэгжиж байгаа томоохон уул уурхайн төслүүдэд шаардагдах хөрөнгийг дотоодын санхүүгийн байгууллагууд гаргаж өгч чадахгүй байна. Бага хэмжээний зээлийг бол банкууд өгч болж байгаа. Дотоодын даатгалын компаниудын хувьд олон улсын түвшинд хүрээгүй байна. Тиймээс уул уурхайн төслүүд ажлаа түргэн шуурхай явуулах үүднээс банкны болон даатгалын үйлчилгээг гадаадын компаниудаас авдаг. Монголын банк, даатгалын байгууллагууд хурдан суралцах, авхаалж самбаатай ажиллах л хэрэгтэй байна. Түүнээс биш гомдол нэхээд суух нь буруу л даа.

**-Гадаадын хөрөнгө оруулагчид Монголыг их сонирхох боллоо. Үүнтэй холбоотойгоор хилийн чанадаас хэтэрхий хамааралтай болчих вий гэсэн айдас төрж байна. Дотоодын хөрөнгө оруулагчдыг бий болгохын тулд юу хийх хэрэгтэй вэ?**

-Өнөөдөр монголчууд ядуу байна шүү дээ. Хувь хүн, өрх гэр, аж ахуйн нэгжүүд нь ч хөрөнгө мөнгөөр тарчиг учраас илүүдэл хөрөнгө оруулалт хийх нөөц бололцоо хомс байгаа юм. Цөөн



тооны уул уурхайн компани л хөрөнгө мөнгөний хувьд арай дээрдэж, шинэ төсөл, үйлдвэрлэлд хөрөнгө оруулах бололцоо нээгдэж байгаа. Ийм төрлийн үндэсний компанийн тоог л олшруулах бодлого хэрэгтэй байна.

**-“Тэнгэр” санхүүгийн нэгдлийн хувьд үйл ажиллагаагаа хэрхэн өргөжүүлэх бодолтой байгаа вэ. Хэтдээ олон улсын зах зээлд хувьцаа гаргах төлөвлөгөө бий юу?**

-Цаашдаа олон улсын зах зээлд гарахаас өөр замгүй. Өнөөдөр монголчууд зам барья, цахилгаан станцтай болъё, орон сууцанд орё гэхээр мөнгө байхгүй байна. Тэр мөнгийг одоогоор гадаадаас л авна шүү дээ. Уул уурхайн төслүүдээ эдийн засгийн эргэлтэд оруулъя гэхээр бас л мөнгө алга. Тиймээс гадаадаас л

мөнгө татахаас өөр аргагүй. Гэхдээ үүнээс нэг их айх хэрэг байхгүй болов уу. Америкчууд Хятадаас 1.2 их наяд, Японоос 900 тэрбум долларын зээл авсан байна шүү дээ. Дэлхийн номер нэг эдийн засаг хүртэл ийм их хэмжээний зээл авчихсан байна.

**-Гэхдээ Монголын тэтгэврийн сан, даатгалын компаниудын нөөц бололцоо сайн гээд байгаа. Үүнийгээ ашиглаад дотоодын институционал хөрөнгө оруулагчдыг бий болгох хэрэгтэй, тэгвэл гадаадаас хэт хамааралтай байхаас сэргийлж чадна гээд байдаг шүү дээ.**

-Тэтгэврийн санг урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэр болгох асуудал бол үнэхээр тулгамдсан, хийх ёстой ажлуудын нэг. Гэхдээ энэ нь шинэ асуудал огтхон ч биш юм. Бусад ►

оронд олон 10 жилийн өмнөөс туршаад, хэрэгжүүлээд, амжилттай явж байгаа. Гэтэл үүнийг монголчууд одоо хүртэл хэрэгжүүлэхгүй байгаа нь санхүүгийн зах зээлийн хөгжлийг хойш нь татаж байна л даа. Урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэр байхгүй өнөө үед бага ч гэсэн байгаа боломжоо ашиглаж чадахгүй байгаа нь эмгэнэлтэй л хэрэг юм. Харин даатгалын компаниудын хувьд одоогоор нөөц бололцоо хомс байгаа.

**-Та өмнө нь Монголбанкны дэд ерөнхийлөгч байсан, одоо хувийн хэвшлийн төлөөлөл болж байгаа хүнийхээ хувьд мөнгөний бодлогыг юу гэж боддог вэ?**

-Төвбанк хуулиараа бие даасан, улс төрийн нөлөөллөөс ангид байх эрхээр хангагдсан байдаг. Энэ байдлаа сайн хадгалж, мөнгөний бодлогоо явуулах л чухал байна. Гэхдээ мөнгөний бодлого дангаараа явах боломжгүй л дээ. Сангийн бодлого, татварын бодлого, УИХ-ын шийдвэрээс шууд хамаардаг.

**-Монголбанк сүүлийн үед мөнгөний бодлогоо чангаруулж эхлээд буйгаа төсвийн зарлага нэмэгдэж байгаатай холбон тайлбарладаг. Таны хэлснээр бэлэн мөнгө тараах улстөрчдийн шийдвэр мөнгөний бодлогод нөлөөлж байна уу. Энэ нь банк, санхүүгийн салбарт яаж тусах бол?**

-Нэгэнт төсвийн зарлага тэлээд ирэхээр мөнгөний бодлогыг чангалахаас өөр аргагүй байдаг. Төсвийн зардал нь ч тэлээд, мөнгөний бодлого нь ч сул байвал инфляци талийна шүү дээ. Энэ бол сурах бичиг дээр байдаг ойлголт. Мөнгөний бодлогыг хатууруулна гэдэг нь зээлийг хязгаарлана гэсэн үг. Бодлогын хүү өсөөд ирэхээр банкууд Төвбанкны үнэт цаас аваад, аж ахуйн нэгжүүдэд өгөх зээлээ багасгачихдаг. Тэгэхээр үйлдвэрлэл, үйлчилгээнд нийлүүлэх байсан мөнгө Төвбанк руу явчихна гэсэн үг. Тиймээс Монголбанк мөнгөний бодлогоо хатууруулахдаа хавтгайруулж биш, ялгавартай хандах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, хэрэглээний зээлд тавих шалгуураа чангалаад, үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалттай зээлд тавьж буй шалгуураа зөөллөх ёстой. Тухайлбал, махны үйлдвэрлэлд олгох зээл буурахад эргээд махны үнэ нэмэгдэнэ, үр дүнд нь инфляци өснө шүү дээ.

Харин бэлэн мөнгө тараах асуудлыг үнэхээр хэрэгцээтэй байгаа эмзэг бүлэг рүү л чиглүүлнэ үү гэхээс биш, одоогийнх шиг эрүүл саруул хүмүүст

өгөөд байх нь улс орныг мөхөл рүү явуулж байгаа хэрэг. Хүмүүсийг ажиллах чадваргүй болгож байна шүү дээ.

**-Таван жилийн дараа манай санхүүгийн салбар ямар түвшинд очсон байх бол?**

-Таван жилийн дараа Монголын санхүүгийн салбар 10 дахин нэмэгдэнэ гэсэн таамаглал гарсан байсан. Тэрийг би бодитой гэж үзэж байгаа. Эдийн засаг дахь үр нөлөө нь ч үүнийг дагаад нэлээд нэмэгдэх болов уу.

**-Санхүүгийн байгууллагуудыг харилцагчгүйгээр төсөөлөхийн аргагүй гэж Та хэлсэн. Тэгвэл монголчуудын хувьд санхүүгийн үйлчилгээ хэзээ хүртээмжтэй болсон байх бол. Өнөөдөр тухайлбал, зээл авахад өндөр хүүтэй, шалгуур ихтэй байгаа шүү дээ.**

-Нэг хүнд ногдох зээл олголтоороо Монгол дэлхийд тэргүүлж байгаа шүү дээ, манайхан л өөрсдөө мэдэхгүй байгаа болохоос биш. Дэлхийн банкны харъяа байгууллагын аль 2006 онд гаргасан судалгаагаар бичил зээлээр манай орон дэлхийд хоёрдугаарт явж байна. Тэгэхээр зээлийн хүртээмжийн хувьд муу биш гэж ойлгож болно. Ер нь хүн бүр зээл авах нь зохимжгүй. Бусад орон ч зээлд умбаад байдаггүй. Монголчуудын хувьд хамгийн тулгамдсан асуудал бол зээлийн хүү өндөр байгаа явдал юм.

**-Зээлийн хүүг бууруулах хэрэгтэйг хүн бүр ярьдаг. Сүүлийн жилүүдэд бага багаар буурсан ч гэсэн дорвитой үр дүн алга байх шиг. Яагаад Монголд зээлийн хүү ийм өндөр байдаг юм бэ?**

-Нэгдүгээрт, бэлэн мөнгө тараагаад байхаар бараа, үйлчилгээний үнэ дороо нэмэгдчихдэг. Яагаад гэвэл Монгол Улс өөрөө үйлдвэрлэгч биш, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнээ дандаа гаднаас авчирдаг. Тиймээс мөнгөний тоо хэмжээ нэмэгдэхэд хязгаарлагдмал тоо хэмжээтэй бараа, бүтээгдэхүүний үнэ л өснө. Тэгээд л төгрөгийн ханш унана. Инфляци 15 хувь байна гэж бодоход 100 төгрөг 85 төгрөг болчихно л гэсэн үг. Эсвэл 100 төгрөгөөр авч байсан талхыг 115 төгрөгөөр авна гэж ойлгож болно. Тэрийг дагаад яах вэ гэхээр хадгаламжийн хүү өснө. Банкинд мөнгөө хадгалуулах хүмүүс дор хаяж 15 хувийн хүү шаардана шүү дээ. Мөнгөнийхөө үнэ цэнийг алдахыг хэн ч хүсэхгүй. Хэрвээ банкууд хүүгээ өсгөхгүй бол хүмүүс автомашин, үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж авдаг ч юм уу, хадгаламжаас өөр хөрөнгө

оруулалт эрээд явчихна. Тиймээс банкууд мөнгийг хуримтлуулж, эх үүсвэр бүрдүүлэхийн тулд өндөр хүү амлахаас аргагүй. Тэрийгээ цааш зээл болгож гаргахдаа өөрийнхөө зардал, ашгийг нэмээд ирэхээр хүү бүр ч өндөр болох нь гарцаагүй. Ийм л чөтгөрийн тойрог шиг юм болчихоод байгаа юм. Банкууд өндөр хүүтэй зээл өгөөд байна гэсэн ойлголт байдаг. Гэтэл банкууд хүссэндээ биш, олж байгаа эх үүсвэр нь өндөр хүүтэй учраас л тэгж байгаа хэрэг.

**Хоёрдугаарт, монголчууд хуримтлалгүй, ядуу байна. 2000 хадгаламж эзэмшигч нийт хадгаламжийн 40 хувийг бүрдүүлж байна. Гэтэл нийт хадгаламж эзэмшигчийн 90-ээд хувь нь үлдсэн 60 хувийг эзэмшиж байгаа юм. Үүнээс монголчуудын бэл бэнчин маш дорой, муу байгаа нь харагдаж байгаа биз. Монголчууд элбэг дэлбэг амьдралтай, орлого сайтай байвал мөнгөний бодит хэмжээ нэмэгдэж, тэр хэрээр зээлийн хүү буурах ёстой л доо. Аливаа зүйл хомсдолтой байгаа нөхцөлд үнэтэй байдаг шүү дээ. Талх, мах хомсдолтой байвал үнэ нь өсдөгтэй ижил юм. Өөрөөр хэлбэл, нийт мөнгөний хэмжээ хомс байгаа учраас мөнгөний үнэ цэнэ өндөр байна.**

**-Хадгаламжийн хүү өндөр байгаатай холбоотойгоор “халуун мөнгө” орж ирээд байна гэж мэргэжилтнүүд ярьдаг. Энэ нь манай санхүүгийн салбарын хувьд хэр эрсдэлтэй вэ?**

-Том эсрдэл мөн л дөө. Төвбанк бодлогын хүүгээ нэмчихээр банкууд дагаад хүүгээ өсгөнө. Хадгаламжийн хүү ч нэмэгдэнэ. Тэгэхээр хүмүүст гадаадын банкуудад жилийн 0-2 хувийн хүүтэй байгаа мөнгөө Монголын 12-13 хувийн хүүтэй хадгаламжид оруулах сонирхол төрнө. Мэдээж гадныхан бага хугацаанд их ашиг олохын тулд л мөнгөө Монголын банкинд оруулна. Гэтэл ийм мөнгө тогтворгүй байдаг. Нийгэм, эдийн засгийн ялимгүй тогтворгүй байдал үүсэхэд л шууд гараад явах эрсдэлтэй учраас “халуун мөнгө” гэж нэрлээд байгаа юм шүү дээ.

Ингээд бодохоор Төвбанк мөнгөний нийлүүлэлтийг багасгах зорилгоор бодлогын хүүгээ нэмж байгаа нь харин ч эсрэгээрээ, төгрөгийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэх талтай. “Халуун мөнгө” ороод ирлээ гэхэд долларын хадгаламжийг хэзээ л бол хэзээ төгрөг рүү шилжүүлэх хэрэг гарч мэднэ. Энэ нь хэдэн зуун сая биш, хэдэн тэрбумаар тоологдох их мөнгө байвал ▶

яах билээ? Хатуу мөнгөний бодлого явуулах гэсэн биш, харин ч зах зээлд төгрөг нийлүүлчихэж байгаа хэрэг болно.

**-Нэгэнт л эрсдэлийн тухай ярьж эхэлсэн болохоор банкны салбарын эрсдэлийн удирдлагын тухай бодлоо хуваалцахгүй юу. Дэлхийн эдийн засаг дахиад хямарч, уналтад орж мэднэ гэсэн болгоомжлол сүүлийн үед төрөөд байгаа. Энэ тохиолдолд Монголын банкуудын бэлтгэл ямаршуу байгаа бол.**

-Санхүүгийн байгууллагуудын эрсдэлийн удирдлага 10-20 жилийн өмнөхөө бодвол эрс сайжирсан. Монголын банкны салбар 4-5 хямралтай нүүр тулж үзлээ шүү дээ. Энэ бүхнийг даваад гарсан банкууд нэг ёсондоо хямралын эсрэг вакцин сайн хийлгэж авсан гэж болно. Гэхдээ биеэ тоож болохгүй л дээ. Бэлтгэлтэй байх ёстой. Хямрал болоход яах вэ гэсэн арга чаргаа банкууд сайн мэддэг болсон.

**-2008 онд зэсийн үнэ огцом унахад манай гадаад валютын нөөц дундарч, ханш савалж, банкууд хэцүү байдалд орсон. Дахиад ийм байдал давтагдахгүй гэсэн баталгаа бий юу?**

-1990 он хүртэл Монгол Улс зөвхөн зэсийн үнээс л хамааралтай байлаа. Зэсийн үнэ сэргэвэл монголчуудын амьдрал гайгүй болдог, унавал доройтодог. Харин өнөөдөр арай өөр. Зэсээс гадна нүүрс, алт, газрын тос, төмөр, жонш зэргийг олборлоод гаргаад эхэлсэн. Тэгэхээр гадаад зах зээлийн цохилтод арай тэсвэртэй болсон болов уу.

Гэхдээ л энэ нь тайвшрах зүйл биш. Уул уурхайн орлогоороо бусад салбараа хөл дээр нь босгож байж л Монгол Улс хөгжилд хүрнэ. Ашигт малтмал бол хэзээ нэгэн цагт дуусна. Тэр үед монголчууд оюун ухааныхаа чадлаар эдийн засгаа аваад явах чадвартай болсон байх ёстой. Монгол цөөхөн хүн амтай болохоор олон зуун сая хүнтэй бусад оронтой өрсөлдөхийн тулд монгол хүн бүр хөдөлмөрийн чадвартай, боловсролтой байх ёстой л доо. Тиймээс хүнийхээ оюун ухаан, ур чадварт оруулах хөрөнгө оруулалт л хамгийн чухал.

**-Бичил зээлийн хүртээмжээр Монгол Улс дэлхийд хоёрдугаарт эрэмбэлэгддэг тухай Та хэлсэн. “ХасБанк” бичил зээлээр нэлээд удаан дагнасан учраас энэ салбар Монголд ямаршуу байгааг Та сайн мэдэх байх.**

-“ХасБанк” анх бичил зээлээр эхэлж байсан. Одоо энэ салбар Монгол Улсын хэмжээнд бусад оронтой харьцуулахад нэлээд хөгжсөн байна. Бичил зээлийг одоо бол бүх банк олгож байна. Дээрээс нь 150 банк бус санхүүгийн байгууллага, 300 хадгаламж зээлийн хоршоо бүгд бичил зээлээр дагнаж байгаа. Харин “ХасБанк”-ны хувьд одоо жижиг, дунд үйлдвэрлэлийн зээл нийт зээлийн багцын 50 хувийг эзэлж байхад бичил зээл 20 хувьд ч хүрэхгүй байна. Орон сууцны зээл 20 хувийг нь бүрдүүлж байх жишээтэй. Гэхдээ туршлага дээрээ үндэслээд бичил санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг компаниудын олон улсын нэгдэл болох зорилгоор бид 2009 онд Киргиз улсын “Мол Булак Финанс” санхүүгийн компанид хөрөнгө оруулалт хийсэн. Мөн саяхан “Тэнгэр” санхүүгийн нэгдэл Хятадын Шинжан Уйгарын автономит улсын Урумчи хотод бичил зээлийн компани байгуулах хөрөнгө оруулалт хийх тухай санамж бичигт гарын үсэг зураад ирлээ. Монголоос Хятадын санхүүгийн салбарт хийж буй анхны хөрөнгө оруулалт гэх үү дээ. Тэнд Тиань шан гэдэг уул байдаг нь орчуулбал “тэнгэр уул” гэсэн утгатай юм л даа. Энэ нэрээр компаниа нэрлэсэн.

**-Энэтхэг, Пакистан зэрэг оронд бичил зээлтэй холбоотой маргаан нэлээд гараад байгаа. Өндөр хүүтэй зээлээр ядуусыг дарамталдаг, хэцүү байдалд оруулдаг гээд л. Харин Монголд бичил зээлийн салбарын ирээдүй ямар байгаа вэ?**

-Уулын мод урттай богинотой гэж ярьдаг шүү дээ. Дэлхий дээр одоо 10 мянгагаруй бичил зээлийн байгууллага байгаа гэдэг. Түүнээс цөөн тооны байгууллагын үйл ажиллагаа буруу явж, өөрсдийгөө ч, харилцагчдыгаа ч хүнд байдалд оруулсан нь бий. Дээрээс нь улс төрийн нөлөө их орсон явдал ч ажиглагддаг. Зарим нэг орны улстөрчид зээлээ битгий төл, улс төлчихнө гэж ард түмэндээ уриалж байх жишээтэй. Үүний тод жишээ нь Никарагуа юм. Гэвч ерөнхийдөө бичил зээл сайн үр дагавартай гэдэг.

Энэхүрээнд дахин давтаж хэлэхэд, хүн бүр зээл авах ёсгүй шүү дээ. Зээл гэдэг өвс ногоо шиг ургаж байдаг юм биш. Зээл гэдэг нөгөө талдаа хэн нэгний хадгаламжийн мөнгө байдаг. Хадгаламжийг авъя гэсэн хүн бүрт өгч болохгүй. Банк найдвартай хадгалах үүрэг хүлээснийхээ хувьд авсан зээлээ найдвартай, ажил болгож чаддаг хүнийг л олж зээл өгөх ёстой юм. ■

Гадаад худалдаа ба валют

## “Ноён доллар”, та хаачих нь вэ?

Д.Марал

Монголд доллараар бороо орж байна. Энэ оны эхний хагас жилийн байдлаар гадаадын шууд хөрөнгө оруулалт 1.8 тэрбум ам.долларт хүрсэн нь өмнөх жилийн мөн үеэс 2.9 дахин өссөн үзүүлэлт ажээ. Хямралаас хойш Монголд орж ирэх гадаад валютын урсгал өдрөөр биш цагаар нэмэгдэх болсон. Тэрбум тэрбумаар тоологдох ийм их мөнгийг монголчууд хэзээ ч харж байгаагүй. Яг үнэнийг хэлэхэд статистик мэдээлэлд дуулдаад байгаа тэр их мөнгийг бид одоо ч гартаа бариад, тоолоод сууж байгаа юм алга. Тиймээс “ноён доллар” Монголын босгыг алхав уу үгүй юу нэг тийш алга болоод байж

таарна. Хаашаа яваад байгааг нь хамтдаа шалгаад үзье. Энэ нь сүүлийн хоёр жилийн турш суларч ирсэн ам.долларын ханш яагаад чангарах болсон, цаашид ямар байх төлөвтэйг ойлгоход хэрэг болох биз ээ.

Орц

Эхлээд Монголыг чиглэх долларын урсгал ямар хаалгаар орж ирж буйг тогтооё. Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ батлагдсанаас хойш гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдэж байгааг мэргэжилтнүүд ярьдаг. Аргагүй шүү дээ. Уурхайг ашиглалтад ▶▶



Шог зургийг А.Амарсайхан

орлуулахын тулд зөвхөн энэ жил гэхэд 2.3 тэрбум ам.доллар зарцуулахаар төлөвлөсөн тухайгаа “Айвенхоу майнз” компанийн захирал Роберт Фрийдланд дуулгасан билээ. Үүний хажуугаар гадаадын хөрөнгө оруулалттай бусад том жижиг уурхайн ажил идэвхжиж байгаа нь “ноён доллар”-ыг ашигт малтмалаар баялаг монгол нутагт даллаад байгаа юм. Товчхондоо, уул уурхайн хөрөнгө оруулалт Монголыг чиглэх гадаад валютын нэг том ундарга болжээ. Нөгөө талаас монголчууд бараагаа зараад валют авна. Тэгэхээр экспортын орлого долларын бас нэг том эх үүсвэр болж таарна. Гэтэл манай экспортын 80 гаруй хувь нь Хятад хэмээх ганцхан зах зээлд гарч байгаа юм. Монголчууд нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть тэргүүтэй ашигт малтмалаа хятадуудад өгч, оронд нь доллар авна. Нүүрсний олборлолт огцом нэмэгдсэний зэрэгцээ дэлхийн зах зээл дэх түүхий эдийн ханш өндөр байгаатай холбоотойгоор Монголын экспортын орлого энэ оны эхний найман сард 2.9 тэрбум ам.долларт хүрчээ. Энэ нь өнгөрсөн жилийн мөн үеэс 61 хувиар өссөн үзүүлэлт юм.

### Гарц

Экспортын орлого ингэтлээ нэмэгдсэн байхад Монголын гадаад худалдааны алдагдал энэ оны эхний найман сарын байдлаар жилийн

өмнөхөөсөө 7.6 дахин өсөж, 1.3 тэрбум ам.долларт хүрсэн нь гайхал төрүүлнэ. Ашигт малтмалын томоохон төслүүдийн хөрөнгө оруулалт нь бэлэн мөнгө гэхээсээ илүүтэй уул уурхайн тоног төхөөрөмж, хүнд даацын машин механизм хэлбэрээр орж ирээд байгаа аж. Өөрөөр хэлбэл, манайд орж ирсэн гадаадын шууд хөрөнгө оруулалт эргээд л гадагшаа гарчихаж байгаа юм. Үүний хажуугаар тээврийн хэрэгсэл, нефтийн бүтээгдэхүүний импорт ч суга өссөнийг хүснэгтээс харна уу. Дэлхийн зах зээлдэх газрын тосны үнэ нэмэгдэж байгаагаас Монголын хилээр орж ирэх түлш, шатахууны ханш ч өндөр байж, улмаар импортод улам их мөнгө зарцуулахад хүргэж байна. Тэгэхээр хөрөнгө оруулалт, экспортын орлого гэх хоёр хаалгаар орж ирж буй гадаад валютын урсгал импорт гэх бүүр ч том хаалгаар гараад явчихаж байгаа юм. Гадаад худалдааны алдагдал санаанд оромгүйгээр нэмэгдэж буй нь зарим талаар айдас төрүүлэх ажээ.

“Айгаад байх юм байхгүй. Дэлхийд Энэтхэг, Хятадыг эс тооцвол худалдааны алдагдалгүй орон тун цөөхөн шүү дээ. Тэгээд ч монголчууд алдагдал гэхээсээ илүү үүний үр дүнд үйлдвэрлэл хэр нэмэгдэж байгааг харах ёстой. Тоног төхөөрөмж оруулж ирэх нь үйлдвэрлэлийг сэргээж, ажлын байрыг бий болгож, эдийн засагт эергээр нөлөөлдөг юм” хэмээн Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны

газрын дэд захирал С.Жавхланбаатар учирлалаа.

### Халууны шил юу харуулна вэ?

Валютын ханшийг халууны шилтэй зүйрлэж болдог тухай Монголбанкны Валют, эдийн засгийн газрын төлбөрийн тэнцлийн статистик, судалгааны хэлтсийн захирал С.Болд тайлбарлав. Хөрөнгө оруулагчдын Монголд итгэх итгэл, макро эдийн засгийн байдал, валютын орж, гарах урсгал ямар байгааг валютын ханшаас шууд олж харж болох ажээ. 2008 оны зун 9000 ам.долларт дөхөж очоод байсан тонн зэсийн үнэ хямралаас болоод хагас жилийн дотор гурав дахин унаж, 3000 ам.доллараас ч доош орж байсныг нэхэн саная. Үүнээс болж экспортын орлого навс унахад “Найман шарга” дахь долларын ханш 1700 төгрөгт хүрсэн шүү дээ. Тэнгэрт хадсан долларын ханшийг бууруулахын тулд Монголбанк гадаад валютын дуудлага худалдаа хийх замаар арилжааны банкуудад доллар нийлүүлж, үр дүнд нь гадаад валютын нөөц асар хурдан дундарч байсан. Тэгвэл 2010 оноос хөрөнгө оруулалт, экспортын орлого нэмэгдэхэд байдал эсрэгээрээ эргэсэн юм. Монголд орж ирэх валютын урсгал эрчимжихийн хэрээр төгрөгийн ханш чангарч, улмаар Төвбанк гадаад валютын ханшийг огцом унагахгүйн төлөө зах зээлд илүүдээд байсан долларыг татаж эхэлсэн. 2009 онд дөнгөж хагас тэрбум ам.доллар байсан гадаад валютын нөөц эдүгээ 2.6 тэрбум ам.доллараас давчихаад яваагийн учир энэ буюу.

Монголбанк долларын ханш чангарахаар суллах гээд, сулрахаар чангалах гээд үзээд байдгийг Тагайхаж магадгүй. Гадаад валютын ханш чанга байвал импортын бараа өндөр үнэтэй болж, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийхээ дийлэнх хэсгийг гаднаас авдаг монголчуудын хувьд хүнд цохилт болох нь ойлгомжтой. Харин сул байвал экспортод бараа, бүтээгдэхүүнээ гаргадаг үндэсний үйлдвэрлэгчдийн орлого буурдаг. Тиймээс валютын ханш чанга ч биш, сул ч биш, тогтвортой байх нь л хамгийн чухал.

Харин хоёр жилийн турш сулрах хандлагатай байсан долларын ханш сүүлийн саруудад бага багаар чангарах

**Санхүүгийн зах зээл**

Монгол Улсад орсон шууд хөрөнгө оруулалт /салбараар/



▶ төлөвтэй болсон нь импортын хэмжээ огцом өсөж, гадаад худалдааны алдагдал тэлж байгаатай холбоотой. Гэхдээ энэ бол нэг их санаа зовохоор савлагаа биш, зах зээл өөрөө өөрийгөө аваад явж буй учраас Монголбанкнаас оролцох шаардлагагүй байгаа ажээ.

**Хаалга хаагдвал...**

Импортын хэрэглээ ихээр нэмэгдсэн энэ үед гадаад валютын орж ирэх урсгал саараад эхэлбэл Монгол Улс жинхэнэ хэцүү байдалд орж мэдэхээр байна. Ялангуяа ирэх жил сонгууль болох учраас иргэдийн гар дээр очих бэлэн мөнгөний хэмжээ улам нэмэгдэж, үр дүнд нь хэрэглээний шинжтэй импорт өсөх төлөвтэй. Оюутолгойн зэс, алтыг 2013 оноос экспортолж эхлэхээс өмнө гадаад худалдааны алдагдал нэмэгдсээр байх төлөвтэйг мэргэжилтнүүд тайлбарлаж байна.

“Аж үйлдвэрлэл, гадаад худалдаа гэдэг нь нэг зоосны хоёр тал юм. Бид юу үйлдвэрлээд, юу гаргаж байгаагаа бодох хэрэгтэй” хэмээн С.Болд онцлов. Манай экспортын 90 гаруй хувийг ердөө 10 төрлийн бараа эзэлж байгаагийн ес нь ашигт малтмал болохыг хүснэгтээс харна уу. Дэлхийн зах зээл дэх нүүрс, зэсийн үнэ 2008 оных шиг навс унах аваас манай экспортын орлого огцом буурч, гадаад валютыг даллаж буй нэг хаалга хаагдах эрсдэл бий. Энэ нь мөн хөрөнгө оруулалтын хэмжээ буурахад ч нөлөөлж мэднэ.

Гадаадын шууд хөрөнгө оруулалтын 85 хувийг мөн л уул уурхай, ашигт малтмалын салбар залгиж байгаа билээ. Гэтэл энэ салбарын хууль, эрх зүйн орчин улам л таагүй болох төлөвтэй. Ашигт малтмалын “малгай” хуульдаа өөрчлөлт оруулна гэж байгаагийн зэрэгцээ Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг ч буцаана гэх яриа гарах болсон. Гэтэл хөрөнгө оруулагчид тогтворгүй байдлыг үзэн яддаг шүү дээ.

Гадаад валютын орж, гарах урсгал зөвхөн ашигт малтмалын салбараас хамаарч байгаа нь энэ бүхнээс харагдаж байна. Түүхий эдийн үнэ унахад л “Найман шарга” дахь долларын ханш тэнгэрт хадах эрсдэл бат гэгч нь оршин тогтносоор. Энэ байдлаас яаж гарах вэ гэсэн асуултад мэргэжилтнүүд ганц л хариулт өгч байна. Экспортын барааны нэр төрлөө олшруулах хэрэгтэй! Уул уурхайн орлогоороо хөдөө аж ахуй, аялал жуулчлал зэрэг бусад салбараа дэмжиж, хөл дээр нь босгож байж л Монголд орж ирэх гадаад валютын эх үүсвэрийг олон

Экспортын барааны гүйцэтгэл /сая ам.доллараар/

Нэр төрөл	Эхний найман сар				Мөнгөн дүнгийн өөрчлөлт /хувиар
	2010		2011		
	Хэмжээ /тн. баррель/	Мөнгөн дүн	Хэмжээ /тн. баррель/	Мөнгөн дүн	
1 Чулуун нүүрс	9 698 472	484,1	11 687 078	1 154,0	138,4% ↑
2 Зэсийн баяжмал	381 082	500,0	377 322	661,5	32,3% ↑
3 Төмрийн хүдэр ба баяжмал	1 930 621	137,2	3 748 544	275,1	100,5% ↑
4 Боловсруулаагүй нефть	1 337 648	98,2	1 493 350	150,0	52,7% ↑
5 Мөнгөжөөгүй алт	3 867	132,9	2 708	125,5	-5,6% ↓
6 Ямааны угаасан ноолуур	2 864	100,1	2 433	114,9	14,9% ↑
7 Цайрын хүдэр ба баяжмал	77 823	85,5	82 655	100,3	17,3% ↑
8 Жонш, лейцит, нефелинт	254 484	40,7	265 442	62,0	52,3% ↑
9 Ямааны самнасан ноолуур	476	31,1	325	33,8	8,9% ↑
10 Молибдений хүдэр ба баяжмал	3 275,7	35,4	2 617,0	31,3	-11,8% ↓
<b>Нийт экспорт</b>	<b>1 793,6</b>		<b>2 889,0</b>		<b>61,1% ↑</b>

Гадаад худалдааны эргэлт /сая.ам доллараар/

	Эхний найман сар		%
	2010	2011	
Гадаад худалдааны нийт бараа эргэлт	3 758,8	7 080,1	88,4%
• Валютын төлбөртэй бараа	3 575,0	6 207,2	73,6%
Экспорт	1 793,6	2 889,0	61,1%
• Валютын төлбөртэй бараа	1 778,5	2 884,9	62,2%
Импорт	1 965,2	4 191,1	113,3%
• Валютын төлбөртэй бараа	1 796,5	3 322,3	84,9%
Гадаад худалдааны тэнцэл	-171,6	-1 302,1	7.6x
• Валютын төлбөртэй бараа	-18,0	-437,5	24.3x

Импортын барааны гүйцэтгэл /сая ам.доллараар/

Нэр төрөл	Эхний 8 сар		Өөрчлөлт /хувиар/
	2010	2011	
1 Хүнд механизм, тоног төхөөрөмж сэлбэг хэрэгсэл	340,9	843,7	147,5% ↑
2 Нефтийн бүтээгдэхүүн	398,0	726,9	82,6% ↑
3 Тээврийн хэрэгсэл	219,2	683,5	211,8% ↑
4 Оффисын болон гэр ахуйн тавилга, хэрэгсэл	68,0	120,5	77,2% ↑
6 Хүнсний бүтээгдэхүүн	104,9	119,8	14,2% ↑
7 Эм болон хими биологийн бүтээгдэхүүн, бордоо	38,7	54,3	40,4% ↑
5 Төмөр хийц, металл бүтээгдэхүүн	15,0	39,6	164,1% ↑
8 Төрөл бүрийн даавуу	1,1	1,3	19,1% ↑
9 Бусад гол нэрийн бүтээгдэхүүн	86,3	133,8	55,0% ↑
Бусад	693,1	1 467,8	111,8% ↑
<b>Нийт импорт</b>	<b>1 965,2</b>	<b>4 191,1</b>	<b>113,3% ↑</b>

Эх сурвалж: ГЕГ

болгох ажээ. Мөн түүхий нүүрс, зэсийн баяжмал, газрын тосоо тэр чигт нь гаргаад байх биш, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байж л “ноён доллар”-ыг эх орныхоо хөрсөнд шингээж чадах юм. Одоо бол Монголд юун хүнд машин механизм, тоног төхөөрөмж байтугай, газрын тос боловсруулах үйлдвэр ч алга байна шүү дээ. Тиймээс л хөрөнгө оруулалт, экспортын орлого гэх шошготой “ноён доллар” манайд саатаж чадахгүй, тоног төхөөрөмж, түлш, шатахуун болж хувирахын тулд гараа даллаад алга болж байна. ■



Ч.Отгочулуугийн булан

## Улаанбаатар-Санхүүгийн төв болж чадах уу?

Нийслэл хот маань уул уурхайн асар том бизнесийг дагаад ядаж л бүс нутгийн хэмжээнд санхүүгийн төв болж чадах уу? Өнөөдөр дэлхийн дэвжээнд Нью-Йорк, Лондоны биржүүд сүр хүчээ гайхуулж байна. Тэдний араас Европт Парис, Франкфурт хотууд, харин Азид Токио, Хонконг, Сингапур нэхэж явна. Эдгээр төвийн дийлэнх нь үндсэн үйл ажиллагаагаа англи хэл дээр мөрдөх бөгөөд хууль эрх зүйн хувьд англо-саксон загварт суурилсан байдаг. Төрийн зохицуулалт, дэмжлэг сайтайн зэрэгцээ Төвбанкны бие даасан байдал нь ч хамгаалагдсан, мөнгө валютын бодлого нь тодорхой дүрэмтэй, ил тод, ойлгомжтой байдаг. Банкууд нь баячуудад зориулсан хувийн банкны үйлчилгээнээс эхлээд тэтгэврийн хөгшинд жижиг хөрөнгө оруулалтын зөвлөгөө өгөх хүртэл олон төрлийн үйлчилгээг үзүүлнэ. Мэдээж цахим технологи гэх зэрэг техник хангамж сайтайн дээр ажиллагсдын ур чадвар зэгсэн. Эдгээр амжилт, давуу талын цаана тухайн хотынхоо дэлхийд өрсөлдөх чадварыг өсгөх гэсэн төрийн бодлого нуугдаж байдаг юм. Жишээ нь, Франкфурт, Хонконг зэрэг улсын зохицуулах хороод нь банк, санхүүгийн байгууллагуудаа хянаж шалгахаас гадна, сургах, шинэ стандартад төлөвшүүлэхэд онцгой анхаардаг.

Монгол Улсад маань байдал ямар байна вэ? Манай улсын зах зээлийг банк давамгайлсан хэлбэртэй гэж үздэг. 1999-2000 оны эрс шинэчлэлийг эс тооцвол төрийн зүгээс энэ салбарын талаар дорвитой бодлого явуулсан нь үгүй. Цөөн тооны хувийн банкууд маань сайн муугаараа хэлүүлэн байж бор зүрхээрээ, зах зээлийн эрэлтийн хүчээр босож ирж байна. Үүний баталгаа нь Монголд сүүлийн жилүүдэд банкны салбар эрчтэй томорч байгаа байдал юм. Тухайлбал, 2000 онд ердөө 1200 зээлдэгч 60 орчим тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байсан бол өнөөдөр 600 мянга орчим зээлдэгч 4.3 их наяд төгрөгийн зээлийг банкны сектороос авсан байна. Гэвч энэхүү толгой эргэм өндөр өсөлт нь бодит ур чадвар, бүтээмжид тулгуурласан эсэх нь тодорхойгүй. Монголын зах зээл тэлж байна. Нуурын ус нэмэгдэхэд бүх завь дээшилдгийн адилаар банкууд ч мөн санхүүгийн их эрэлтийн хүчээр томорч байна.

Монголд зээлийн хүү хэт өндөр байгаа нь харилцагчдын сэтгэл ханамжид муугаар нөлөөлдөг. Учир нь, зээлийн ерөнхий эрсдэл их, мөн эх үүсвэрийн зардал буюу хадгаламжийн хүү өндөр. Банкны ерөнхий үйл ажиллагаа болон зээлийн эргэн төлөлтийн үед маргаан гарахад банк хууль, шүүхээр хамгаалагдаж чаддаггүй. Үүнд мөн л төрийн урагшгүй үйл ажиллагаа буруутай гэж үзэж болно. Шүүхийн шийдвэр удаан гардаг, биелэлт сул, нэг барьцаа хөрөнгийг олон давхар бүртгэдэг, бүртгэлийн байгууллагууд нь гар хардаг зэрэг нь зээлийн эрсдэлийг өсгөдөг бөгөөд энэ нь эргээд өндөр хүү болж бизнес эрхлэгчдийн нуруун дээр дарамт болон очиж байна.

Зээлийн хүү өндөр байгаагийн өөр нэг шалтгаан нь хадгаламжийн хүү өндөртэй холбоотой. Төсвийн хэт

хяналтгүй тэлэлт инфляцийг өдөөх бөгөөд иргэд инфляциас өөрсдийгөө хамгаалахын тулд зөнгөөрөө хадгаламжийн өндөр хүүг хайдаг байна. Инфляци өндөр байгаад мөн л валют, мөнгөний бодлого боловсруулагчид тодорхой хэмжээнд буруутай.

Монголбанк бодлогоо хэт монополь байдлаар боловсруулдаг. УИХ тогтоол төдийхнөөр мөнгөний бодлогыг хэт ерөнхий баталж өгдөг нь Төвбанкинд дураараа дургих эрхийг нь албан ёсоор олгосноос ялгаагүй хэрэг болно. Улс төрийн томилгоогоор ирсэн Монголбанкны ерөнхийлөгч нь орчин үеийн макро эдийн засгийн уялдаа холбоог зөв ойлгодог байх зэрэг энгийн нэг шалгуурыг давдаг эсэх нь тодорхойгүй. Монголбанкны хамгийн гол капитал нь түүний нэр хүнд бөгөөд бизнес эрхлэгчдийн хүлээлтийг зөв удирдах замаар бодлогоо зөв таниулж сурталчлах ёстой. Монголбанкны ерөнхийлөгч үнэндээ найрал хөгжмийн удирдаач адил олны өмнө ил баймаар атал хааяа нэг хэрэг төвөгт нэр нь холбогджээ гэх төдийгөөс хэтрэхгүйгээр олонд танигдаж буй нь харамсалтай.

### Цаашид яах вэ?

Сонгуулиас сонгуулиар амьсгалдаг улс төрчид төрийн бодлого боловсруулж буй өнөө цагт нийслэл хот маань санхүүгийн хүчирхэг төв болж чадах нь эргэлзээтэй. Ганц найдах зүйл нь Банкуудын холбоо илүү хүчирхэг байх хэрэгтэй. Гэвч хуулиар олгогдсон эрх нь хязгаарлагдмал тул одоохондоо тэднээс их зүйл хүлээгээд хэрэггүй л болов уу.

Монголын эдийн засаг өсч, зээл хадгаламжийн зөрүү буюу маржин ихтэй байгаа энэ цаг үеийг банкууд маань зөв ашиглаж хүндээ, стандарт, этиктээ арвин хөрөнгө оруулах хэрэгтэй. Өнөөдөр том банкны нэг зээлийн эдийн засагч хэдэн тэрбумын багц хянах боломжтой хэмжээнд энэ салбар томорч байна.

Харин харилцагчид, иргэд маань яах ёстой вэ? Тухайн банкныхаа тайлан балансаас дор хаяж хүүгийн орлого-хүүгийн зарлагын зөрүү, хадгаламж зээлийн харьцаа үзүүлэлтийн зөрүүг хараад ойлгох чадвартай байх хэрэгтэй. Хэдхэн жилийн өмнө дампуурсан хоёр дунд хэмжээний банк үнэндээ зээл, хадгаламжийн хүү болон нийт хэмжээнийхээ удирдлагыг зөв хийж чадаагүй юм шүү дээ. Тайланд нь энгийн шинжилгээ хийж үзэхэд л эх үүсвэрийн илүүдэлтэй, хадгаламжиндаа хэт их хүү төлдөг нь харагдаж байсан.

Тэгэхээр иргэд маань санхүүгийн хувьд илүү боловсролтой байвал банкуудыг муудахаас нь өмнө “хашрааж” сурна. Мэдлэгтэй, шаардлага өндөртэй харилцагч бүхий банк өөрийгөө улам хөгжүүлэхийн тулд хичээж таарна.

Улаанбаатар маань бүс нутагтаа томд тооцогдох банк санхүүгийн том төв болж чадах уу? гэсэн асуултыг дахин тавья. Чадна. Иргэд маань боловсорч, төрөө шахаж шаарддаг, төр нь дотоодын банкуудаа дарамталж биш, харин дэмждэг сэтгэлгээтэй болсон цагт бид чадна. ■



Фотог Э.Зоригт

Институционал хөрөнгө оруулалт

## Нэрийн данс хоосон биш, хувьцаатай байг

Д.Мөнхчимэг

Манай нэг найзын нүүрэнд мишээл тодорч, нүдэнд нь оч гэрэлтсээр орж ирэв. “Хөгшөөн юу гээч, бид нарын ирээдүйд авах тэтгэврийн мөнгө аймаар өндөр хувиар өсдөг юм байна ш дээ. Бас нэг цахим хуудсаар ороод нэрийн дансандаа хэдий хэмжээний мөнгө байгааг тооцож болдог болчихож” гээд, <http://www.ndaatgal.mn/ndans/> гэсэн хаягийг даруйхан нээж үзүүлэв. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлөөс баталсны дагуу тэтгэврийн даатгалын нэрийн дансны орлогод 2009 онд 29.8 хувь, 2010 онд 28.3 хувиар хүү тооцох болсон тухай тэрбээр мэдээд, бөөн баяр болжээ.

Тэгээд бид хоёр хамт суугаад, тэтгэврийн даатгалын шимтгэлд хэдий хэмжээний мөнгө төлснөө бодож үзэв. Ажил хийж буй монгол хүн бүр гэртээ авчрах орлогынхоо 20 хувийг сар бүр нийгмийн даатгалын шимтгэлд өгдөг. Энэ хураамжийн нэг хувийг тэтгэмжид, дөрвөн хувийг эрүүл мэндийн даатгалд, нэг хувийг ажилгүйдлийн даатгалд, үлдсэн 14 хувийг тэтгэврийн даатгалд суутгаж байгаа юм. Хувийн хэвшилд дөрөв дэх жилдээ ажиллаж буй найз маань анх сардаа 350 мянган төгрөгийн цалин авч байсан бол эдүгээ 550 гаруй мянган төгрөг авч байгаа юм.

Тэгээд энэ хугацаанд төлсөн нийгмийн даатгалын шимтгэл нь 4.5 сая төгрөгт хүрснийг мэдээд баян хүн болчихсон юм шиг л хөөрч байхыг нь яана. Найзаасаа би хэдэн асуулт асуулаа.

**-Дөрөвхөн жилийн хугацаанд чиний төлсөн шимтгэл 4.5 сая төгрөгт хүрчихсэн байна шүү дээ. Гэтэл 55 нас хүрч, тэтгэвэр авахын тулд чи дахиад 30 жил ажиллах ёстой. Энэ хугацаанд цалин чинь байнга өсөх нь лавтай, чи нийгмийн даатгалын шимтгэлд хэр их мөнгө өгөхөө төсөөлж байна уу?**

-Мэдэхгүй ээ, лав л хэдэн зуун сая төгрөгт хүрэх юм шиг байна.

**-Тэгээд чи 34 жилийн турш нийгмийн даатгалын шимтгэл төлчихөөд, 55 хүрэлгүй нас барчих юм бол “хохь чинь” болно гэвэл яах вэ? Төр чиний гэр бүлд “оршуулгын зардал” гэж 300 мянган төгрөг өгчихөөд л буруу харна гээд бод.**

-Би 55 нас хүрэхээсээ өмнө тэтгэвэртээ гарч болохгүй гэж үү?

**-Өнөөгийн хуулиар бол даатгуулагч 20-иос доошгүй жилийн хугацаанд тасралтгүй шимтгэл төлснөөр л нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсдэг юм.**

**10-20 жил төлсөн тохиолдолд хувь тэнцүүлэх тэтгэмж авна. Хэрвээ есөн жил төлчихөөд, амьдралын эрхээр гэртээ суувал... Уучлаарай, чи хэзээ ч тэтгэвэр авч чадахгүй.**

-Тэгвэл би шимтгэлд ийм их мөнгө төлж байгаа юм чинь тэтгэвэр маань ядахдаа өндөр байна биз дээ?

**-Чи 20 жилийн турш шимтгэл төлж байж цалингийнхаа 45 хувьтай тэнцэх хэмжээний тэтгэвэр авна. 30 жил бол 60 хувь, 40 жил бол 75 хувьтай дүйцнэ. Тэр хугацаанд инфляци хэрхэн өсөх, чиний авах тэтгэвэр амьдралд чинь хүрэлцэх эсэх хэнд ч падлийгүй.**

-Тэгвэл нэрийн дансанд байгаа үлдэгдлийг шалгах ямар хэрэг байгаа юм бэ? Нэгэнт л би тэр мөнгийг авч чадахгүй юм бол ямар ч утга алга байна шүү дээ (бөөн бухимдал болов).

**-Яг зөв, тиймээс л өнөөгийн нийгмийн даатгалын тогтолцоог орвонгоор нь эргүүлэх хэрэгтэй байгаа юм.**

Ингээд би тэтгэврийн сангийн мөнгийг Монголд юунд зарцуулдаг, бусад оронд ямар менежмент хийдэг тухай чадахынхаа хэрээр судалж, олон ч хүнтэй уулзсаныхаа хувьд найздаа бяцхаан лекц уншиж өгөхөөр шийдлээ.

### Төсвийн цоорхой нөхөх нь

Монгол Улс “залуучуудын орон” гэсэн сайхан тодотголтой. Хүн ам зүйн хувьд ид хөдөлмөрийн насандаа яваа буюу 20-54 насны иргэд жин дарж байгаа бол 55-аас дээш насныхан харьцангуй цөөн байгааг графикаас харна уу. “Залуучуудын орон” гэх сайхан нэрийг нөгөө талаас нь авч үзвэл монголчуудын дундаж наслалт бага, насан туршдаа морь мал мэт зүтгэчихээд тэтгэвэртээ ч гарч чадалгүй бурхан болооч нь олон, тэтгэвэр авлаа ч хүртэж гавьдаггүй нь харагдана. Үүнийг яагаад нуршаад байна вэ гэхээр өнөөгийн тогтолцоогоор төр шимтгэл төлж буй хүмүүсийн мөнгийг өсгөлгүй, өмнөх үеийнхэнд нь тэтгэвэр болгоод өгчихөж байгаа юм.

Үндэсний статистикийн хорооны мэдээллээс үзэхэд эдүгээ 557.6 мянган иргэн нийгмийн даатгалын шимтгэл төлж байхад нийгмийн халамжийн тэтгэвэрт ердөө 56.2 мянган хүн хамрагдсан байна. Ийм олон хүнээс авсан шимтгэлээ цөөн хүнд олгож байгаа Тэтгэврийн болон тэтгэмжийн сан одоо ч алдагдалтай болоод байгааг Сангийн яамныхан анхааруулж, нийгмийн даатгалын шимтгэлийн ▶

▶ хэмжээг нэмэх хэрэгтэй гэсэн санал гаргаад буйг юу гэж ойлгох вэ? Тэгвэл одоо шимтгэл төлж, тэтгэврийн хөгшчүүлийг “тэжээж” байгаа хагас сая хүн 20-30 жилийн дараа тэтгэвэртээ гараад ирэхээр яах юм бол? Тэдэнд өгөх мөнгө Тэтгэврийн санд үлдэх үү? Ер нь Тэтгэврийн сангийн мөнгө хаана яваад байгаа юм бэ? мэтийн олон асуулт шил шилээ даран хөврөх нь лавтай.

2002 онд Монгол Улсын Нэгдсэн төсвийн тухай хууль батлагдсан. Ингэхдээ нийгмийн даатгалын шимтгэлийн хөрөнгийг Нэгдсэн төсвийн нэгэн бүрэлдэхүүн гэж тусгаснаас болж монголчуудын ирээдүйн тэтгэвэр “Татварын орлого” гэсэн ангилалд багтаад, төсвийн цоорхой нөхөх үүрэг гүйцэтгэдэг болчихоод буй. Засгийн газар тэтгэврийн сангаас 2.1 их наяд төгрөгийг та бидэнд мэдэгдэлгүйгээр “хүүгүй зээл” болгон ашигласныг Монголын үйлдвэрчний эвлэлийн холбоо гурван ч жилийн өмнө илрүүлсэн.

Гэтэл Нийгмийн даатгалын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн хоёр дахь заалтад “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно” гэсэн байдаг юм шүү дээ. Засгийн газар энэ заалтыг зөрчсөөр ирсэн бөгөөд цаашид ч үл тоомсорлох янзтай. Энэ байдлыг өөрчлөхгүй бол иргэдийн нэрийн дансан дахь мөнгө төсвийн цоорхой нөхсөөр, эргээд тэтгэвэр авах гэхээр хоосорсон байх аюултай юм.

**Тэтгэврийн сангийн мөнгийг хэрхэн арвижуулдаг вэ?**

Тэтгэврийн сан 550 тэрбум ам.долларын хөрөнгөтэй бөгөөд нийгмийн даатгалын шимтгэл төлөгчдийнхөө мөнгийг олон улсын хөрөнгийн зах зээлд эргэлдүүлэх замаар өсгөсөөр иржээ. Зөвхөн Норвеги ч биш, Япон, Канад, Сингапур, Малайз, Австрали, Франц, Швед, Чили зэрэг дэлхийн олон оронд төрийн болон хувийн тэтгэврийн сангийн мөнгийг хөрөнгө оруулалтын урт хугацааны эх үүсвэр болгон ашигладаг. Ингэснээр иргэдийнхээ ирээдүйн тэтгэврийн хэмжээг өсгөж, амьдралын баталгааг хангаж өгч байгаа юм. “Towers Watson” компанийн хийсэн судалгаанаас үзэхэд дэлхийн томоохон 300 тэтгэврийн сан 2010 онд 12.5 их наяд ам.доллар эзэмшиж байна гэжээ.

Соёлтой орнуудын иргэд бол насны


эцэст хэрэглэх хөрөнгийг нь яаж өсгөж байгаа талаарх мэдээллийг тогтмол авч, нийгмийн даатгалын хуримтлалаа өвдөж зовбол хэрэглэх баталгаа гэж үзэн, сэтгэлтэнүүн ажиллаж, амьдардаг тухай эдийн засагч Д.Жаргалсайхан бичиж байсан. Харин яаж өсгөдөг нь монголчуудын хувьд их сонин байх болов уу.

“Даатгал, тэтгэврийн сангууд гадаадад бол хөрөнгийн зах зээлийн хамгийн том тоглогчид байдаг шүү дээ” хэмээн Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газрын захирал Д.Болдбаатар ярьж байсан. 2011 онд мөнгөний талаар төрөөс баримтлах үндсэн чиглэлд “Урт хугацааны санхүүгийн эх үсвэрийг бий болгох арга хэмжээ авна” хэмээн заасан байдаг. Урт хугацааны санхүүгийн эх үүсвэр нь хөрөнгийн зах зээл, тэтгэврийн сангуудаас бий болдог. Энэ хоёр нь бие биетэйгээ нягт уялдаа холбоотой байж гэмээнэ аль аль талдаа ашигтай байж чаддаг аж. Тодруулбал, хөрөнгө оруулалт хийдэг санхүүгийн менежерүүд тэтгэврийн сангийн хөрөнгийг өсгөдөг байна. Яаж тэр вэ? Мэдээж Засгийн газрын бонд, эсвэл хувьцаа худалдаж авна. Ингэснээр нэг талдаа сангийн хөрөнгө арвижиж, нийгмийн даатгалын шимтгэл төлж байгаа хүмүүсийн мөнгө өснө. Нөгөө талаас хөрөнгийн зах зээл хөгжинө. Гэхдээ ингэж нэг сумаар хоёр туулай харвахын тулд мэдээж маш сайн менежмент хэрэгтэй.

**Айлаас гуйхаар авдраа уудал**

Өнөөдөр монгол хүн бүр “Эрдэнэс Тавантолгой”-н 536 ширхэг хувьцааг эзэмшиж буй. Гэхдээ гурван монгол хүний нэг нь нэн ядуугийн ангилалд багтаж байгаа өнөө үед үнэгүй авсан хувьцаагаа хүмүүс хамгийн анхны боломжоор зарж, хоногийн хоолоо залгуулах магадлал тун ч өндөр байгааг учир мэдэх хүмүүс анхааруулсаар. “Эрдэнэс Тавантолгой”-н хувьцааг олон улсын хөрөнгийн зах зээлд гаргаж, зах зээлийн үнэ цэнэ нь тогтох үед арилжаа нээлттэй болно гээд байгаа шүү дээ. Тэр үед манай хөрөнгийн бирж дэх гадаадын хөрөнгө оруулагчдын тоо улам л өссөн байх нь дамжиггүй. Ингээд хувьцааны урсгал гадагш чиглэх аюултайг Монголын хөрөнгийн биржийн ТУЗ-ийн дарга Б.Болд тэргүүтэй олон мэргэжилтэн сануулж байгаа юм.

“Одоо ч Монголын хөрөнгийн биржид байгаа нийт хувьцааны ихэнхийг гадаадын хөрөнгө оруулагчид авч байна. Монголчуудад боломж



байгаа ч түүнийгээ ашигладаггүй нь харамсалтай. Тэтгэврийн сангийн мөнгийг арвижуулах үүднээс хөрөнгийн зах зээлд оруулах учиртай” хэмээн Санхүүгийн зах зээлийн холбооны ерөнхийлөгч Ө.Ганзориг тэмдэглэж байв. Үнэхээр 2010 онд шинээр нээлгэсэн дансыг ажиглавал монгол иргэдийнх 1.9 хувиар өссөн байхад гадаад иргэдийн данс 34 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй байлаа. Энэ нь Монголын хөрөнгийн зах зээлийг гаднын байгууллага, иргэд сонирхож эхэлснийг харуулна хэмээн Үнэт цаасны газрын 2010 оны ажлын тайланд тэмдэглэжээ.

Лондоны хөрөнгийн биржийн хийх шинэчлэлийн үр дүнд манай хөрөнгийн зах зээл гаднынхны сонирхлыг илүү ихээр татах нь ойлгомжтой. Гэтэл гэнэт дэлхийн зах зээл дэх нүүрс, зэсийн үнэ навс унадаг ч юм уу, ямар нэгэн байдлаар Монгол Улс моодноос гарвал гаднынхан бэлэн мөнгөө тоолж аваад л буцна. Манай бирж үхмэл байдалдаа эргээд л орно. Ийм байдалд л орохгүйн тулд дотоодын институционал хөрөнгө оруулагчдыг бий болгох ёстойг мэргэжилтнүүд тайлбарлаж буй. Бэл бэнчин муутай монголчуудын хувьд бэлэн ашиглаад урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэр болгочих хуримтлал гэвэл зөвхөн Тэтгэврийн сан байгааг мэргэжилтнүүд ярьдаг.

“Урт хугацааны хөрөнгө оруулалтын эх үүсвэр байхгүй өнөө үед бага ч гэсэн байгаа боломжоо ашиглаж чадахгүй байгаа нь эмгэнэлтэй л хэрэг” хэмээн “Тэнгэр” санхүүгийн нэгдлийн гүйцэтгэх захирал М.Болд учирласан билээ. “Айлаас гуйхаар авдраа уудал” хэмээн монголчууд ярьдагчлан Тэтгэврийн сангийн мөнгөний зарим хэсгийг хөрөнгийн зах зээлд эргэлдүүлэх нь Монголын хөрөнгийн биржийн хөгжилд ч онцгой нэмэртэй билээ. Нөгөө талаас монголчуудын ирээдүйд авах тэтгэврийн хэмжээг жинхэнэ утгаар нь өсгөж чадна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгчид ▶

► хүсвэл нэрийн дансаа барьцаанд тавьж, банкнаас зээл авч болдог болно. Тэтгэвэр авч байгаад нас барлаа гэхэд нэрийн дансан дахь үлдэгдэл нь үр хүүхдэд нь өвлөгддөг болно. Ихэнх оронд ийм л байдаг. Харин хэзээ ийм цаг Монголд ирж, иргэд нэрийн данснаасаа тэтгэвэр авахыг хэн ч хэлж мэдэхгүй. Яагаад гэвэл Тэтгэврийн сангийн мөнгийг өсгөх бус, үрэн таран хийхэд л төр, засаг анхаарч байна. Насан туршийн хуримтлалаа нэгдсэн

төсвийн татварын орлого болгох биш, нэрийн дансандаа байлгаж, ирээдүйн баталгаагаа хангахын тулд монголчууд одооноос санаа тавих хэрэгтэй. Эрүүл саруул, эрч хүчтэй байхдаа шимтгэл төлж, хуримтлал үүсгэсэн бол эргээд түүнийгээ хэцүү үедээ захиран зарцуулах эрхтэй байх ёстой. Харин буцаан авах үед та бидний нэрийн дансан дахь мөнгө хоргодсон биш, хоосорсон биш, хэд дахин нэмэгдсэн байх учиртай. ■

харьцуулахад чамлалттай юм. Доор харуулсан S-муруй дээр дэлхийн улс орнуудыг ДНБ-д даатгалын салбарын эзлэх хувиар нь жагсаасан байгаа. Монгол Улсын даатгалын салбарын орлого ДНБ-ий ердөө 0.38 хувьтай тэнцүү буюу нэлээд хойгуур жагссан байгааг анзаарч байгаа байх. Энэ үзүүлэлтээрээ S-муруй дээр Underdeveloped market буюу буурай хөгжилтэй хэсэгт багтаж байна. Дэлхий дахин Монголыг маань хөгжиж буй (emerging market) зах зээл гэж үздэг ба гадаадын мэргэжилтнүүд Монголын даатгалын салбарыг маш сул хөгжилтэй гэж дүгнэдэг. Энэ салбарыг хөгжүүлэхийн тулд даатгалын компаниуд өөрсдөө тэлж ажиллахаас гадна ажиллах тодорхой, цогц эрх зүйн орчныг нь төрөөс ойрын хугацаанд бүрдүүлж өгөх шаардлагатай.


Одоо даатгалын салбарын өсөлт, хөгжилд нөлөөлөх боломжуудын талаар авч үзье. Юуны өмнө одоо

Шинжээч бичиж байна

## Даатгалын салбарын шинэ боломжууд

Б.Одмаа

Эдийн засаг, санхүүгийн чиглэлээр дотоод, гадаадад мэргэжил эзэмшсэн, бие даасан шинжээч нар "Purplebook.mn" гэсэн вэб сайт ажиллуулж эхэлжээ. Тэдний энэхүү үйл ажиллагаа нь бизнесмэн, менежер, эдийн засагч, түшмэлүүдэд зөв шийдвэр гаргах, эх орныхоо хөгжил, үйл ажиллагаагаа зөв удирдан залахад шаардлагатай мэдээллийг тогтмол хүргэх зорилготой аж. "Mongolian Economy" сэтгүүл тэдний үйл ажиллагааг дэмжиж, зорилго нэгтэй хамтарч ажиллахаар боллоо. Тиймээс тус сайтад нийтлэл бичдэг шинжээч нарын бүтээлээс "Шинжээч бичиж байна" булангаараа хүргэж байна.



Анх улсын ганцхан компанитай үүсч байсан даатгалын салбар өдгөө олон тоглогчтой томоохон салбаруудын нэг болж хөгжиж байгаа. Тухайлбал, даатгалын компанийн тоо 17-д хүрсэн, хураамжийн орлого энэ оны эхний улиралд л гэхэд 8.9 тэрбум төгрөг, салбарын компаниудын цэвэр ашиг хоёр тэрбум төгрөг болсон байна.

Зах зээлийн хувьд авч үзвэл Монголын даатгалын зах зээл нүд орой дээр гаргам 77 хувийн өсөлттэй байгаа нь Европ, Америкийн хөгжингүй зах зээлийг бодвол одоогоор залуу, өсөлтийн шатандаа явж байгаатай холбоотой болов уу. Санхүүгийн

зохицуулах хорооны мэдээний дагуу, Монголд нийт 600,000 хувь хүн даатгуулсан гэх боловч, Монгол Улсын нийт татвар төлдөг иргэдийн тоо 500,000 хүрэхтэй үгүйтэй байхад энэ тоо их хэмжээгээр давхцсан, даатгалын компаниуд өөрсдийн харилцагчдыг зөв тоолж чаддаггүйг харуулж байна.

Даатгалын үйлчилгээ хүрэлцдэггүй, хүртээмж муутай байгааг ДНБ-д эзлэх даатгалын хураамжийн орлогын хувиас харж болохоор байна. 2010 оны байдлаар энэ үзүүлэлт 0.4 хувьд ч хүрэхгүй байгаа нь олон улсын дундаж жишиг болох 5-8 хувьтай

байгаа бүтээгдэхүүний хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлж болно, нөгөөтэйгүүр шинэ даатгалын бүтээгдэхүүн нэвтрүүлж зах зээлийн багтаамжийг нь тэлэх боломжтой. Тухайлбал, 2010 оны байдлаар нийт 75 мянган жолооч хариуцлагын даатгал хийлгэсэн нь жолооны үнэмлэхтэй хүмүүсийн дөнгөж 10 хувь нь байгаа юм. Хэрэв Жолоочийн заавал хариуцлагын даатгалын хуулийг цаг алдалгүй баталсан тохиолдолд энэ нь зах зээлийн хөгжилд чухал алхам болох юм.

Бизнес, нийгмийн харилцаа хөгжиж, эдийн засгийн өсөлт эрчимтэй явагдаж байгаа өнөө үед шинэ төрлийн ►►

▶ даатгалын бүтээгдэхүүн эрэлт ч өсөх хандлагатай байгаа юм. Үүнд үүргийн, хариуцлагын, улс төрийн эрсдэл, тэтгэврийн гэх мэт олон төрлийн даатгалыг нэрлэж болох байна. Даатгалын зах зээл асар их нөөц боломж агуулж байгаа ч түүнийг хэрэгжүүлэхийн тулд Монголын даатгалын компаниуд санхүүгийн чадавх сайтай, итгэл найдвартай байх

ёстой. Гадаад орнуудад бол томоохон даатгалын компаниудын дийлэнх нь ХК хэлбэртэй байдаг байхад Монголын тухайд биржид бүртгэлтэй даатгалын компани одоогоор алга байна. Тиймээс даатгалын компаниуд одооноос нэгдэн нийлэх, удирдлага менежментээ сайжруулах, санхүүгийн чадавхиа нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах ёстой болов уу. ■

Хөгжлийн банк байна. Бодлогын банк ч гэж нэрлэдэг. Манайхөн эрчимтэй л ажилламаар байна” гэсэн юм.

Бондын зах зээлд Монгол Улс 1996 онд анх хөл тавьсан. Бонд гэдэг нэгэн төрлийн өрийн бичиг. Банкны зээлээс ялгаатай нь өөр хүнд худалдах боломж нээлттэй. Өөрөөр хэлбэл, мөнгө зээлж буй хэрэг л дээ. Манай улс 1996 оноос эхлэн Засгийн газраас төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор хямдруулсан бонд арилжаалж эхэлсэн хэдий ч туршлагажих хэмжээний дорвитой зүйл болж чадаагүй. 1996-2008 онд нийтдээ 170.2 тэрбум төгрөгийн л бонд гаргасан байдаг. Тиймээс ч өнөөдрийг хүртэл иргэдийн дунд бондын талаарх ойлголт тун ядмаг байсаар. 12 жилийн хугацаанд дээрх хэмжээний бонд гаргаж байсан Монгол Улс 800 тэрбум төгрөгийн бонд арилжаална гэхээр гадаадынханд нэг талаараа чамлалтай ч нөгөө талаараа дэндүү гэнэн санагдах биз.

Санхүүгийн зах зээлд банкны систем дангаар ноёрхож буй энэ үед арилжааны банкууд бондын зах зээлд төвийн тоглогч хэвээр байх нь ойлгомжтой. Тэд л хөдлөхгүй бол манайд бонд борлохгүй тийш хандана. Гол нь төрөөрөө дэнчин тавьсан бондын арилжааг сохроор шүтэх байдал сүүлийн үед гаарлаа. Бондоор хөрөнгө босгох хялбар санагдсан нь гацаанд орж, зарим төрийн түшээг гансрахад хүргэсэн. Магадгүй, манайд 800 тэрбум төгрөгийн бонд ахадсан тоо байж мэдэх юм. Дотоодын ▶

## Бонд

# Хөгжлийн банкны бондод хөл ургаад, хилийн дээс алхаасай

Б.Баяртогтох

Монголын өрх бүрт “Таван толгойн” хувьцааны тухай халуун яриа өрнөж байхад Төрийн ордонд бондын талаарх мэтгэлцээн үргэлжилсээр... Харин бондын үр дүн богино хугацаандаа бүрхэг байсаар. Цаашид ч харанхуй таамаг хөвөрсөөр байна. Түүхэндээ Засгийн газар тэнэг ч гэмээр магадгүй тэмдэглүүштэй ч гэмээр шийдвэр гаргасан нь Хөгжлийн банкны 800 тэрбум төгрөгийн бонд гэлцэх боллоо. ДНБ-ийхээ бараг 10 гаруй хувьтай тэнцэх хөрөнгийг зээлээр аваад, дэд бүтцийн салбартаа хөрөнгө оруулах зоримог алхмыг төр хийсэн нь үнэн ч, амжилттай арилжаалах нь “худал” болж хувирлаа гэх болов. Хөгжлийн банкны бондын төлбөр нь жилийн 4.75-7.0 хүртэл хувийн хүүтэй байхаар төлөвлөж байгаа ажээ. Ийм өндөр хүүтэй бондыг лавтай арилжааны банк болоод аж ахуйн нэгж сонирхохгүй л болов уу гэдэгт эдийн засагчид эргэлзээд эхэлчихэж.

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор, профессор Л.Оюун “Засгийн газрын баталгаат бондыг олон улсын бондын зах зээлд гаргаж болно. Амжилттай хөрөнгө босгосон жишээ цөөнгүй. Худалдаа хөгжлийн банк гэхэд л хоёр удаа гадаадын зах зээлд бонд гаргасан. Манай улс дэлхий нийтийн сонирхлын цэг болоод байна. Тиймээс Засгийн газраар баталгаажсан бондыг

гадаадад арилжаалбал богино хугацаанд мөнгө босгож болно” гэв. Тэрбээр бараг хагас жилийн өмнө үүдээ нээсэн Хөгжлийн банкны үйл ажиллагаа удаашралтай байгаад шүүмжлэлтэй хандсан. “Энэ банкны улс орны хөгжилд гүйцэтгэх үүрэг, хувь нэмэр маш их. Манайх шиг шилжиж буй сул хөгжилтэй оронд Хөгжлийн банк эдийн засагт чухал бодлогын үүрэг гүйцэтгэдэг. Ийм жишгээр олон орон хөл дээрээ боссон. БНСУ-ын Хөгжлийн банк зөв бодлого явуулсан учраас улсынхаа хөгжлийг түргэсгэж чадсан. Хятадад гэхэд гурван том



Хөрөнгийн биржээр арилжаалж буй Сангийн яамны 300 тэрбум төгрөгийн бондоо арилжааны хэдэн банкиндаа шахаад ч болов хөрөнгө босгохоор мэрийж байна. Харин 800 тэрбум төгрөгийн бондоо одоо яах вэ? Дотоодын зах зээлд шингэхгүй, нэр төдий 800 тэрбум төгрөгийн бонд хэзээ хилийн дээс алхах бол. Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооны дарга, Хөгжлийн банкны ТУЗ-ын дарга асан Ч.Хашчулуун “Хөгжлийн банкны санхүүжилтийн асуудлыг хүмүүс яагаад удаагаад байгаа юм бэ гэж багагүй шүүмжилдэг. Гэтэл Хөгжлийн банк маань саяхан байгуулагдсан. Нэг үгээр хэлбэл, зургаан сартай хүүхдээс 600 сая ам.доллар нэхээд байгаатай адил зүйл болох гээд байна. Гэхдээ асуудлыг хурдан шийдэхийн төлөө ажиллаж байгаа. Ер нь зах зээлд дээр санхүүжилт, мөнгө босгох ажилд наанадаж 2-3 сарын хугацаа орж байна” хэмээн ярьжээ. Хөлд орно, удахгүй хөлд орно гэж Хөгжлийн банкаа дээр доргүй эрхлүүлээ шүү дээ. Яасан эрхэлж ханадаггүй, байгуулагдаж чаддаггүй Хөгжлийн банк вэ.

Бонд тойрсон асуудал ихээхэн төвөгтэй болж хувирлаа. Муйхар зан мухардалд хүргэдэг гэдэг. “Хөгжлийн банк бонд гаргах гэж байгааг тэнэглэл гэж л ойлгож байна даа” хэмээн УИХ-ын гишүүн Ж.Амаржаргал Ерөнхий сайд С.Батболдод хандан Хөгжлийн банкны асуудлаар асуулга тавьжээ. Асуулгадаа “Монгол Улс нь биш Хөгжлийн банк нь бонд гаргаад байгааг ойлгохгүй байна. Уг нь Засгийн газар нь гаргаж байж олон улсын зах зээл дээр Монголын үнэ цэнэ тогтож чадна” хэмээн тэмдэглэсэн байна. Мөн тэрбээр “Засгийн газрын үнэт цаасны суурь хүү олон улсын зах зээлд тогтож амжаагүй энэ үед дөнгөж байгуулагдсан Хөгжлийн банкнаас хаалттай хэлбэрээр бонд гаргах нь хэр зохистой вэ. Дэлхий дээр Засгийн газрын бондоос өмнө үнэт цаас гаргаж жишиг хүү тогтоож байсан хөгжлийн байгууллагуудын туршлага бий юу” гэдэгт хариулт авахыг хүсчээ.

Манай улсын Засгийн газар түүхэндээ 263 тэрбум төгрөгийн бондыг зөвхөн дотоодын зах зээлд гаргасан туршлагатай. Бонд гаргах чиглэлээр мэргэшсэн боловсон хүчин ч дутмаг байна. Өөрөөр хэлбэл, шахаанд орсон Хөгжлийн банкинд 800 тэрбум төгрөгийн бонд нь шантааж болж байх шиг ээ.

Хөгжлийн банкны бондыг анх хаалттай хэлбэрээр арилжаалахаар төлөвлөснөө сүүлдээ “хаалттай болон нээлттэй” хэлбэрээр болгон өөрчилжээ. Ер нь энэхүү байгуулагдаж дуусдаггүй сайхан нэртэй банкны маань үйл ажиллагаа, бонд арилжаалах байдал нь ч учир битүүлэг байгаа талаар мэргэжлийн хүмүүс ярьж байна. Энэ байдлаараа дэлхийн санхүүгийн зах зээл дээр Монголоор овоглосон Хөгжлийн банкны бонд мөддөө гарахгүй нь бололтой. Хоног сар алдах тусам шинэ бүтээн байгуулалтын хөтөлбөрүүд хойш суух нь. Хөгжил ч биднээс алсрах нь мэдээж. Дэлхийн банкны тэргүүлэх эдийн засагч Рожер ван дэн Бринк “Хөгжлийн банкны бондын тооцоо ч алга” хэмээн халаглан ярьсан удаатай. Бонд гарахад наад зах нь нэг жил шаарддагийг Дэлхийн банкныхан хэлж байна. Тухайн төслийн техник, эдийн засгийн үндэслэл, ашиг гээд олон зүйлийг тооцох учиртайг ч бидэнд санууллаа. “Бонд гаргагч төлбөрийн чадваргүй болох, дампуурах эрсдэл бий. Барьцаанд тавьсан хөрөнгийг худалдан борлуулж, бондын төлбөрийг барагдуулахаар хуулинд тусгасан нь эрсдэлээс хамгаалж буй нэг арга юм” гэж Монголын хөрөнгийн зах зээлийн тэргүүлэгч компани болох “Би Ди Сек”-ийн Хөрөнгө оруулалтын албаны менежер Ц.Цог ярьсан юм.

Иргэд, бусад хөрөнгө оруулагчдын хувьд эрсдэл багатай санхүүгийн хэрэгсэл болох Засгийн газрын хямдруулсан бондыг илүү сонирхдог хэмээн хөрөнгийн захын мэргэжилтэн тайлбарлаж байв. Одоогоор хөрөнгийн биржид 120 гаруй тэрбум төгрөгийн бонд арилжаалаад байна. Бондын захын гол худалдан авагч нь арилжааны банкууд. Тэднийг бодлогын хүүгээр дэмжигч нь Монголбанк. Хэрвээ банкууд бондын арилжаанд оролцохгүй тохиолдолд тухайн өдрийн арилжаа саатах эрсдэлтэй. Гадаадын хөрөнгө оруулагчид 300 тэрбум төгрөгийн бондын арилжаанд олонх бус цөөнхийн байр сууриар оролцож байна. Манайхан бондын зах зээлдээ хэр дүн шинжилгээ хийсэн юм бол. Бонд худалдан авах эрэлт манайд байсан ч юм уу, үгүй ч юм уу.

Эдийн засагч Д.Жаргалсайхан “Аль нэг улсын Засгийн газар 10-30 жилийн хугацаатай өрийн бичгээ гадаадын зах зээлд гаргахыг бие даасан улсын өр

гэдэг. Хувь хүн биш, хувийн компани биш, өөрөө татвар цуглуулж чаддаг Засгийн газар нь бонд гаргадаг учир хөрөнгө оруулагчид өрийн бичгийг нь худалдан авч хугацааны эцэст гаргасан хөрөнгөө хүүгийн хамт эргүүлэн авдаг. Энэ хөрөнгө оруулагчид болон хувь хүмүүс, компаниуд, хөрөнгийн сангууд, өөр улсын Засгийн газар зэрэг санхүүгийн зах зээлийн гол тоглогчид. Засгийн газар нь иймд бонд гаргаж, олон улсын санхүүгийн далайд гарч чадвал тухайн орны хувийн компаниуд ч дагаад гарах боломж нээгддэг” хэмээн “Бонд-далайн гарц” нийтлэлдээ өгүүлжээ.

Бондоо хэрхэн арилжаалах талаар ур ухаанаа уралдуулах зуур саяхан Хөгжлийн банкны ТУЗ-ийн даргыг сольж, Сангийн яамны Төсвийн бодлогын газрын дарга Б.Батжаргалыг томиллоо. ТУЗ-ийн даргын томилгоог бонд арилжаалах үйл явцтай холбоотой болов уу гэж таамаглаж байхад нэг хэсэг нь үүнийг улстөржүүлэх болов. “Уг нь Хөгжлийн банкны 150 тэрбум төгрөгийн бондыг дотоодод гаргахаар энэ оны зургадугаар сард ТУЗ-ийн хурлаар шийдвэрлэсэн боловч Сангийн яамны 300 тэрбум төгрөгийн бондыг зах зээлд гаргаж, хүүг нь 7-11 хувиар тогтоосон нь Хөгжлийн банкны бондыг дотоодод арилжаалах боломжийг үлэмж багасгасан” хэмээн ҮХШХ-ны дарга Ч. Хашчулуун учирлалаа. Хуулиараа Хөгжлийн банкны бондыг гаргахад зээлийн хүү нь зах зээлийн хүүгээс доогуур байх ёстой ажээ. Гэтэл Хөгжлийн банкны бондын хүүнээс Сангийн яамны бонд, Төв банкны үнэт цаасны хүү өндөр байгаагаас болж хуультай харшлах болж. Иймээс гадаадын зах зээлээс санхүүжилтийн хөрөнгө татах шаардлагатай болсон хэмээн тэрбээр тайлбарлалаа. Өөрөөр хэлбэл, дотоодын зах зээлд байгаа илүүдэл хөрөнгийн үнэ нь Хөгжлийн банкны бондын хүүгээс илүү өндөр байгаа учраас хөрөнгө дайчлахын тулд олон улсын зах зээлд илүү хямд өртгөөр үйл ажиллагаагаа явуулах нь оновчтой аж.

Сангийн яамны 300 тэрбум төгрөгийн бонд, Хөгжлийн банкны гаргах 800 тэрбум бонд нийлээд манай дотоодын зах зээлийн санхүүгийн “тогооноос” халих учраас Засгийн газраас гадаадаас хөрөнгө босгох зөвшөөрлийг Хөгжлийн банкинд ▶▶

олгосон юм байна. Харамсалтай нь Хөгжлийн банк гадаадаас хөрөнгө босгох асуудалд алгуурласаар...

Хэрэв бондоо гадаад зах зээлд энэ ондоо амжаад гаргалаа гэж бодоход хүүг бууруулах боломжийг олгодог гол хөрөнгө оруулагч нартай хэлэлцээр хийдэг “private placement” аргыг сонгохоор тохиролцсон байна.

Энэхүү хүү бууруулах хэлэлцээр хийдэг арга нь илүү хямд эх үүсвэрийг бий болгодог аж. Гэхдээ цаг хугацааны хувь 1-2 жил зарцуулах төлөвтэй байдаг хэмээн эдийн засагчид тайлбарлажээ. Энэ мэт хөрөнгийн зах зээлд бондоор тоглож болдоггүйн горьг манайхан эхнээсээ мэдэрч эхлэв. Хөгжлийн банкны бондод хөл ургаад дэлхийн зах

зээлийг зориосой.

Монголбанкны Ерөнхийлөгч Д.Пүрэвдорж “Хөгжлийн банк бол сайн, муу хоёр талтай. Сайн аваад явбал тус болдог. Муу авч явбал эдийн засагт тогтворгүй байдал үүсгэдэг. Юу ч болсон Хөгжлийн банкиг байгуулаад үзье” хэмээн өөрийн болоод Төвбанкны байр сууриа илэрхийлж байсан юм. ■

## Эрсдэлийн менежмент

# “Магадлал бага” буюу “хэзээ ч”...

Д.Ганбаяр  
/Эрсдэлийн шинжээч/

Монгол Улс зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжиж хувийн хэвшил, бизнесийн байгууллагууд амжилттай хөгжиж чадсан хэдий ч нийгэм, эдийн засаг, улс төрд бий болж байгаа гадаад орчны шууд ба шууд бус нөлөө, байгууллагын удирдлагын менежментийн алдаа, үйл ажиллагааны доголдлоос шалтгаалан хүндрэлтэй тулгарч улмаар дампуурахад хүргэж байдаг.

Бизнесийн байгууллагын үйл ажиллагаанд тулгарч байгаа саад бэрхшээл, дампуурал нь өндөр хөгжилтэй улс орнуудад ч мөн байнга тохиолддог.

Дампууралд хүргэж байгаа гол шалтгаан нь удирдлага төлөвлөлт байхгүй, дотоод болон гадаад орчноос нөлөөлж байгаа хүчин зүйлд оновчтой хариу үйлдэл үзүүлж чаддаггүй, ирээдүйгээ харсан зөв шийдвэр гаргадаггүй гээд байнга эрсдэлээ тооцож, төлөвлөж хэрэгжүүлдэг, эрсдэлийн менежментийн тогтолцоог нэвтрүүлсэн байгууллага амжилтад хүрч чадаж байгааг 2009 оны аравдугаар сарын “Harvard Business Review” сэтгүүлийн судалгааны тайланд тусгасан байсан.

Ихэнх бизнес эрхлэгчийн хувьд бизнесийн ашиг, орлогод түлхүү анхаарч хөрөнгө оруулах шийдвэрээ гаргаж, өдөр тутмын үйл ажиллагааг удирдан ажилладаг хэдий ч тэр бүр ирээдүйд гадаад болон дотоод орчноос бий болж байгаа хүчин зүйл, саад бэрхшээлийг тооцож



чаддаггүйгээс болж нэг мэдэхэд томоохон тулгамдсан асуудалд ордог. Нөгөөтэйгүүр ирээдүйд учирч болох эрсдэлийг урьдчилан харж, шийдвэрлэх эрсдэлийг удирдах төлөвлөгөө, хяналт хэрэгжилтийн тогтолцоо байдаггүйгээс орлого буурах, алдагдалд орох, бизнесийн үйл ажиллагаагаа зогсоох хүртэлх асуудал тулгарсаар байна.

Эрсдэл гэж юу вэ? Энэ нь ирээдүйд тохиолдох тодорхой бус байдал бөгөөд тухайн тодорхой хугацаа өнгөрөхөд бий болох үр дагаварыг хэлнэ. Хувь хүн, байгууллага, бизнесийн салбар, нийгэм улс оронд ирээдүйд юу тохиолдохыг шууд тодорхойлж чадахгүй, гэхдээ таамаглаж болно. Таамаглал нь хэр бодитой болохыг тохиолдож болох магадлалын түвшингээр л илэрхийлж чадна. Ирээдүйд болох үйл явдал

нь хувь хүн Та өөрөө, байгууллагын удирдлага, салбарын түвшинд шийдвэр гаргаж байгаа сайд, улс орны бодлогыг боловсруулж байгаа улс төрчид, шийдвэр гаргах албан тушаалтан нар ямар шийдвэр гаргаж байгаа, хэрхэн удирдаж ажилласнаар тодорхойлогдоно.

Хувь хүн Та, байгууллагын удирдлага, төрийн түшээ бүгд өдөр бүр шийдвэр гаргадаг. Заримдаа буруу шийдвэр гаргасныг сүүлд нь ойлгож ухаардаг. Шийдвэр гаргахдаа оновчтой сонголт хийхийг хэлдэг. Олон хувилбар, сонголтуудаас зөвийг нь тооцоолж сонгож чадвал зөв шийдвэр гардаг байна. Сонголтуудын ашигтай байх магадлалын түвшингээр аль нь өндөр байна гэдгийг хөрөнгө оруулалтын шинжилгээ хийж тооцдог бол сонголт бүрийн цаана хэрэгжүүлэхэд ямар саад, бэрхшээл учирч болох, түүнийг удирдаж даван туулж чадах эсэхийг эрсдэлийн шинжилгээгээр тооцож гаргадаг. Өөрөөр хэлбэл, оновчтой сонголт хийх шийдвэр гарахдаа сонголт тус бүрийн ашиг болон эрсдэлийг хамтад нь уялдуулан тооцоолдог байна.

## Эрсдэлийн шинжилгээ гэж юу вэ?

Сонголт, хувилбаруудыг боловсруулахад судалгаа хийгдсэн байх хэрэгтэй. Судалгаа хийхэд анхдагч болон хоёрдогч эх сурвалжаас мэдээлэл олж авдаг. Эрсдэлийн шинжилгээ хийхэд олж авсан мэдээлэлд анализ буюу дүн шинжилгээ хийж үр дүнг тодорхойлон илэрхийлэхэд чиглэгдэнэ. Нөгөөтэйгүүр ирээдүйд ▶

▶ тохиолдох тодорхой буй байдлыг таамаглан тооцоолоход чиглэгдсэн эрсдэлийн чанарын ба тоон шинжилгээний үр дүн юм. Таамаглалыг тохиолдох магадлалын хувь хэмжээгээр илэрхийлдэг. Удирдлагын орчин үеийн хандлагад эрсдэлийг тооцохдоо аливаа үйл явдал хэзээ ч тохиолдохгүй гэж болохгүй гээд “тохиолдож болох магадлал бага” гэх буюу тодорхой хувь хэмжээгээр илэрхийлж “хэзээ ч” гэсэн ойлголтыг байхгүй болгох хэрэгтэй гэж тодорхойлжээ.

Эрсдэлийн шинжилгээг хийхдээ байгууллагад шууд ба шууд бус байдлаар нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлох шаардлагатай байдаг. Эрсдэлийг тодорхойлохдоо байгууллагад дотоод орчноос бий болсон эрсдэл, гадаад орчны эрсдэл гэж ангилж авч үздэг. Дотоод орчны эрсдэлд байгууллагын санхүүгийн эрсдэл, техник технологийн эрсдэл, үйл ажиллагааны эрсдэл гэж үндсэн ангилал байдаг. Байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлж байгаа гадаад орчны эрсдэлийн ангилалд нийгэм, байгаль орчин, эдийн засаг, зах зээл, хууль эрх зүй, зах зээлийнх гэж хамааруулдаг. Тухайн байгууллага, салбарын онцлог шинжээс хамаарч бизнесийн үйл ажиллагаанд аль аль нь шууд ба шууд бус хамаарлаар тулгамдсан асуудалд хүргэдэг.

### Эрсдэлийн менежмент гэж юу вэ?

Салбарын онцлогтой уялдуулан судалгааны хамрах хүрээ, аргачлалыг боловсруулж байгууллагын дотоод ба гадаад орчны эрсдэлийг тодорхойлдог. Тодорхойлсон эрсдэлийн хамрах цар хүрээ буюу далайц, тохиолдох тоо хэмжээ буюу давтамжийг эрсдэлийн тоон ба чанарын шинжилгээний тусламжтай тооцож эрсдэлийн үзүүлэх үр дагаварын түвшингээр ангилдаг.

Эрсдэл бүрийн харилцан хамаарал буюу корилляцийг тооцож эрсдэлийг бий болгож байгаа эх үүсвэр буюу шалтгаан, нөлөөлж байгаа хүчин зүйлийг тодорхойлж эдгээрийг арилгах, бууруулах, даван туулах тактик, стратегийг боловсруулдаг. Үүнийг эрсдэлийг бууруулах хариу үйлдэлийн төлөвлөгөөний хүрээнд бүрэн тооцоолж боловсруулдаг байна.


Эцэст нь уг төлөвлөгөөг хэрэгжүү-

лэхэд чиглэсэн байнгын үйл ажиллагаатай эрсдэлийн шинжээч, эрсдэлийн менежерийн тусламжтай хяналт, мониторинг хийж эрсдэлийг удирдаж үйл ажиллагаагаа сайжруулж байдаг.

Бизнесийн байгууллагын эрсдэлийн менежмент буюу Enterprise risk management (ERM) нь 2000 оноос хойш бизнесийн бүх салбарт хурдацтай нэвтэрч эхэлсэн. Учир нь глобалчлал, улс орны эдийн засаг, нийгэм, улс төрийн өөрчлөлт, хөгжиж байгаа улс орнуудын эдийн засгийн хурдацтай өсөлт, салбарын өрсөлдөөн

зэргээс шалтгаалан бизнесийн орчинд бий болж байгаа шууд ба шууд бус эрсдэлийн хамрах цар хүрээ байнга өөрчлөгдөж байна.

Иймд бизнесийн байгууллага нь цаашид оршин тогтнох, өрсөлдөхийн тулд гадаад болон дотоод орчны өөрчлөлтөөс бий болж байгаа эрсдэлийг цаг алдалгүй тооцон удирдаж тогтмол шинэчлэлт, өөрчлөлт зөв хийх шаардлагатай байгаа учраас орчин үеийн эрсдэлийн менежментийн арга барилыг эзэмшиж, бизнесийн ажил хэрэгт нэвтрүүлэх зайлшгүй хэрэгтэй байгаа юм. ■



### Хөрөнгийн зах зээл

## Үрэх үү, өсгөх үү?

Э.Зоригт

**Д**орж саарал өнгийн “Sonata II” маркын машинаас гарч ирээд хаалгыг нь тас хийтэл хааж, орцныхоо зүг алхлаа. Цэмцийтэл нь арчсан машинаа эргэн нэг хараад, чамайг удахгүй солих юмсан, лизинг хөөцөлдөхөөс гэсэн бодол тээн алхах нь илт. Тэрхэн зуур машинаа зарах тухай бодолд автсан тэрбээр хаалганыхаа хонхыг дарж байгаагаа ч мэдээгүй биз. Хаалга нээгдэнгүүт том

охин нь хүзүүдэн аваад, “Ааваа би “I phone” гар утас авмаар байна. Энэ утсаа барихгүй шүү” гээд галын өрөөнд орлоо. Дорж хүн болж төрсний хувьд сайн машин унаж, сайхан байранд амьдарч, үнэтэй гар утас барьж гэмээнэ амьдралын амтыг мэдэрнэ хэмээн үздэг. Тиймдээ ч ахуйн хэрэглээндээ туйлын анхаардаг олонх монгол хүний адил бодолтой нэгэн. Эхнэр, хүүхдээ хүнээс дутахааргүй ▶

Элбэг хангалуун байлгахыг зорилгоо болгоно. Хэдийгээр эхнэр болоод өөрийнх нь цалин, ууж идэх, өмсөж зүүхээс илүү гардаггүй ч орон сууцаа солих хэмжээний мөнгийг сүүлийн гурван жилийн хугацаанд хураагаад амжжээ. Анд нөхөд нь Доржийг мөнгө олох авъяастай, амьдралын овсгоотой хэмээн магтаж түүний жишгээр амьдрал ахуйгаа дээшлүүлж элбэг хангалуун аж төрөхийг хүснэ. Та ч гэсэн түүнийг амьдралын төлөө зүтгэлтэй, сайн залуу гэж бодох биз ээ. Гэтэл бидний хэрэглээгээ хэт анхаарсан ийм сэтгэлгээ хөрөнгийн зах зээлийн хөгжлөөс хойш татдаг гэвэл Та итгэх үү?

Монголбанкны ерөнхийлөгч Л.Пүрэвдорж “Манайхан мөнгө олох тусмаа илүү их үрж байна. Хуримтлал үүсгэх, мөнгөө яаж өсгөх талаар бодохыг ч хүсэхгүй байгаа нь ажиглагддаг. 2011 оны эхний найман сарын байдлаар нийт импорт 4191.1 сая ам.доллар болсон нь өнгөрсөн оны мөн үеэс 2.1 дахин өссөн үзүүлэлт юм. Энэхүү импортын ихэнх хувийг суудлын зориулалттай тээврийн хэрэгсэл, гэр ахуйн тавилга зэрэг эзэлжээ. Энэ нь монголчуудыг ахуйн хэргэлээндээ хэрхэн анхаардгийг харуулж байгаа хэрэг. Бидний энэ үрэлгэн байдал инфляцийг хөөрөгдөж, хуримтлал үүсэх нөхцөлийг бууруулж, мөн хөрөнгийн зах зээлийн хөгжлөөс чангааж байна” гэсэн юм.

Манайхан эрсдэлд дургүй, олсон мөнгөө хэрхэн өсгөхөөсөө илүүтэй үрэх тухай эхэлж боддог нь нууц биш. Тиймээс ч хөрөнгийн биржээр үйлчлүүлэх дургүй байдаг биз. Харин гадаадынхан мөнгийг хэрхэн өсгөх тал дээр ихээхэн анхаардаг байна. Монгол хүн “Excel” маркын машин нь явдаг эсэхээс үл хамаарч яаж “Grand mark II” болгох вэ гэдэг дээр толгойгоо гашилгадаг. Харин гадаад хүн машин нь хэрэглээг нь залгуулж чадахгүй болсон тэр үед л солих тухай бодож эхэлдэг байна. Өөрөөр хэлбэл, тэд бидний болоод байгаа хэрэгцээгээ шинэчилдэг, мөнгөөр яаж ашиг олох арга замыг хайдаг гэсэн үг. Энэ нь явсаар “Хөрөнгө оруулах” гэдэг цэг дээр ирдэг байна. Бид хэрэгцээнээсээ давсан эрэлтийг бий болгодог байхад гаднынхан илүүдэл эрэлтийг хүсддэггүй аж. Манайхаас бусад оронд хүн бүр ганган машин унаж, үнэтэй гар утас бариад байдаг

гүй.

Манайд цөөн тооны хөрөнгийн хуримтлалтай хэсэг байгаа боловч тэдний олонх нь эрсдэлээс айгаад хувьцаа авахаас илүү хадгаламж нээлгэх нь дээр гэж үздэг. Гэхдээ хэтэрхий их эрэлт нь нийлүүлэлтийн хомсдол буюу “шок”-ыг үүсгэж улмаар инфляцийг бий болгох гол хүчин зүйлийн нэг болдог тухай мэргэжилтнүүд ярьж байна. Хэр хэмжээний инфляци бий болсноос шалтгаалж таны банкинд хадгалуулсан хадгаламжийн хүү тэр хэмжээгээр буурдаг ажээ. Тухайлбал, Та банкинд өнөөдөр мөнгөө 10 хувийн хүүтэй хадгалуулж байгаа бол таны мөнгө одоо ямар ч өсөлтгүй зогссон гэсэн үг. Яагаад вэ? Монголбанкнаас гаргасан тооцоогоор өнөөдөр инфляцийн түвшин 10 гаруй хувьтай байгаа аж. Таны 10 хувийн хүү инфляцид идэгдсэн гэж ойлгож болно. Ийм мөнгийг “Үхмэл” мөнгө гэх ойлголт байдаг. Ойлгомжтойгоор хэлбэл, Та 100 төгрөгөөр өсөн талх авдаг байсан бол 10 хувийн инфляцийн улмаас 110 төгрөгөөр мөн тооны талх авах болно. Өөрийн чинь 10 хувийн хүүтэй хадгалуулсан 1000 төгрөг 1100 болсон ч сарын өмнөх 1000 төгрөгийн худалдан авах хэмжээнд л байсаар байна гэсэн үг юм. Хэрэгцээгээ анхаарах нь зөв ч аливаа зүйлийн тунг нь тааруулахгүй бол хор болдог гэдгийг бид мэднэ. Тиймээс Та илүүдэл хэрэгцээндээ зориулах тэр мөнгөөрөө ашигтай үйл ажиллагаа явуулж байгаа аль нэг аж ахуйн нэгжид хөрөнгө оруулалт хийвэл таны мөнгө өсөөд зогсохгүй инфляцийн өсөлтийн өчүүхэн хэсгээс ч болов хугаслаж дэм болох юм. Бид “Маргаашийн өөхнөөс өнөөдрийн булчирхай дээр” гэх явцуу ойголтоос зарим талаар салмаар.

Өнөөдрийн манайхны айгаад байгаа сэтгэлгээгээр тэртээ 1930-аад оны үед европчууд сэтгэдэг байсан гэдэг. Тухайлбал, хувьцаа нь аз сорьсон, эрсдэлтэй наймаа харин бусад төрлийн зээл хамгийн найдвартай гэж ойлгодог байжээ. Гэхдээ өнөөдөр дэлхий нийт дээрх бодлоос ангижирсан. Харин манайхан арай өөр төсөөлөлтэйгээс хөрөнгийн зах зээлийн хөгжил дорой байна.

Монголын хөрөнгийн биржийг сайжруулахаар дотоод, гадаадын мэргэжилтнүүд хүч хавсран ажиллаж байгаа билээ. Тухайлбал, энэ

оны дөрөвдүгээр сард “Лондоны хөрөнгийн бирж” Монголын хөрөнгийн биржтэй хамтран ажиллахаар болсон. Бид тэдний туршлагаас хангалттай суралцаж чадвал энэ нь манай хөрөнгийн зах зээлд оруулж буй том хөрөнгө оруулалт. Мөн хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх тал дээр манайхан ажиллаж л байна. Гаднын туршлагатай мэргэжилтнүүд компанийн засаглал, нийгмийн хариуцлагын талаар хурал зөвлөлгөөн ч цөөнгүй зохиож байгаа гэдгийг Та мэдэж байгаа биз. Гэхдээ хамгийн чухал нь Төвбанкны ерөнхийлөгчийн хэлсэнчлэн бид өөрсдийнхөө үзэл бодлыг үндсээр нь өөрчлөх хэрэгтэй байна. Одоогоор Монголын хөрөнгийн биржээс хувьцаа худалдаж авдаг хүн тун цөөн. Тухайлбал, хөрөнгийн биржийн энэ оны наймдугаар сарын тайлангаас харахад нийт гүйлгээний үнийн дүнгийн 5,5 хувийг л хувьцааны худалдаа, 94,5 хувийг Засгийн газрын бондын арилжаа тус тус эзэлжээ.

Аль тивд байдаг гэдэг нь ч үл мэдэгддэг байсан жижигхэн Монгол өдгөө олон улсын анхаарлыг татаж хөрөнгө оруулагчид хошуурч байгаа нь биднээс дэлхийн жишигт нийцэн алхах шинэ сэтгэлгээг шаардаж буй. Өнөөдөр “Хүннү коал”, “Петро матад”, “Энержи ресурс”, “Дархан Селикат” зэрэг Монголын томоохон компани гадаадын зах зээлээс амжилттай хөрөнгө босгож үйл ажиллагаагаа өргөтгөж чадсан. Энэ нь монгол компанид итгэх гаднынхны итгэл сайжирсан гэдгийн илэрхийлэл. Харин одоо монголчууд өөрсөддөө итгэх, мөн сэтгэлгээгээ өөрчлөх нь чухал. Бид “Хүний нохой идэхээр өөрийн нохой ид” гэдэг. Хэрвээ дотоддоо хувьцаагаа борлуулж, хөрөнгө босгож чадвал монгол хүн, хөрөнгийн хуримтлал үүсгэх түүнчлэн их хэмжээний ашиг олох боломж бий болох юм. Монголын хөрөнгийн биржийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Б.Болд “Монголын компаниуд, дотоодын хөрөнгийн бирж дээр хувьцаагаа арилжаалж эхэлбэл дотоод хувьцаа эзэмшигчдэд хүчтэй дэмжлэг болж, магадгүй улс төрийн савалгаатай бодлогын эрсэг тэмцэх боломжтой болно” гэжээ. ■

## Энгийн асуулт

## Та хувьцаа авсан уу?



**Б.Наранцогт:** /УИХ-ын гишүүн  
Ж.Батсуурийн шадар туслах/

-Хувьцаа авах талаар бодож байгаа шүү. Ер нь ирээдүйд энэ төрлийн бизнест хүч үзэх сонирхол байна.



**Ш.Эрдэнэбат:**  
/УБТЗ-ын машинист/

-Ахынх нь ид хийж бүтээх эрэл хайгуулын насан дээр цэнхэр, ягаан тасалбар гээд нэг үнэт цаас гаргасан юм, манай улс. Үүнийг хувьцааны арилжаанд орж байсан гэж хэлж болох л юм. /инээв/ Гэхдээ орон даяар тийм ч бүтэлтэй юм болоогүй. Тэр үед одоогийнх шиг интернэт, гар утас гээд мэдээллийн хэрэгсэл байсан биш. Өнөөдрийнх шиг ийм олон зурагтын сувагтай ч байсангүй. Мэдээллийн дутагдалтай үед амьдарч байлаа шүү дээ. Түүнээсээ болоод цэнхэр, ягаан тасалбарынхаа учрыг ололгүй хоосон цаас мэтээр



**Д.Хулан:** /“Сүү” ХК-ийн  
маркетингийн менежер/

-Би хувьцааны арилжаанд оролцож байгаагүй. Гэхдээ залуу хүн учраас энэ талаар сонирхон судалж байгаа. Хүмүүс ч сүүлийн үед хувьцаа болон хөрөнгийн зах зээлийн талаар нэлээд сонирхож, тэр хэрээрээ мэдлэг нь дээшилж байх шиг байна. Тийм

“Оюутолгой”, “Тавантолгой” гээд их мөнгө, том хөрөнгө оруулагч далласан төслүүд хөрөнгийн биржийн хөгжилд хувь нэмэр оруулах нь гарцаагүй. 20-иод жилийн түүхтэй Монголын хөрөнгийн бирж, туршлага дутуу хөгжил дорой байгаа нь үнэн. Гэхдээ ойрын хугацаанд хөгжиж чадна гэдэгт найдаж байна. Тэр үед хүмүүсийн хөрөнгийн биржид итгэх итгэл сайжирсан байна байх.

ойлгодог байсан. Засаг ч хийсэн зүйлийнхээ талаар сайн тайлбарлаж танилцаагүйгээс болж бидний дунд хувьцааны талаар буруу ойлголттой болчихсон. Харин одоо өөр болжээ хувьцааны талаар ч их ярих болсон байна. Мэдээлэл дамжуулах ч олон арга замтай болж. Одоо Тавантолгойн хувьцааг иргэн бүрт тарааж байгаа. Энэ нь сайн юм. Тавантолгойн хувьцаагаар дамжуулж үнэт цаасны талаарх шинэ ойлголтыг залууст суулгаж өгөх хэрэгтэй. Тэгж чадвал манай залуус аливааг сурахдаа сайн юм чинь дороо л ойлгоод авна. Гэхдээ энэ талын мэдээллээр сайн хангаж бусад орны алдаа дутагдлыг судлаад ямар эерэг гарц байгааг олж харах хэрэгтэй. Тэгэхгүй Тавантолгойн хувьцааг нөгөө л цэнхэр, ягаан тасалбар шиг үнэгүүдүүлээд орхивол хувьцааны ойлголтыг дахин шинэчлэх гэдэг улам л хэцүү болно.

болохоор хувьцааны арилжаанд хүч үзэх төлөвлөгөөтэй байгаа. Энэ талын мэдээлэл тааруу мөн хувьцаа авах хэмжээний их мөнгөн хуримтлал байхгүй зэргээс шалтгаалаад хойш тавиад л яваа. Гэхдээ хувь хүн мөнгөтэй байлаа ч манай хувьцаа болон хөрөнгийн биржийн хөгжил дорой байгаа нь итгэл алдахад хүргэдэг шүү. Ер нь нийгмийн дунд хувьцаа худалдан авах нь аз сорьсон тоглоом гэсэн ойлголт байдаг. Тэр утгаараа ойр дотнын хүмүүс маань энэ төрлийн худалдааг тийм ч ойшоодоггүй. Энэ нь мөн надад нөлөөлдөг байх.




**Д.Ууганбаяр:**  
/гэрэл зурагчин/

-Би одоогоор гэртээ хүүхдээ хараад сууж байна. Хажуугаар нь бага сага зүйл хийж мөнгө олдог. Манай эхнэр ажилтай. Тэгээд гэртээ сууж байх зуураа яаж мөнгө олж болох аргуудыг нэлээд судалсан. Хэрвээ толгойгоо ажиллуулж чадвал хувьцаа гэдэг гэртээ сууж байгаад л мөнгө олж болох юм гэдгийг ойлгосон. Тийм болохоор хувьцаа худалдаж авах тал дээр нэлээд анхаарал хандуулж судалгаа явуулаад байна. Хэрвээ ашигтай ажиллаж буй газрын хувьцааг худалдан авч чадвал ногдол ашиг хүртэх эсвэл урьд нь авсан үнийн дүнгээсээ хэд дахин нугалж зарах боломжтой юм билээ.



**Г.Золбоо:**  
/ХААИС-ийн оюутан/

-Би хувьцааны арилжаанд оролцож байсан. Гэхдээ яг өөрийн нэр дээр арилжаа хийж байгаагүй. Брокер диллерийн компанид ажилладаг эгчээрээ дамжуулан хувьцаа худалдан авч байсан юм. Намайг хувьцаа авч байгааг хэн ч мэдээгүй, гэхдээ надад таалагдсан. Одоогоор цөөхөн хувьцааны хадгаламжтай. Их сургуулиа төгсөөд үнэт цаасны арилжаанд идэвхтэй оролцоно гэж бодож байгаа. Залуу хүний сэргэлэн ухаанаар авхаалжтай байх юм бол амжилт олно гэдэгтэй итгэлтэй байдаг. Мөн хувьцааны талаар хүмүүс мэдлэгтэй болж энэ төрлийн бизнесийн талаар сонирхдог болжээ. 10 жилийн дараа гэхэд би мундаг том хөрөнгө оруулагч болчихсон байхыг мөрөөддөг. ■



Төсөв

## Төсөв, мөнгөнд төрийн бодлого үгүйлэгдэж байна

И.Отгонжаргал

Өглөгч аав сурсан зангаараа баруун солгойгүй цацахаар шийджээ. Төрийн албан хаагчдын дундаж цалин 600 мянган төгрөг болох гэнэ. Багш, эмч нарынх бол бүүр ч бодоогүйгээр суга өснө. Одоо байгаагаасаа хоёр дахин нэмэгдэнэ гэсэн үг. Энэ асуудлыг Хөдөлмөр, нийгмийн зөвшилцлийн гурван талт үндэсний хороогоор хэлэлцэж, талууд нэгдсэн зөвшилцөлд хүрсэн гэсэн тайлбар дагалдав. Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны зүгээс анх цалин нэмэх тухай ам ангайсан. Ам ангайнуут л санал санаачлага Засгийн газрын зүгээс ногоон гэрлээр дэмжигдэв. Өрхийн тэргүүнд үр хүүхдүүдийнхээ нэхсэн болгоныг нь авч өгч сайхан загнах шалтгаан бий болохоор цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэх зэргийг бол дуун дээр дэмжихээс аргагүй цаг үе. Сайхан зантай аавд он удаан жил зөвлөмж, зөвлөгөөг нь анхаарч мөрддөг байсан ОУВС, Дэлхийн банк зэрэг донор байгууллагын улаан гэрэл асаасан анхааруулгыг ч ажиг тунгаах сөхөө алга.

Сангийн сайд төсвийн тодотгол хийж ДНБ-ий 5.0 хувьтай тэнцэх

хэмжээгээр төсвийн зардлыг өсгөх төсөл УИХ-д өргөн барив. Харин Олон улсын валютын сангаас төсвийн тодотгол хийх шаардлагагүй гэж мэдэгдлээ. Тус байгууллагаас Монголын эдийн засаг хэт хурдан өсөж, хадгаламж, зээлийн хэмжээ огцом нэмэгдэхийн хэрээр гүйлгээнд байгаа мөнгө нэмэгдэж, дээр нь нийгмийн халамжийн зардал хавтгайрснаар төгрөгийн худалдан авах чадвар унаж байгааг учирлав. Дэлхийн банкныхан ч инфляцын өсөлтийг даруй 20 хол даваад талийж магадгүй гэж сэтгэл түгшсэн байдалтай сууна. Харин Сангийн сайд “Монголбанк бодлогын хүүгээ өсгөх бодлого барьж байгаа. Засгийн газар ч мах, бензин шатахууны нөөцийг хэвийн хэмжээнд байлгахад анхаарна. Ингэснээр инфляцийг 10 хувиас хэтрүүлэхгүй байх боломжтой” хэмээн хэвнэг өгүүлж буйгаас үзэхэд айсуу сонгуультай холбоотойгоор улстөрчид бэлэн мөнгө тарааж, бийлэгжүү загнан амлалтаа биелүүлэх ажилдаа чихгүй толгой царайлан шуудрах нь тодорхой гэдэг нь сүүлийн хэдхэн хоногийн төсөв мөнгөтэй холбоотой мэдээллүүдээс тов тодорхой. Нэг

- 25 Грэм Уотс:  
Та бүхэн Монголын эдийн засгийн сэтгүүл зүйд том шинэчлэл авчирчээ
- 26 Хөгжил өөд хөдөлмөрлөгчид
- 30 Хийн хоолой ба хөршүүдийн сонирхол
- 31 Давосын зуны чуулганд Монголыг “гайхуулжээ”

байгаа учир мөнгөний үнэ цэнэ унаж байна. Засгийн газар дэд бүтэц, зам барилга барих, эмнэлэг, сургуулийн хүртээмжээ нэмэгдүүлэн, хувийн секторын хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэхэд нөлөөлж чадвал эдийн засгийн өсөлт бодит өгөөжтэй болно. Төсвөөс давсан орлогоо хөдөлмөрийн бүтээмж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд зарцуулахгүй юм бол ядаж өр төлбөрөө барагдуулахад зориулах хэрэгтэй. Жишээ нь, тэтгэврийн сангийн өрөө төлж эхэлбэл хөрөнгийн зах зээлийн хөгжилд нааштай нөлөө үзүүлнэ” гэж чухам үнэнийг хэлээдхэж. Харин улстрөчид маань эдийн засагчдын иймэрхүү хатуу үнэнийг илэрхийлсэн үгийг хэр тусгаж авахаас хамаг зүйл шалтгаална.

Төсвийн тодотголын төсөлд тусгасан олон зуун тэрбум төгрөгийн зардлын жагсаалтаас ажиглахад “Овоо доо энэ чинь харин нүдээ олсон зүйл байна” гэхээр зардал харагдах нь тун бага. Төрийн тусгай хамгаалалтад байдаг албан тушаалтны дотоод, гадаадад хийх айлчлалын зардал, ноос, ноолуур тушаасан, утаагүй зуух нийлүүлсний “нөхөн олговор” гээд урт жагсаалт үргэлжилнэ. Ухаантай Засгийн газар, ард түмнээ боддог улстөрчидтэйсэн бол дэлхийн эдийн засгийн хямрал дахин нүүрлэх аюул буйг харсаар мэдсээр сууж, бүсээ чангалж болохоорсон доо.

Төсвийн тодотгол хийх нь Төсвийн тогтвортой байдлын үндсэн зарчим, зорилгыг алдагдуулахад хүргэж байгаа тухай Монголын нээлттэй нийгэм форумын эдийн засагч Н.Дорждарь манай сэтгүүлийн энэ удаагийн дугаарт тодорхой бичсэн байгааг тэмдэглэхэд таатай. 2013 оноос хэрэгжиж эхлэх уг хуулийг төсөв, мөнгөний бодлогод эерэг үр дүн авчрах эцсийн ганц найдвар гэж үзэж, хүлээх эдийн засагч, мэргэжилтэн цөөнгүй бий. Уг нь тус хуулинд зарлагын өсөлт, төсвийн алдагдал, улсын өр зэрэг чухал үзүүлэлтийг хязгаарлах олон чухал шаардлага тусгагдсан байжээ. Тэр битгий хэл, С.Баярцогт сайд өөрөө “Ер нь Төсвийн тогтвортой байдлын тухай хууль батлагдвал цаашдаа төсвийн тодотгол гэдэг ойлголт байхгүй болно” гэж сайрхаж байсан цаг саяхан аж. Гэтэл жил хүрэхгүйн дараа Сангийн сайд маань дурлаж батлуулсан хуулиа уландаа гишгэж байгааг юу гэж ойлгох болж байна

вэ? Монголчууд ч яах вэ сонгууль энэ тэртэй нь холбоод ойлгодог юмаа гэж бодоход гаднынхан болон олон улсын байгууллагулынхон бол бүр нүд нь орой дээрээ гарч байгаа биз. Улс төрийн амлалт биелүүлэхээ ойрын гол зорилгоо болгосон шийдвэр гаргагчид маань ийм л ичмээр юм хийж сууна.

2012 оны Төсөв, мөнгөний бодлогын сонирхолтой тоонууд өнөөдрийн байдлаар хараахан тэр бүр ил гарч амжаагүй байна. Дөнгөж УИХ-д өргөн бариад байгаа учраас тэр.

Төсвийн зардлыг ингэж тэлж байгаа тохиолдолд ирэх оны төсвийн алдагдал ямар гарах вэ гэдэг сонин. Зарим мэргэжлийн хүний амнаас сонсоход, Сангийн яам ирэх оны төсвийн алдаглыг 4,1 хувьтай гаргахаар тооцсон гэнэ. Сайхан тоо сонсогдож байгаа биз. Энэ хэмжээндээ барьж чаддаг бол сайхан л байна. Гэтэл энэ нь даан ч үнэмшихэд бэрхтэй юм даа. Төсвийн алдагдлыг ийм бага гаргахын тулд ямар нэгэн харьцуулалтын тоо хэрэгтэй болно. Тэр тоо нь ДНБ-ий хэмжээ юм. Тиймээс Сангийн яамны хийсэн төсвийн тооцоогоор 2012 онд ДНБ-ий өсөлт 20 хувьтай байх аж. Энэ тоог энгийн иргэд хараад баярлах ч харин учир мэдэх хүмүүсийн хувьд бол ДНБ-ий жилийн өсөлт 20 хувьтай гарна гэдэг хөх инээд хүрэхээр зүйл бололтой. Нэг үгээр хэлбэл, тун ч хатуу тоо хийгээд бүтэшгүй мөрөөдөл шахуу зүйл гэнэ.

2011 оны төсвийн алдагдлыг ч гэсэн Сангийн яам анх Төсвийн төсөлд тусгахдаа таван хувьд барина гэж сайхан мэдээ дуулгаж байсан. Монголбанкныхан ч түүнд нь олзуурхаж, Мөнгөний бодлогын бүх тооцоогоо баяртайгаар төсвийн алдагдлын таван хувь дээр үндэслэн хийж, “моггидуулсан”. Харин энэ удаа Төвбанкныхан хаширсан учраас дээрх 4,1 гэсэн тоо хэдий тааламжтай санагдах авч мөнгөний бодлогоо зөөлрүүлнэ гэж лав ам алдахгүй л болов уу. Эндээс үзэхэд Төсөв, мөнгөний бодлогыг УИХ-аар тус тусад нь оруулж, хэлэлцэх биш, хамтад нь ярилцаж хооронд нь уяж өгөх шаардлага бийг хаана хаанаа анзаарч л байдаг баймаар. Одоогийн байдлаар төсвийн асуудал УИХ-аар эхний ээлжинд шахуу хэлэлцэгдэхээр байгаа бол Төрөөс мөнгөний талаар баримтлах үндсэн чиглэлийн төсөл арванхоёрдугаарт эрэмбэлэгдсэн байх жишээтэй. Зөрүүтэй баталсан зүйлийг

уялдуулах гэж араас нь хөөцөлдөх биш, Төсөв, мөнгөний бодлогыг хамтад нь хэлэлцдэг болчихвол илүү үр дүн гарах магадлалтайг төрийн түшээ маань гадарлах л ёстой доо. Уг нь бол манай Төвбанкныхан олон нийтэд нээлттэй байхыг эрмэлздэг. Жил гаруйн өмнөөс тус байгууллагынхан олон нийттэй харилцах харилцаандаа ийм шинэчлэл хийж чадсан. Тэр нь ч хэвлэлийнхэнд таалагддаг. Эдийн засгийн чиглэлээр бичдэг сэтгүүлчдийн мэдлэг мэдээллийг сайжруулахад чиглэсэн сургалт ч цөөнгүй хийдэг. Улсын нууцын чанартай л биш бол иргэдэд хүргэх ёстой асуудлыг нээлттэй байлгах нь зөв шийдвэр гаргах, улсын хөгжил урагшлахад тустай гэж үздэг хүн Төвбанкинд цөөнгүй бий. Энэ утгаараа ч гэсэн Мөнгөний бодлогын асуудлаар холбогдох байгууллагуудтайгаа хамтарч ярилцаад нэгэн зорилгын төлөө явж болдоггүй юм уу гэсэн сэтгүүлчдийн асуултад “Харин тиймээ, уг нь бол улс орны хөгжлийн төлөө тэгмээр л байгаа юм. Яагаад ч юм 20 жил нэгнээсээ алдаа хайсан, биенээ үгүйсгэсэн. Харин одоо манай Монголбанкны зүгээс биенээсээ алдаа хайх биш, гарцыг хамтдаа хайъя гэдэг санал гаргаад байгаа. Бидний зүгээс Сангийн яам, МҮХАҮТ зэрэг байгууллагатай уулзаж асуудлыг хамтдаа шийдэх гарцыг олохоор уулзалтын ширээнд дуудаад, эсвэл дуудагдаад очдог ч эцсийн бүлэгт муудалцаад л салдаг. Одоо ийм баймааргүй байна шүү дээ” хэмээн Монголбанкны Олон нийттэй харилцах албаны захирал Б.Лхагважав учирлаж байсан. Ийм санал санаачилгыг Монголбанкны зүгээс одоогоос хоёр, гурван сарын өмнөөс гаргаж байсан санагдана.

Манайх л болохоор төсвийн алдагдал хэрээс хэтэрч, инфляци өссөнд тэр энэ буруутай гэж хэн нэгнийг муулж, эсвэл хийсэн ажлыг нь үгүйсгэдэг ужиг өвчинтэй удаан яваад байгаа болохоос бусад оронд төсөв, мөнгөний бодлогоо хамтад нь авч үзээд, Сангийн сайд, Төвбанкны ерөнхийлөгч нарыг нэг зорилгын төлөө хамтад нь зүтгүүлдэг байна. Гэтэл өнөөдөр манай Засгийн газар, УИХ, Төвбанкинд нэгдсэн зорилт байхгүйгээс төсөв, мөнгөний бодлого эрүүл, тогтвортой эдийн засгийг хөгжүүлэхэд чиглэхгүй байна.



Зочин

## Грэм Уоттс: Та бүхэн Монголын эдийн засгийн сэтгүүл зүйд том шинэчлэл авчирчээ

Файнэншл таймс” сэтгүүлд хорь гаруй жил ажилласан туршлагатай сэтгүүлч Грэм Уоттс багш Дэлхийн банкны дэмжлэгтэйгээр Монголын эдийн засгийн сэтгүүлчдэд өнгөрсөн есдүгээр сард сургалт явуулахаар ирсэн юм. Тэрбээр “Би өнгөрсөн жил Монголд ирж байсан. Энэ удаа ирэхэд Монголын автозам, хот, хүн гээд ихэнх зүйл урьдын адил байлаа. Харин сэтгүүл зүй тэр дундаа эдийн засгийн сэтгүүл зүйн салбарт том шинэчлэл гарсан гэдгийг олж харсан. Энэ нь “Mongolian Economy” сэтгүүл юм. Монголын эдийн засаг хурдацтай хөгжиж байгаа өнөө үед танай сэтгүүл гарсан гэдгийг сонсоод маш их баярласан шүү. Тэгээд ойролцоох номын дэлгүүрт очоод авах гэтэл аль хэдийнэ дуусчихсан байсан. Гэхдээ сүүлийн дугаарыг нь олж, уншиж үзээд өмнөх дугааруудыг унших бодолд өөрийн эрхгүй автсан” хэмээн манай редакцид зочлох үеэрээ сэтгэгдлээ хуваалцсан юм.

Дэлхий нийтэд эдийн засгийн чиглэлээр сургагч багш гэдгээрээ танигдаж, хүлээн зөвшөөрөгдсөн энэ хүндтэй хүн, эдийн засгийн салбарын мэдэмэдээлэлданхаарлаахандуулдаг Монголын олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл дотроос шинэ тутам байгуулагдсан “Mongolian Economy” сэтгүүлийг олзуурхан, манай редакцид зочилсонд бид баяртай байгаа. Тэрбээр “Эдийн засгийн хүнд мэдээллийг

уншигчдад энгийн ойлгомжтойгоор хүргэх гэдэг туйлын чухал. Энэ үүргийг танай сэтгүүл биелүүлж чадна гэдэгт итгэлтэй байна” гэж онцолсон юм. Мөн Монголын эдийн засгийг гаднын олон орон сонирхож байгаа ийм нөхцөлд танай сэтгүүл англи хэл дээр гардаг нь маш том давуу тал. Надад англи хэл дээрх мэдээ мэдээлэл маш их таалагдсан, хойшдоо “Mongolian Economy” сэтгүүлтэй хамтарч ажиллах, арга туршлагаасаа хуваалцахдаа баяртай байна гэдгээ ч хэлсэн.

Уулзалтын явцад дэлхийн сэтгүүл зүйн хөгжил, ирээдүйн хандлага, Монголын сэтгүүл зүйн давуу болон сул тал гээд олон асуудлаар манай хамт олонтой үзэл бодлоо хуваалцахын зэрэгцээ олон чухал зөвлөгөө өгсөн нь бидэнд оюуны томоохон хөрөнгө оруулалт болсон билээ. Дашрамд Грэм багшийг бидэнтэй ажлынхаа арга туршлагаас хуваалцахад Дэлхийн банкны Монгол дахь Суурин төлөөлөгчийн газар болон Хэвлэлийн хүрээлэнгийн удирдлагад талархсанаа илэрхийлье.

Түүнчлэн олон улсын сэтгүүл зүйд, сэтгүүлч, редактор, эрхлэгчээр олон жил ажилласан тэрбээр дэлхий нийтийн анхаарлыг уул уурхайгаар татаад байгаа манай орны хамгийн сонирхолтой цэг болох Өмнөговь аймагт, дөрөв хоногийн аялал, сургалт явуулсан юм. Уг сургалтад телевиз,



сонин, сэтгүүл түүнчлэн интернэт сайтын гээд 20 гаруй сурвалжлагч, сэтгүүлч хамрагдсан. Эдийн засгийн сэтгүүл зүйгээс шинэ хөгжил шаардаж байгаа өнөө үед Грэм Уоттс багшийн сургалт нь сэтгүүлчдэд дадлага, туршлага олж авах сайхан завшаан болсон. “Уул уурхайн хөгжил, эдийн засгийн өсөлт, дэлхийн хэмжээний эрдэс баялгийн том орд гээд сайхан амлалтуудыг дагуулсан “Олон толгой”-н эргэн тойронд байдал ямар байгааг нүдээр үзэж мөн Грэм Уоттс багшаар хичээл заалгана гэдэг дадлагат тулгуурласан мэдлэг олж авах боломжийг бий болгосон” гэж сэтгүүлчид олзуурхаж байлаа. Мөн Грэм Уоттс багш Монголын хэвлэлийн хүрээлэнтэй хамтарч, эдийн засгийн сэтгүүл зүйд зориулсан цахим номыг, хэвлэлийн хүрээлэнгийн сайтад байршуулж амжсан. Уг цахим санд банк, санхүү, худалдаа наймаа, Засгийн газрын бодлого, газар тариалан, уул уурхай зэрэг сэдвээр бичихэд анхаарах зүйлс, практик зөвлөмжийг багтаасан байна. ■



## Сурвалжлага

## Хөгжил өөд хөдөлмөрлөгчид

Х.Хулан

Нидерландын Хан хүү Жэим дэ Бурбон Парм манай улсад ирээд явлаа. Гэхдээ албан айлчлалаар бус дэлхийн шилдэг 34 залуу лидерийн хамт эртний түүхт Монгол Улсад хоёр өдрийг маш энгийн байдалд өнгөрөөсөн юм. Энгийн хувцаслаж, харилцааны соёлоороо бусдыг өөртөө татсан дунд зэргийн нуруутай Хан хүү хөрвоог уяруулдаг хосгүй морин хуур хөгжмийг эв хавгүйхэн барьж сонирхлоо.

Дэлхийн ирээдүйн хэтийн төлөвийг тодорхойлж ажиллах томоохон үүргийг хүлээсэн 700 гаруй шилдэг залуу манлайлагч байдаг аж. Эдгээрийн төлөөлөл болсон өөрийн улс орныхоо тухайн салбарын тэргүүлэгч, олон түмэндээ танигдан хүлээн зөвшөөрөгдсөн 34 залуу удирдагч манай оронд айлчилсан юм. Хоёр өдөр үргэлжилсэн танилцах аяллыг Сангийн дэд сайд Ч.Ганхуяг санаачилжээ. Дэлхийн залуу манлайлагчдыг Эдийн засгийн форум буюу Давосын чуулга уулзалтаас жил бүр шалгаруулдаг уламжлалтай. Манай улсаас хамгийн анх буюу 2005 онд УИХ-ын гишүүн С.Оюун, 2006 онд Их аварга Д.Дагвадорж, 2009 онд Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт болон Сангийн яамны дэд сайд Ч.Ганхуяг нар дэлхийн залуу удирдагчаар тус тус шалгарч байжээ.

Монголын өнөөгийн нийгэм, эдийн засгийн байдал, ёс заншил, цаашдын зорилттой танилцах залуу удирдагчдын аялал Нийслэлийн 33 дугаар дунд сургуулиас эхэлсэн юм. “Нэр төрөө

эрхэмлэх аян” сэдвийн хүрээнд тус сургууль дээр хийсэн уулзалтын үеэр сурагчид хэрхэн нэр төртэй амьдрах вэ, залуу удирдагч болоход ямар зан чанар, мэдлэг боловсрол шаардлагатай талаарх санал бодлоо тэдэнтэй хуваалцсан.

Түүнчлэн манай авьяаслаг хүүхэд багачууд Монголын сонгодог урлаг, уран нугаралт, хөөмий, ардын бүжиг, морин хуур зэрэг Монголын соёл урлагийг гадаадын зочдод танилцуулсан нь залуу удирдагчдын сэтгэлийг ихэд хөдөлгөсөн билээ. Үүний дараа тэд оюутан залуучуудтай уулзаж, манлайлал, нийгмийн асуудал, шийдвэр гаргах явцад оролцох байдал ямар байвал зохих талаар илэн далангүй яриа өрнүүлэв. Хэлэлцүүлгийн үеэр оюутнууд манай оронд байгалийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд тулгарч буй бэрхшээл, туршилт судалгаа хийх тоног төхөөрөмж, лабораторийн нөхцөл байдал хангалтгүй байгаа тухай ярьсан юм.

Испанийн Аликантегийн Их сургуулийн Нанотехнологи, молекулын лабораторийн захирал Хавиер Гарсиа Мартинес “Монголчууд боловсрол, шинжлэх ухаанд ямар их ач холбогдол өгч байгааг хараад миний сэтгэл үнэхээр их хөдөлж байна. Танайх шиг ийм олон залуустай орны хувьд боловсролын салбартаа илүү их хөрөнгө мөнгө зарцуулахыг шаардах хэрэгтэй. Учир нь үе залгамжлах шинэ эрдэмтэд зайлшгүй шаардлагатай. Дотооддоо олгох боломжгүй боловсролыг

гадаадаас олж ав. Би ч гэсэн тийм замыг туулсан. Тэгээд эх орондоо эргэж ирээд боловсрол шинжлэх ухааны салбартаа манлайлагчид нь бол. Зөвхөн байгалийн баялаг гэж ярьж болохгүй, харин үүндээ яаж нэмүү өртөг шингээх вэ гэдэг нь чухал. Тэр мэдлэгийг зөвхөн шинжлэх ухаан, технологиос олж авна” гэсэн юм. Олон залуусын өөр нэг сонирхсон асуудал бол урдаа тавьсан зорилгоо ямар алхмаар эхлүүлэх вэ гэсэн асуултад дэлхийн залуу удирдагчид “Монголын ирээдүй болсон залуучууд та бүгдийн дуу хоолой олон асуудал дээр маш чухал. Өөрийнхөө зорилтыг мэдэж байж аливаа өөрчлөлтийг хийнэ. Иймээс зорилго нэгтэй хүмүүстэйгээ нэгдэж, зөв арга барилыг сонгох нь чухал. Мөн амжилт, үр дүн гэж бодохоос илүү суралцах үйл явцад анхаарлаа төвлөрүүл, тэгвээс гайхамшигтай зүйл тохиолдох болно” хэмээн хариулав.

“Booz&Company”-ийн мэргэжилтэн, “Чарас” компанийн гүйцэтгэх захирал “Монако-Азийн” нийгэмлэгийн үүсгэн байгуулагч, “А Капитал” группын үүсгэн байгуулагч, “Хильтон Уорлдвайд”-ын дэд ерөнхийлөгч зэрэг төлөөллөөс бүрдсэн дэлхийн залуу манлайлагчид тухайн орон бүртээ хамгийн шилдэг мэргэжилтнүүд, эх орныхоо ирээдүйг жолоодогчид. Хөгжил өөд хөдөлмөрлөж сурсан залуус манай улсад хоёрхон өдөр болсон ч гэлээ энэ нь асар их ач холбогдолтой арга хэмжээ юм. Тэд Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдтой уулзаж, улс орныхогчийн талаар ярилцахын зэрэгцээ Монголын сэтгүүлчидтэй хэвлэл мэдээллийн байгууллагуудын өнөөгийн байдал, хэвлэлийн эрх чөлөө, сэтгүүл зүй болон PR-ын хил хязгаар, мэргэжлийн сэтгүүл зүй гэх мэт сэдвээр санал бодлоо хуваалцсан. 2.7-хон сая хүн амтай жижиг улсад тооны хойноос хөөцөлдсөн сэтгүүл зүй хөгжиж байгааг мэдсэн “Томсон Ройтер”-ийн сурвалжлагч Дебора Кан “Хэвлэлийн эрх чөлөөтэй орон гэж тунхаглах нь нэг зүйл. Харин түүнийг дэмжсэн хууль журамтай байх бол өөр хэрэг” гэв. Хамгийн гол нь аливаа хэвлэл мэдээллийн хэрэгслийг эзэмшигч эзэд нь ил, сэтгүүлчдийн эрх ашгийг хамгаалсан хууль тогтоомжтой байх нь мэргэжлийн сэтгүүл зүйн зөв хөгжлийн голдрил мөн талаар залуу удирдагчид санал нэгдсэн билээ.

Аяллын хоёр дахь өдөр залуус байгалийн үзэсгэлэнт Тэрэлжийн зүг хөдөллөө. Сангийн дэд сайд Ч.Ганхуяг энэ удаа хөтөчийн үүрэг гүйцэтгэж, Монгол Улсын дотоод бүтэц, эдийн засаг санхүүгийн нөхцөл байдал, монголчуудын аж амьдралын тухай тайлбарлана. Зочид гэр хороолол, хүн

амын хөдөлмөр эрхлэлт, ядуурлын түвшингийн талаар ихэд сонирхож байв. Чингис хааны хөшөөтэй Цонжин Болдог цогцолбор болон Тэрэлжийн үзэсгэлэнт хадны энгэрт орших бясалгалын Аръяабалын хийдтэй танилцлаа.

Монголын ёс заншил, түүх дурсгал, нүүдэлчдийн уламжлалт аж ахуй залуу удирдагчдад сэтгэгдэл төрүүлж, онгон байгаль ус ихэд таалагдсан байх. Тэрэлж зочид буудалд болсон Байгалийн баялгийн үр ашиг, өсөлт, бэрхшээл, санхүүгийн тогтвортой байдлын хэлэлцүүлэгт УИХ-ын гишүүн С.Оюун, Сангийн дэд сайд Ч.Ганхуяг, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Дэлхийн банкны суурин төлөөлөгч хатагтай Корали Гэвэрс нар оролцсон. Газрын хөрсөн дорх манай баялаг залуусын анхаарлыг ч мөн татаж байлаа. Нидерланд улсын Гадаад явдлын яамны байгалийн баялаг хариуцсан тусгай элч, Хан хүү Жэм дэ Бурбон Парм, "Монголчууд та бүгд үзэсгэлэнт байгаль, мөн ийм их хэмжээний байгалийн баялгийн нөөц ордыг илрүүлсэн аз завшаантай ард түмэн. Гэхдээ эдийн засгаа маш сайн, зөв хөгжүүлэхгүй бол энэхүү баялгаас хэтэрхий их хараат болох аюул байна. Та бүгдэд мэдлэг ухаан, тэвчээртэй байж тал бүрийн салбарыг хамруулсан хүчирхэг эдийн засгийг хөгжүүлэхийг би ерөөж байна" хэмээв.

Баялагтаа эрдээд бусад салбараа мартаж аюул байдаг. Баялгаас орж ирсэн мөнгийг боловсрол, эрүүл мэнд, мэдээллийн технологийн салбараа хөгжүүлэхэд зориулах мөн эх орны хишиг нэрийдлээр бэлэн мөнгө тарааснаас, ажлын байр бий болгох нь илүү чухал гэсэн санааг олонх залуу лидер хэлж байлаа.

Эцэст нь Ч.Ганхуяг сайдаас сэтгэгдлийг нь сонсоход "Монголын хойч ирээдүй, бидний тусгаар тогтнол, эрх чөлөөнд ийм амьд холбоос хэрэгтэй. Монгол Улс албан ёсны дипломат харилцааг аль болох олон оронтой тогтоохоос гадна иргэн, хувь хүмүүсийн хоорондын амьд нөхөрлөл, туншийн хамтын ажиллагаа байх ёстой. Тэр үйл явцад салбар бүрт өөрийн орон бүрт манлайлж яваа залуу хүмүүсийг авчирснаар үнэтэй хөрөнгө оруулалт хийлээ гэж үзэж байна. Яагаад гэвэл өөрсдөө дор бүрдээ салбартаа улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөө бодол санаагаа чиглүүлж явах хүмүүс. Цаашдаа олон жилийн турш сайн найз нар болж байгаад баяртай байгаа. Нөгөө талаас энэ хүмүүсийн туршлагыг Монголд авч үлдэх нь маш



чухал" гэсэн юм.

Шилдэг залуусын Монголд хийсэн энэхүү арга хэмжээг Монголын эдийн засгийн форумаас зохион байгуулсан бөгөөд сурвалжлан олон нийтэд

хүргэх боломжийг манай сэтгүүлд олгосон Сангийн яамны дэд сайд Ч.Ганхуяг болон Монголын эдийн засгийн форумынханд талархсанаа илэрхийлье. ■

## Дэлхийн залуу удирдагчид ямар ажил албатай хүмүүс байдаг вэ?



**Нами Мацуко: / Японы “Номура холдинг” компанийн Нийгмийн хариуцлагын албаны дарга/**

Хатагтай Нами Мацуко нь хөрөнгө оруулалтын банк болон үнэт цаасны зах зээлийн мэргэжилтэн. Тэрбээр “Номура Холдингс” группт Нийгмийн хариуцлагын албаны даргын ажил хашихын сацуу “Бийонд томорроу” сангийн үйл ажиллагааг дэмжин ажилладаг. Уг сан нь өнгөрсөн гуравдугаар сард Японд болсон хүчтэй газар хөдлөлт, цунамигийн дараа үүсэн байгуулагджээ. Нами Мацуко “Манай сан нь газар хөдлөлтөд өртсөн Японы Зүүн хойд хэсгийн залуучуудад зориулж 2012 оны дөрөвдүгээр сараас сургалт хэрэгжүүлэх юм. Уг сургалт нь тэднийг ирээдүйн удирдагч болоход нь чиглүүлнэ” хэмээн сонирхууллаа.

Японд цунами хагас жилийн өмнө болж өнгөрсөн ч өнөөг хүртэл 20000 хүн ор сураггүй алга болсон хэвээр. Сангийн үйл ажиллагааг

чиглүүлж байгаа Японы Зүүн хойд хэсэгт оршин суудаг хүн амын бараг 30 орчим хувь нь 60 наснаас дээш ахмадууд аж. Тус бүс нутгийн залуучууд нь томоохон хот суурин, ялангуяа Токиод ажиллаж амьдрахаар явах тохиолдол газар хөдлөхөөс өмнө ч элбэг байжээ. Газар хөдлөлтийн аюулд нэрвэгдсэн нутаг дэвсгэрийг сэргээн босгох үйл явцад залуучуудын хүчин чармайлт маш шаардлагатай буй аж. Үүний тулд орон нутгийн залуучуудын боловсрол, удирдах чадварыг дээшлүүлж, тэднийг нутгийнхаа Зүүн хойд хэсэгт амьдрахад тус дэм үзүүлэх ажлыг энэ сангаас зохион байгуулах гэнэ.

Дашрамд дурдахад, хатагтай Нами Монголын ард түмэнд хандан, Японд болсон газар хөдлөлтийн үеэр тусламж үзүүлсэнд чин сэтгэлээсээ талархаж явдгийг минь уламжлаарай гэсэн юм.



**Донг Кван Ким: / “Ханва” группийн гүйцэтгэх захирал/**

“Ханва” групп нь БНСУ-ын арван том компанийн тоонд багтдаг билээ. Тус компанийг анх 1952 онд ноён Донг Кваны өвөө үүсгэн байгуулсан бөгөөд одоо аав нь ерөнхий захирлаар нь ажилладаг. Санхүү болон худалдааны салбарт үйл ажиллагаа явуулдаг энэхүү компани нь нийгмийн хариуцлагын хүрээнд нарны эрчим хүч, ногоон

технологи болон тогтвортой байдал дээр гол анхаарлаа хандуулдаг. Донг Кванаас амжилтад хүрэхэд, ямар зарчмыг баримталвал зохистой вэ, Монголын залуучуудад хандан зөвлөгөө өгнө үү гэхэд тэрбээр дараах зүйлийг хэлсэн юм. “Аливаа зүйлд сэтгэл ханамжтай битгий бай. Мөн эрсдэлийг үүрч, аз туршихаас битгий ай” гэв.



**Катрин Лэй: /“Рийбук”-ын Стратеги болон бизнесийн хөгжлийн газрын дарга/**

Германы Тюбинген хотод төрсөн хатагтай Катрин Лэй багаасаа биеийн тамираар хичээллэж эхэлсэн нэгэн. Чухам тэр үеэс л спорт түүнийн амьдралын салшгүй хэсэг болжээ. Тэрбээр “Бостон консалтинг”, автомашины “Бэ Эм Вэ” группт ажиллаж байсан бөгөөд өөртөө тохирсон ажлыг олох гэж урт удаан хугацааг зарцуулсан аж. Одоо ажиллаж байгаа “Рийбук” компани нь түүний хүсэл тэмүүллийг бүрэн хэмжээнд агуулсан байдаг гэлээ. Сүүлийн таван жил АНУ-ын “Рийбук”-ын төвд ажилласан тэрбээр одоо Амстердам хот дахь компанийнхаа төвд ажиллаж байна. Түүний ажил өргөн хүрээг хамрах бөгөөд Америк болон Европын сургуулиудад биеийн тамирын хичээлийг оруулдаг байх, хөгжиж буй орнуудад

хямд үнээр гутал нийлүүлэх, мөн нийтийн биеийн тамирыг дэмжсэн олон арга хэмжээ авах зэрэг ордог. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдэд зориулсан спортоор хичээллэх хөтөлбөрийг Америк болон Европт хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд удахгүй Ази руу өргөжүүлэх аж. “Судалгаагаар, спортоор хичээллэх нь зөвхөн эрүүл мэндэд сайнаар нөлөөлөөд зогсохгүй, мөн тархины үйл ажиллагааг сайжруулж, хөдөлгөөн нь тархины “бордоо” болдог нь нотлогдсон” хэмээн тамирчин бүсгүй ярьж байна. Иймээс нийтээрээ биеийн тамирт хамрагдах нь илүү үр дүнтэй бөгөөд хүүхдүүдэд “спортоор хичээллэвэл эрүүл саруулаас гадна ухаантай болно” гэж хэлэх нь үнэхээр “супер” тайлбар болдог гэнэ. ■

Үзэл бодол

## Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн үндсэн зарчим, зорилго алдагдаж байна



Н.Дорждарь (МННФ-ын эдийн засгийн менежер)

Сүүлийн жилүүдэд зэсийн үнэ дэлхийн зах зээлдээр хэрхэн хэлбэлзэхээс хамаарч УИХ-аас төсвийн жилийн дундуур улсын төсөвт жил бүр, заримдаа бүр хоёроос гурван удаа тодотгол хийж ирсэн билээ. Ингэж орлогоо даган зарлага нь өөрчлөгддөг тогтолцоо давамгайлж ирсэн нь хямрал үүссэн нөхцөлд нийгэм, эдийн засгийн зайлшгүй чухал зардлуудыг танахад хүргэдэг. Нөгөөтэйгүүр орлого нэмэгдвэл үр ашгийн тооцоо муутай, шаардлагагүй зарлага ихсэхэд нөлөөлдөг. Энэ байдлыг өөрчлөх үүднээс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталж, орлого нэмэгдсэн жилд төлөвлөснөөс илүү гарсан орлогыг Тогтворжилтын санд хуримтлуулж, харин орлого багасч дутагдсан жилд нь тус сангаас төсвийн зардлыг санхүүжүүлснээр Засгийн газрын зардлыг тодорхой түвшинд барьж, аливаа эрсдэлийг хязгаарлахыг зорьсон юм. Ингэснээр хэд хэдэн эерэг үр дагавар бий болохын нэг нь төсөвт тодотгол хийх шаардлагагүй болохыг Сангийн сайд С.Баярцогт УИХ-ын чуулган дээр онцолжээ. Тухайлбал, “Ер нь төсвийн тогтвортой байдлын хууль батлагдвал цаашдаа төсвийн тодотгол гэдэг ойлголт байхгүй болно. Ашигт малтмалын үнийн зөрүүнээс бий болсон орлогын нэмэлт эх үүсвэр бий болбол Тогтворжуулалтын сан руу оруулж орлого муудсан жил уг сангаас эргэж зарцуулдаг зарчим руу шилжинэ гэдгийг хэлмээр байна” гэжээ.

Эрхэм сайдын хэлсэн энэ зарчмыг хэрэгжүүлэх үүднээс 2010 оны зургадугаар сард Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг баталсан юм. Хэн ч харсан Монгол Улс төсөв, санхүүгийн хувьд хариуцлагатай байхыг эрмэлзэж байгаа мэт. Гэтэл хууль батлагдсаны дараачийн жилд буюу 2011 оны есдүгээр сард Сангийн сайд маань төсөвт тодотгол хийх төслийг УИХ-д өргөн барилаа.

Яагаад ийм байдал үүсэх болов гэх асуулыг олон хүн тавьж байгаа нь мэдээж. Уг нь тус хуульд зарлагын өсөлт, төсвийн алдагдал, улсын өр зэрэг чухал үзүүлэлтийг хязгаарлах олон чухал шаардлага тусгагдсаныг тэд мэдэж байгаа. Харамсалтай нь энэ чухал хууль хэлбэр төдий, нүд хуурсан зүйл болж хувирсныг илтгэх хэд хэдэн асуудал байгаад та бүхний анхаарлыг хандуулахыг хүсэж байна. Тэр тусмаа улс төрийн хоёр нам хамтарч Засгийн эрхийг барьж байгаа энэ үед засаж залруулах зайлшгүй шаардлагатай юм.

Нэгдүгээрт, зарлагын хэмжээнд тавих хязгаарлалт. Төсвийн тогтвортой байдлын хуулинд Монгол Улсын нэгдсэн төсвийн зардал нь эрдэс баялгийн бус салбарын өсөлтийн хэмжээнээс хэтрэхгүй байхаар хуульчилж, 2013 оноос мөрдөхөөр болсон билээ. Гэтэл өмнө нь төсвөөс шууд зарлага хийж санхүүжүүлдэг байсан дэд бүтцийн болон бусад төслийг шинээр байгуулагдсан Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх боломжийг нээж өгснөөр уг хязгаарлалтыг хялбархан тойрч гарч болох нөхцөлийг бүрдүүлсэн юм. Хөгжлийн банкны хөрөнгийн эх үүсвэрийг төсвөөс, мөн Засгийн газраар (татвар төлөгчдийн мөнгөөр) баталгаажуулсан үнэт цаасаар бүрдүүлэх тул төсвийн зарлагад тооцогдох учиртай гэж үзэж байна.

Хоёрдугаарт, өрийн хэмжээнд тавих хязгаарлалт.

Монгол Улсын өрийн хэмжээг хязгаарлах байдлаар татвар төлөгчдийн мөнгийг хэт эрсдэлд оруулахгүй байх, улмаар ирээдүйд тэдний нуруун дээр дааж давшгүй ачаа үүрүүлэхгүй байх зорилгоор энэ хязгаарлалтыг хуулинд тусгаж өгсөн. Хуулийн нэр томъёогоор бол “улсын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 40 хувиас хэтрэхгүй байх” юм. Энэ заалт 2014 оноос үйлчилж эхэлнэ. Харин энэ өрийн хэмжээнд уул уурхайн салбарт төрийн шууд оролцоог нэмэгдүүлэх зорилгоор авсан, тухайн төслийн үр ашгаас эргэн төлөгдөх зээлийг оруулж тооцохгүй гэж зааж өгсөн нь өрийн хэмжээ үлэмж нэмэгдэх үүдийг нээж, уг хязгаарлалтын учир утгыг алдагдуулж байна. Тухайлбал, “Оюу толгой” ХХК-д Монголын төр 34 хувь эзэмших зорилгоор “Айвенхоу Майнз” компаниас зээл авч байгаатай холбоотой дараах асуудал үүсч байна. Уг зээлийг өр гэж тооцохгүй гэсэн санаа хуулинд туссан. Цаана нь Таван толгой, Асгат гэх мэт стратегийн болон стратегийн бус олон орд бий. Тэр бүгдэд төр оролцож, зээлээр хувь оролцоогоо баталгаажууллаа гэхэд эрсдэл өндөртэй уул уурхайн салбар уналтад орж, зээлийг тухайн төслийн үр ашгаас эргэн төлөх боломжгүй болох нөхцөл үүсч болно. Түүнчлэн Оюу толгойн 34 хувийн тухайд зээлийн гэрээ хийхдээ буцаан төлөлт нь тухайн төслийн үр ашгаас хамаарах бус, ямар ч нөхцөлд Монголын тал хариуцан төлөх байдлаар тохиролцсон. Өөрөөр хэлбэл, өрийн хэмжээ 40 хувиас хэтрэхгүй байх нөхцөлийг хангахад уг зээлийг өрийн хэмжээнд оруулан тооцох бүрэн үндэслэлтэй болж байна. Эс бөгөөс Оюу толгойн гэрээг өөрчилж, 34 хувийн санхүүжилтийн эргэн төлөлтийг төслийн үр ашигтай нь уях л үлдэж байх шиг.

Гуравдугаарт, тогтворжилтын сангаас хөрөнгө зарцуулах нөхцөл. Төсвийн төлөвлөсөн орлогоос бодит орлогын хэмжээ давсан тохиолдолд Тогтворжилтын санд хуримтлуулж, харин бодит орлого дутвал тус сангаас зарцуулах үндсэн зарчмыг хуулинд тусгаж өгсөн. Гэтэл Засгийн газрын Тусгай сангийн тухай хуулинд тус сангаас хөрөнгө зарцуулах нөхцөлийг тусгахдаа төлөвлөсөн болон бодит орлогын зөрүүг зарцуулж болно гэж зааж өгчээ. Өөрөөр хэлбэл, бодит орлого төлөвлөснөөс дутсан хэмжээгээр сангаас зарлага гаргаж болохоос гадна давсан хэмжээг ч зарж болно гэсэн үг. “Зөрүү” гэдэг үг тийм лутгатай. Ингэснээр Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн мөн чанар алдагдаж зорилго биелэхгүй байх нөхцөлийг нээж өгсөн гэж хэлж болно.

Дүгнэхэд, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль нь Монгол Улсын хөгжлийн өнөөгийн өвөрмөц нөхцөл байдалд нэн шаардлагатай хууль мөн. Хуулийг батлан гаргасныг сайшаалтай. Харамсалтай нь уг хуулинд туссан төсвийн үндсэн хоёр дүрэм буюу шаардлага биелэх бодит боломж муу, тэднийг хялбархан тойрч гарах боломжтой байна. Цаашилбал, уг хууль бүрэн хэрэгжиж эхэлсэн ч төсөвт орж ирэх бүх орлогыг зарцуулах нөхцөлийг хязгаарлаж, оновчтой зохицуулж чадахгүй боллоо.

Уг хууль ихээхэн учир дутагдалтай нь одооноос илт харагдаж байна. Иймд цаг алдалгүй засаж залруулах зайлшгүй шаардлагатай болж байна. ■

Орос

## Хийн хоолой ба хөршүүдийн сонирхол

Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболд “Байгалийн хийн хоолойг Монголоор дайруулах асуудал харилцан ашигтай гэдгийг дахин хөндөж, техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулах боломжтой” гэдгээ Оросын талд уламжилсан юм. Тэрбээр үүнийг Сибирт болсон Байгалийн олон улсын эдийн засгийн VII форумын үеэр олон улсад онцлон тэмдэглэсэн билээ.

Орос гүрний хувьд байгалийн хийг экспортлох мөнхийн сонирхлоо хэрэгжүүлэхээр эдийн засгийн шинэ гарцыг Ази, Алс Дорнодоос хайх болж. Өөрөөр хэлбэл, Европын удаан хөдөлгөөнтэй зах зээлээс өөрийн хамаарлаа бууруулахаар чармайж байгаа нь энэ. Эдийн засгийн эрчимтэй өсөлт, үсрэнгүй хөгжлийн жишээ нь Ази тив болоод байгаатай холбоотой. Тиймээс Монголын нутгаар дамжуулан Хятад руу байгалийн хий экспортлох тухай яриа хэлцэл өрнөж байсан хэдий ч Хятадын талаас хараахан дэмжлэг аваагүй. Иймээс БНСАУ руу байгалийн хий нийлүүлэхээр ОХУ-ын төрийн тэргүүн Д.Медведев Хойд Солонгосын төрийн тэргүүн Ким Чен Иртай уулзсан байна. Үүнийг эрчим хүчний салбарын шинжээчид “Сибирийн байгалийн хийг Солонгосын хойгт хүргэх төлөвлөгөөг урагшлуулахаар Кремлийн гаргаж байгаа сүүлчийн хүчин чармайлтад шүүмжлэлтэй хандаж байгаад гайхах хэрэггүй” хэмээн дүгнэжээ.

Байгалийн хийгээ эскапортлоход Оросын тал ихээхэн найдлага тавьж буй боловч БНСАУ-ын тэргүүнтэй хийсэн уулзалтаараа Хятадад шахалт өгөх хэсэн оролдлого гэж зарим мэдээллийн гэрээслээр бичээд эхэлжээ. Ким Чен Иртай хэлэлцээр хийхээр Москвагаас Зүүн Сибирь хүртэл 5650 км замыг туулсан Д.Медведев “Сибириэс Хойд Солонгосоор дамжуулан Өмнөд Солонгост хий дамжуулах хоолойн царцмал наймаанд дэвшил гарсан” гэж мэдэгдсэн нь шинжээчдийн дүгнэлтийг няцааж эхлэв. Харин хуягласан галт тэргээрээ бүс нутгаар аялсан Хойд Солонгосын лидер энэ сэдвээр ганц ч мэдэгдэл хийгээгүй нь сонирхол татах боллоо. Шинжээчид байгалийн хийн дамжуулах хоолойн гэрээг “үлгэр” гэж



нэрлэсэн хэдий ч гэрээ байгуулбал Хойд Солонгос Өмнөд Солонгост нөлөөлөх улс төрийн хөшүүрэгтэй болно гэж тэмдэглэжээ.

Оросын Ерөнхийлөгчийг Москвад буцан ирсний дараахан хятадууд 2015 он гэхэд Төв Азиас 7000 км байгалийн хийн хоолой шинээр барих төлөвлөгөөгөө зарлав. Үүгээр байгалийн хийн баян нөөцтэй бүсээс авах импортоо Хятад хоёр дахин нэмэгдүүлэх ажээ. Төсөл нь Төв Азийн байгалийн хийн импортод Хятадын хувийг жилдээ 60 тэрбум шоо метр болгон өсгөх юм байна.

Манай хойд хөрш шинэ зах зээл хайж байгааг Байгалийн олон улсын эдийн засгийн форум нотлов. Хятадын байгалийн хийн эрэлт нь 2030 онд Европын түвшнөөс давах болно хэмээн хүлээгдэж байгаа учраас байгалийн хийн асуудал хэзээд хуучиршгүй сэдэв юм. Өөрөөр хэлбэл, Оросын хувьд байгалийн хийн шинэ зах зээлээ хадгалсаар байх нь. Хятад одоо зүүн Сибирийн хоёр хоолойгоор жилдээ 67 тэрбум шоо метр байгалийн хий авах гэрээг байгуулах түвшинд явж буй боловч үнийн тохиролцоон дээр гацаад байгаа гэнэ. Манай урд хөршийн хувьд Ойрхи Дорнод, Австрали ба Төв

Азиас өөрийн нийлүүлэлтийг авахаар болсон учраас Оростой тохиролцоонд хүрэхээс төдийлөн яарахгүй байгаа аж.

Чуулга уулзалтын үеэр байгалийн хийн асуудал ийн өрнөж, олны анхааралд өртсөн. Чуулга уулзалтад оролцохоор ирсэн 3000 гаруй төлөөлөгч зөвхөн Сибирийн өргөн уудам хөндийд нуугдаж буй байгалийн хийд нүд унагасангүй. Тус форумын үеэр Монгол Улсын Ерөнхий сайд Байгаль далай, Хөвсгөл далай хоёрыг түшиглэсэн аялал жуулчлалын бүс нутгийг хөгжүүлэх тухай санал гаргаж, ирэх жилийн чуулганыг энэ сэдвээр зохион байгуулах хүсэлтэй байгаагаа оросуудын сонорт хүргэсэн юм. Европын холбооны улсууд болон БНСУ, Франц, Малайз зэрэг өндөр хөгжилтэй орон ОХУ-тай ойртох эдийн засгийн харилцааг сүвэгчилж байгаа хэдий ч эндээс амжилт муутайхан буцсан гэж хэвлэлээр бичжээ. ОХУ өмнөх жилийн чуулга уулзалтаар хөдөө аж ахуйн сэдвийг хэлэлцүүлж байсан бол энэ удаагийнх “Аюулгүй, байгальд ээлтэй эрчим хүч, түүнтэй холбоотой асуудал”-ыг хөндсөнөөрөө уламжлалт чуулганы уур амьсгалыг шинэлэг байлгаж чаджээ. Эрхүү хотод баригдаж буй ▶▶

“Улаанбаатарын бизнес төв”-ийн нээлт чуулга уулзалтын үеэр тохиосон юм. Тус төвд Монголын үндэсний хоолны газар, бизнесийн бусад үйл ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөжээ.

Мөн энэ үеэр манайхаас инженер, техникийн чиглэлийн мэргэжлээр 10 оюутныг Эрхүү мужийн их, дээд сургуульд үнэ төлбөргүй суралцуулахаа Эрхүү мужийн амбан захирагч Д.Ф.Мезенцев мэдэгдсэн нь чихэнд чимэгтэй мэдээ байв. Түүнчлэн тус мужид хувийн зардлаар сурч буй монгол оюутны тоог ирэх хоёр жилд 20 мянгад хүргэх, тэдний сургалтын төлбөр, бусад зардалд хөнгөлөлт үзүүлэх боломжит бүх гарцыг

эрэлхийлэхээ амласан. Мөн ОХУ-аас дэлхийн улс орнууд руу зорчдог нарийн мэргэжлийн эмч нарын баг бүхий эмнэлэгийн галт тэргийг Монгол Улсад аялуулж, иргэдийг үнэ төлбөргүй үзлэг, оношлогоонд хамруулахаар болж. Манай улсын хувьд хойр хөрштэй хийж буй худалдаа сүүлийн таван жилд эрс нэмэгдэж байгаагаас гадна өнгөрсөн жил хоёр улсын худалдааны эргэлт нэг тэрбум ам.долларт хүрлээ. Үүнийг мэргэжилтнүүд найрамдалт хөршийн гадаад худалдаанд шинэ гарц нээгдлээ хэмээн тэмдэглэж байна. ■

эдийн засаг, гадаад худалдааны илүү нээлттэй бодлого баримталж байна. Энэ нь дэлхийн эдийн засагт тогтвортой өсөлтийг бүрдүүлж, тэнцвэртэй байдлыг тогтооход нэмэр болно” гэжээ. Тэрбээр мэдэгдлийнхээ төгсгөлд АНУ болон Европ эдийн засгийн хямралт байдлаас удахгүй гарна гэдэгт итгэлтэй байгаагаа илэрхийлжээ. Харин төлөөлөгчид эсрэгээр АНУ-ын эдийн засаг сэргэхгүй удаж, Европын холбооны өрийн хямрал шийдэгдэхгүй байгаад санаа зовж байгаа аж.

Давосын зуны чуулга уулзалтад Монгол Улсыг төлөөлж Сангийн дэд сайд Ч.Ганхуяг оролцожээ. Тэрбээр Далянь дахь АНУ-ын “СИБС” телевизэд ярилцлага өгөхдөө ийм мэдэгдэл хийсэн байна. “Монгол Улс нь хурдацтай өсч байгаа эдийн засгийн нэг. Манайх Дэлхийн банкны ангиллаар дундаас доогуур орлоготой улсад багтдаг. Нэг хүнд ногдох ДНБ-ий хэмжээ одоогоор 2470 ам.доллартай тэнцэнэ. Энэ оны эхний улирлын байдлаар эдийн засагт 14,3 хувийн өсөлт гарсан. Ирэх онд Монголын нэг хүнд ногдох ДНБ 5000 ам.долларт хүрнэ. Ингэснээрээ Монгол Улс хөгжлөөрөө Индонезийг ардаа орхиж, Хятад, Тайландтай мөр зэрэгцэх болно. Манай улсын нүүрсний асар их нөөц эдийн засгийн хурдацтай өсөлтийг авчирсан. Тухайлбал, өнгөрсөн наймдугаар сард Монгол урд хөршдөө нийлүүлсэн нүүрсний хэмжээгээрээ Австралийг ардаа орхисон. Засгийн газрын зардал энэ жил 50 хувиар өссөн ч төсөв ашигтай байна” хэмээсэн нь дэлхийн 90 гаруй оронд Монголын хөгжлийн тухай “зэрэг мессеж” болон хүрчээ. ▶

## Хятад

# Давосын зуны чуулганд Монголыг “гайхуулжээ”

Бидний хамгийн гол анхаарах ёстой зүйл бол өсөлтийн хэмжээ бус чанар, түүнд нөлөөлж буй зүйл юм. Ирээдүйд хиймэл өсөлт удаан үргэлжлэхгүй” хэмээн Олон Улсын өсөлтийн компанийн захирал Жереми Юргенс “Давос-2011” зуны чуулга уулзалтын үеэр мэдэгдлээ. Дэлхийн 90 гаруй орны 1500 орчим санхүү, бизнесийн “гингат”-ын өмнө тэрбээр “Чанарын өсөлт”-ийг эдийн засгийн өсөлттэй холбон хэлэлцүүлжээ. Өмнөд хөршийн далайн эргийн Далянь хотноо гурав дахь удаагаа болсон чуулга уулзалт өмнө нь 2007, 2009 онд болж байсан билээ. Хятадын Үндэсний хөгжил шинэтгэлийн хорооноос энэхүү чуулганыг “Дэлхийн хямралыг хэлэлцэн шийдэх дээд хэмжээний уулзалт” гэж тодорхойлжээ. Уулзалтаар бизнесийн шинэ орчинг голчлон хэлэлцсэн байна. Дэлхийн хамгийн том хоёр эдийн засаг бүхий АНУ, Хятадад маргаан үргэлжилсээр. АНУ Хятадын эдийн засгийн бодлогыг шүүмжилж байгаагаас гадна энэ хоёр орон худалдааны болоод валютын асуудал дээр санал зөрөөтэй яваа. Хятадын төр экспортын хэмжээнд гадаад орчин нөлөөлж байгаа явдалд анхаарлаа түлхүү хандуулж, юанийн ханшийг бага түвшинд хиймлээр барьж байгааг

АНУ шүүмжилсэн. Харин Хятадын Төрийн зөвлөлийн Ерөнхий сайд Вэнь Зябо Давосын уулзалтад “Хятад улс одоогоор дотоодынхоо хэрэгцээний өсөлтөд анхаарч байгаа. Манай улс дан ганцаараа хөгжиж чадахгүй, гадаад дотоод хөгжлийн аль аль нь байх хэрэгтэй. Тиймээс ч Хятад улс





Сэргээгдэх эрчим хүч

## Салхитай Монгол

Эрчим хүчгүйгээр орчин үеийн хотожсон амьдралыг төсөөлөхөд бэрх. Гэхдээ дэлхий дахинаа хөгжлийн эх үндэс болсон эрчим хүчийг байгальд ээлтэй технологиор хөгжүүлэхэд ихээхэн анхаарч байна.

### Дэлхийд ямар байна вэ?

Өнөөдөр дэлхий нийтийн хэрэглэж байгаа уламжлалт эрчим хүчний түлш болох нүүрс, байгалийн хий зэргийн нөөц хязгаарлагдмал, технологийн явцад хүлэмжийн хий гэх мэт байгаль орчинд үзүүлэх нөлөө ихтэй учраас хязгааргүй нөөцтэй, байгаль орчинд ээлтэй, технологи боловсронгуй болж, үнэ өрсөлдөхүйц болж сэргээгдэх эрчим хүчийг улам ихээр ашиглах болжээ. БНХАУ, АНУ, ХБНГУ гэх мэт дэлхийн томоохон орнууд салхины эрчим хүчийг өргөнөөр ашиглахын зэрэгцээ цаашдаа ч түлхүү ашиглах бодлого явуулахаар төлөвлөсөөр. Үүний тод жишээ бол энэ Фүкүшимагийн ослын дараахан тавдугаар сард ХБНГУ цөмийн эрчим хүчээс татгалзаж, өсөн нэмэгдэж буй эрчим хүчний хэрэглээгээ сэргээгдэх эрчим хүчээр шийдэхээ илэрхийлсэн явдал юм. Үүнийг даган олон улсын том корпорацн Сименс цөмийн эрчим хүчний бизнесээс гарч байгаагаа зарласан.

Олон улсын сэргээгдэх эрчим хүчний агентлаг / ОУСЭХА/-аас гаргасан тооцоогоор 2050 он гэхэд дэлхийн нийт эрчим хүчний 50 орчим хувийг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс гарган авах гэнэ. Энэ оны зургадугаар сарын байдлаар дэлхийн салхин цахилгаан станцуудын нийт хүчин чадал 215 мянган МВт хүртэл

өссөн үзүүлэлт гарчээ. Мөн энэ тоо жилээс жилд тасралтгүй өссөөр байгаа бөгөөд энэ оны сүүл гэхэд 240.5 мянган МВт хүрэх тооцоог тус агентлагаас хийжээ. Ингэж ихээр өсч байгаа нь 1990-ээд оноос хойшхи компьютерийн бизнесийн эрс өсөлттэй харьцуулахуйц байна гэж олон улсын эдийн засгийн шинжээчид онцлон тэмдэглэж байна.


### Монголд ямар байна вэ?

Төв Азийн өндөрлөгт оршдог Монгол Улсын хувьд салхины асар их нөөцтэй гэдэг. Өөрөөр хэлбэл, газар доорх баялгаас гадна байгальд ээлтэйгээр ашиглах боломжтой хязгааргүй нөөц манайд байна гэсэн үг.

Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 10 хувь буюу 160 мянган ам километр гаруй газарт салхины эрчим хүч үйлдвэрлэх зориулалтаар ашиглах хангалттай нөөцтэй гэж тогтоожээ. 13 аймгийн нутаг дэвсгэрт 20.000МВт-аас доошгүй, есөн аймгийн нутаг дэвсгэрт 50.000МВт-аас дээш хэмжээний салхины нөөц байгаа аж. Ашигт малтмалын арвин нөөцөөрөө дэлхийн анхаарлыг хэдийнэ татсан Өмнөговь аймаг л гэхэд 300.000 гаруй МВт салхины эрчим хүчний нөөцтэй. Гэтэл бид хүрээлэн буй орчинд хор хөнөөлгүй байгалийн цэвэр баялгийг сайтар ашиглаж чадахгүй байна шүү дээ.

Эрчим хүчний зохицуулах газраас гаргасан судалгаагаар манай улс эрчим хүчний нийт үйлдвэрлэлийн 93 хувийг нүүрснээс, 6.8 хувийг шингэн ба хийн түлшнээс, зөвхөн 0.2 хувийг л сэргээгдэх эрчим


Монголын нийт газар нутгийн 10 хувь (160000 км<sup>2</sup>) нь салхины өндөр нөөцтэй болох нь тогтоогдсон




Нийт суурилагдсан хүчин чадал /улс орноор МВт/

Улс	2011 оны эхний зургаан сар	2011 оны эхний хагас	2010 оны нийт хүчин чадал	2010 оны эхний хагас жил	2009 нийт хүчин чадал
	MW	MW	MW	MW	MW
БНХАУ	52.800	8.000	44.733	7.800	25.810
АНУ	42.432	2.252	40.180	1.200	35.159
ХБНГУ	27.981	766	27.215	660	25.777
Испан	21.150	480	20.676	400	19.149
Энэтхэг	14.550	1.480	13.065	1.200	11.807
Итал	6.200	460	5.797	450	4.850
Франц	6.060	400	5.660	500	4.574
Англи	5.707	504	5.203	500	4.092
Канад	4.611	603	4.008	310	3.319
Португал	3.960	260	3.702	230	3.357
Бусад орнууд	29.500	3.200	26.441	2.750	21.872
Нийт	215.000	18.405	196.682	16.000	159.766

Салхин турбины 1кВт үнэ /ам.доллар/



Дэлхийн салхин станцуудын нийт суурилагдсан хүчин чадал /2010-2011 МВт/



хүчнээс гарган авдаг ажээ.

Хэдийгээр монголчууд уламжлалт аргаар гэрэл цахилгаантай амьдарч байгаа ч байгаль экологид ээлтэй үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг бүрдүүлээд эхэлсэн байна. Тухайлбал, 1993 онд НҮБ-ийн “Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенци” улмаар 1999 онд “Киотогийн протокол”-д тус тус нэгдэж, 2005 онд Сэргээгдэх эрчим хүчний үндэсний хөтөлбөр, 2007 онд Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний шинэчилсэн хөтөлбөр /2011/ зэрэг эрх зүйн баримт бичгийг баталжээ.

Гэхдээ хуулийн хэрэгжилтийн хувьд бодитой үр дүн хараахан харагдахгүй байгаад Засгийн газар дүгнэлт хийж ажиллах ёстой болов уу. Өнөөдрийн байдлаар манай улсын хувьд салхины эрчим хүчийг ашиглаж, хөгжүүлээд байгаа зүйл бага. Өмнө нь жижиг оврын салхин сэнсүүд энд тэнд цөөнгүй байрлуулсан ч өдгөө ажиллаж байгаа нь ховор болсон тухай мэргэжлийн хүмүүс ярьж байна. Харин хувийн хэвшлийн зүгээс салхины эрчим хүчийг хөгжүүлэх талд томоохон ажил эхлүүлээд байгаа билээ. “Ньюком” групп Төв аймгийн Салхит ууланд 50МВт хүчин чадалтай салхин цахилгаан станцыг ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Монгол инженерүүдийн мэдлэг чадварт тулгуурлан энэхүү станцыг 2012 ондоо багтаан барьж дуусгах юм.

“Ньюком”-ын охин “Clean Energy” компанийн гүйцэтгэх захирал Б.Бямбасайхан “2004 оноос салхины нөөцийн судалгааны ажлыг идэвхтэй хийж, улмаар техник эдийн засгийн тооцоог Шотландын “SgurrEnergy” компанитай хамтран гаргаснаар олон улсын жишигт нийцсэн бүтээн байгуулалтыг энэ онд эхлүүлсэн. Бидний сонгосон Төв аймгийн “Салхит” уул нь төвийн бүсийн эрчим хүчний сүлжээнд хамгийн ойрхон, салхины нөөц ихтэй нь тогтоогдсон” гэв. Тус салхин станц бүрэн хүчин чадлаараа ажилласнаар Улаанбаатар хотын III, IV цахилгаан станцын дараа орохуйц хэмжээний байгальд ээлтэй эрчим хүчний шинэ эх үүсвэр болох юм.

Жил бүр 70 мянган айлыг хангахуйц 168.5 сая кВтц цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж, 185.5 мянган тонн буюу 130 тэрбум литр хүлэмжийн хийг бууруулж, гэр хорооллын 100 мянган өрхийн хэрэглээ болох 1.6 сая тонн цэвэр ус, 70 мянган айлын түлшний хэрэгцээ болох 150 мянган тонн нүүрсийг тус тус хэмнэх юм байна.

“Салхин станц ашиглалтад орсноор манай оронд судалгаа төдий байсан салхины эрчим хүчний ойлголтыг бодит ажил болгосон хамгийн анхны том бүтээн байгуулалт болох юм” гэж Б.Бямбасайхан захирал ярьсан.

Мөн “Ньюком” групп их бүтээн байгуулалт ид өрнөж, эрчим хүчний асар их хэрэглээг шаардаж байгаа говийн бүсийн 250 мянган га газарт салхины нөөцийг гурван жил судалжээ. Ингэснээр эхний ээлжинд 300МВт чадалтай салхин цахилгаан станц байгуулах техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоог хийхээр ажиллаж байгаа аж.

Төр, засгаас эрх зүйн орчныг нь бүрдүүлээд өгвөл хувийн хэвшлийнхэн эх орны хөгжил цэцэглэлт өөд ийн хурдтай тэмүүлэн ажиллаж байна. ■



Д.Энхбатын булан

www.enkhbat.mn

## Атомщигуудтай маргах нь

Бичихгүй бол болохгүй нь ээ. Эргэн тойронд бүгд л уран, цөмийн хаягдал, цөмийн түлш, атомын цахилгаан станц (АЦС)-ын тухай яриад, бичээд байхад...

Нэг хэсэг бид бүгдээрээ л алтчин, зэс-чин, нүүрс-чин болцгоосон. Одоо цөмөөрөө уран-чин буюу атомчин, оросуудын хэлдгээр, атомщигууд болж эхэллээ. Би өөрөө инженер хүн. Цөмийн физикийн анхан шатны ном уншсан гэсэн үг. Бас тэгээд дэлхийн Ногоон намуудын бодлоготой танилцаж, эрдэмтэн мэргэдтэй уулзаж, хурал цуглаанд нэлээд суусан хүний хувьд энэ талаар зэгсэн мэдээлэлтэй болсон гэж өөрийгөө дүгнэдэг. Тиймд зарим нэг дүгнэлтээ тантай хуваалцья гэж бодлоо.

Дэлхийн олон оронд, ялангуяа Ногоон нам нь хүч нөлөөтэй улс орнуудад АЦС-ыг аажмаар халах бодлого баримталсаар ирсэн. Саяхны Фукушимиагийн хэрэг явдлын дараагаас олон орны либерал болон консерватив улс төрчид ч мөн адил цөмийн технологийн ирээдүйд нэлээд эргэлзэх болсон гэдгийг Та лав сайн мэдэх байх. Тэдгээр орнуудын олон нийт АЦС-ын талаар сайн мэдэх болж, интэрнэтээр ч их маргалдаж, хэрэв бид хүсвэл тэр маргаанд нь идэвхтэй оролцож, холбогдох мэдээ материалыг хангалттай хэмжээгээр олж үзэх боломж бүрджээ.

Дэлхий даяар АЦС-ын ирээдүй, түүнийг дагах эрсдэлийн тухай санаа зовж эхэллээ. Харин Монголд байдлыг өөрөөр тайлбарласан компанит ажил эхлээд байна. Сүүлийн үед манай сонин, телевизээр зарим улстөрч, төрийн албан хаагч, бизнесийнхэн өөрсдийн ашиг сонирхлоо олон түмнээр хүлээн зөвшөөрүүлэх гэж цөмийн хаягдал, АЦС-ыг огт аюулгүй, эрсдэлгүй, хөгжлийн ганц зөв зам гэж илт худлаа ярих боллоо.

Олон жишээ дурьдах шаардлагагүй байх. Өнгөрсөн хавар, “MN-25-р суваг” телевизийн “Дуусдаггүй яриа” нэвтрүүлгээр манай улсын Тусгай эрхт Элчин сайд гэх нэгэн хатагтай “цөмийн түлшний хаягдлыг бараг л гараараа барьсан ч аюулгүй эд шүү дээ” хэмээн ярьж ширээ тойрон суусан биднийг төдийгүй телевиз үзэгчдийг ч гайхшруулж байж билээ.

Тэр хүн бол өөрөө цөмийн физикч хүн, цөмийн хаягдал нь өнөөдөртөө төдийгүй олон мянган жилдээ ч маш хүчтэй цацраг туяа ялгаруулсаар байдаг, эргэн тойрныхоо амьтай бүхэнд маш аюултай зүйл гэдгийг сайн мэдэх хүн. Харин яагаад тэгж ярих болов? Тэр хүний мэргэжлийн ёс зүй, улс орныхоо ирээдүйг ч үл тоон улайм цайм худлаа ярьж байхыг нь харахад цөмийн түлш, хаягдал, АЦС-ыг тойрсон ямар их ашиг сонирхол, том мөнгө, улс төр байгааг түвөггүй гадарлаж болно.

Хэрэв өндөр мэргэжлийн хүн ингэж ярьж болж байгаа юм бол энэ талаар огт мэдэхгүй шахам зарим сэтгүүлч, улстөрчдийг ч юу гэх билээ дээ. Худлаа ярих энэ компанит ажилд саад хийе, үүний тулд би ч бас атомщиг болчих нь тийм ч буруу зүйл биш юм байна гэж үзээд энэ маргаанд оролцохоор шийдлээ. Тэгээд нэг их нурушилгүйгээр, би өөрөө яагаад Монголд АЦС барихын эсрэг байгаагаа товчоон өгүүлье. Би Монголд АЦС барихын эсрэг байдаг. Яагаад гэвэл:

**Нэгдүгээрт**, АЦС маш том эрсдэл дагуулдаг. АЦС нэг “гацвал” асар уудам нутгийг аймшигтай хордуулж, хэдэн арван жил хүн мал амьдрах нөхцөлгүй болгодог гэдгийг бид бүгдээрээ мэднэ. Харамсалтай нь ямар ч сайн техник гацаж болно. Гадны нөлөөнөөс ч болж болно. Бид хэзээ газар хөдлөхийг, нэг террорист нөхрийн толгойд ямар бодол орж ирэхийг, байгалийн гэнэтийн

гамшиг хаанаас ирэхийг урьдчилан мэдэхгүй. Байгалийн гамшиг тохиох нь ямар ч улс орны хэрээс хэтэрсэн асуудал шүү дээ. АЦС-ыг бид хянаад, цагт нь сайн засаад, ажиллуулаад байж чаддаг юмаа гэхэд гэнэт ирэх гамшигийг бид хянаж чадахгүй. Тиймд асуудал АЦС-даа ч биш, харин түүнийг дагах том эрсдэлд бий.

Хэрэв бид сүйрлийн эрсдэлийг огт хянаж чадахгүй, тийм боломж бидэнд байхгүй бол тэр эрсдэлтэй зууралдах хэрэггүй. Түүнээс холуур явах хэрэгтэй. Герман, Швейцарь зэрэг өндөр хөгжилтэй орнуудын АЦС-аас татгалзаж буй нэг гол үндэслэл нь хүн өөрөө байгалийн том эрсдэлийг хянаж чадахгүй гэдэгт байдаг. Тийм ээ, АЦС-ыг улс орнууд ашигласаар байгаа. Гэхдээ тэд одоо хянах боломжгүй том эрсдэлтэй үргэлж хамт амьдарч байгаа гэдгээ сайн мэддэг болоод байна.

**Хоёрдугаарт**, “Дэлбэрч” баллах эд зүйлс хэрэглэхийг би хүсэхгүй байна.

Үзэж суутал гэнэт шатдаг телевизор, эсвэл ярьж байтал чихэн дээр чинь тэсэрдэг гар утас, эсвэл унаж явтал өөрөө салаад уначихдаг тийм машиныг Та худалдаж авах уу? Мэдээж үгүй байх. Би ч бас адил. Тэгвэл яагаад бид гэнэтийн сүйрэл дагуулж болох АЦС-ыг худалдан авч болно гэж? Хэдий тийм ч олон газарт АЦС зүгээр л ажиллаад байгаа шүү дээ гэж зарим хүн хэлэх байх. Тэгвэл нэг тооцоо хийгээд үзье.

Телевизор 200 ам доллар, утас 300 ам долларын үнэтэй байж болно. Харин тэр барааг дагаж ирэх эрсдэл нь хэдэн мянган доллар, тэр бүү хэл, таны аминд хүрэх магадлалтай бол яах вэ? За за, аминд хүрэхээ байа гэхэд, лав 200 ам.долларын үнэтэй бараанд 200.000 ам.долларын өртөгтэй эрсдэл дагаж ирдэг бол тийм барааг би л лав худалдаж авахгүй.

Чернобылийн АЦС-ыг барихад, өнөөгийн үнэлгээгээр, нийт дөрвөн тэрбум ам.доллар зарцуулсан гэдэг. Харин түүний ослоос болж Украин улс нийтдээ 180 тэрбум ам.долларын хохирол үзжээ. Өнөөгийн байдалаар ослынхоруршгийг арилгахад Украин улс 25 жилийн туршид улсын төсвийнхөө 10 хувийг тогтмол зарцуулж иржээ. Өмнө нь ЗХУ асар ихийг зарцуулсан бөгөөд тэр тооцоог нууцалсан хэвээр байна. Монголд Чернобыль давтагдана гэх гээгүй ч бид дөрвөн тэрбум долларын АЦС-ын нийт үнэлгээнд түүний 100 ▶

▶ тэрбум долларын эрсдэлийг оруулж тооцох нь зүй. Ядахдаа осол гарвал даах чадвартай байхын тулд. Дэлхийн хамгийн баян, технологийн асар их чадавхтай орнуудын нэг Япон улс ямар их сандарч байж хямралыг туулж байна. Тэд хэдийг зарцуулж байгааг би мэдэхгүй. Гэхдээ олон арван тэрбум доллар гэдэг нь ойлгомжтой.

Бид ч бас тооцоо хийж болно л доо. Харин тийм явдал болбол Монголын уул уурхайн олон жилийн бүх орлого ч түүнд хүрэхгүй байх болов уу. Тэгээд ч бид, ердөө нэг цахилгаан гаргадаг станцтай болохын тулд улс орноороо дэнчин тавьсан ийм замаар явах хэрэгтэй гэж үү.

**Гуравдугаарт,** АЦС маш их ус хэрэглэдэг.

АЦС-ын хөргөлтийн систем нүүрснийхээс бараг хоёр дахин их ус хэрэглэдэг. АЦС 1MW цахилгаан үйлдвэрлэхэд жилд дунджаар 27 сая литр ус хэрэглэж, 24 сая литр усыг уур болгон алдана. Энэ нь 1GWAЦС (Манай IV ЦС-ын хүчин чадал 0.6GW) жилд 27 сая шоо метр ус хэрэглэж, 24 сая шоо метр ус зарцуулна гэсэн үг. Өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын усны жилийн нийт хэрэглээ нь 77 сая куб метр байна. Шинээр байгуулагдах АЦС өнөөгийн Улаанбаатарын усны нийт хэрэглээний 1/3-ийг хэрэглэж, бараг бүгдийг нь уур болгон буцалтгүй алдах нь ээ. Туул гол өнөөдөр Улаанбаатарын хэрэгцээг хангаж чадахгүй болоод байгаа. Тэгвэл энэ хэрэглээг Монголын ямар гол мөрөн усаар хангаж чадах бол?

АЦС-д ус дутвал яадаг билээ? Үүнийг бид Фукушимагаас сайн ойлгож авсан. Тиймд Монголд АЦС баривал түүнийг Сэлэнгэ мөрний л ойролцоо барих хэрэгтэй болох байх. Харин Сэлэнгэ бол дэлхийн цэвэр усны хамгийн том нөөц Байгаль далайг тэтгэдэг гол эх үүсвэр.

Бид өөрт учрах эрсдэлээ тоодоггүй юмаа гэхэд асуудлыг дэндүү сайн мэддэг оросууд бидний өмнөөс тэр эрсдэлийг маань хариуцах юм болов уу. Үгүй л байх. Тэгвэл бид Байгаль нуурыг хамгаалах бүх арга хэмжээг авч чадах болов уу?

Үнэндээ энэ бол зөвхөн Сэлэнгэ, Байгалийн тухай яриа ч биш. АЦС-ыг хаана ч барьсан Монголын олон гол мөрөн, нуур, гүний усны нөөц ийм эрсдэлд орно.

**Дөрөвдүгээрт,** АЦС-ын хамгаалалтын дэд бүтэц маш өндөр зардалтай.

Өөрийнх нь үйл ажиллагааны зардлыг ярихаа больё. Цахилгаан гаргах өртгийг ч орхиё. Манайд нэг байна уу, арван АЦС байна уу гэдгээс үл хамаарч цөмийн аюулын үед ажиллаж чадах хүчирхэг дэд бүтэц байх хэрэгтэй болно. Япончууд яаж сандарч байна? Тиймд бид тэднээс дутахгүй байх хэрэгтэй болно. Цөмийн технологийн инженерүүд, цацрагийн, галын, химийн алба гэх мэтчилэн олон зуун хүн, асар үнэтэй техник хэрэгслийг байнгын бэлэн байдалд байлгах хэрэгтэй.

“Өндөр мэргэжилтэй, мэдлэгтэй олон зуун ажилтныг бэлтгэж, супер техникээр хангаад ... улс орноо хөгжүүлээд ...” гэж их ярьдаг л даа. Та тэгэхэд нь тэгвэл Улсын онцгой байдлын албандаа, ойн түймэр унтраагч хэдэн залуустаа эхлээд олигтойхон хэдэн хувцас, багаж, техник аваад өгчих л дөө гэвэл бололцоо байхгүй л гэх байх. Мөрөөдөх бол нэг хэрэг, харин хийх бол чадавхын бодит хэмжүүр гэж энэ бус уу.

Бид үнэхээр Япон шиг, Орос шиг цөмийн хамгаалалтын өөрийн дэд бүтэцтэй болж болно. Гэхдээ зардлыг нь төлөх хэрэгтэй дээ ...

**Тавдугаарт.** Бидэнд өөр сонголт бий. Магадгүй энэ бол АЦС-ыг сонгохгүй байх миний хамгийн гол шалтгаан байх. Бидэнд цахилгаан эрчим хүч хэрэгтэй учраас л бүгдээрээ АЦС гээд маргаад байгаа шүү дээ. Тэгвэл цахилгаан гаргах өөр олон сайн сонголт бидэнд бий. Нүүрснээс хийн түлш гаргая ... бохирдолгүй цахилгаан станц ажиллуулъя ... гэх мэтээр ирээдүйтэй олон арга замыг бид ярилцаж болно. Тэдний ихэнх нь АЦС-аас хямд, байгаль дэлхийд, хүний амьдралд бага эрсдэлтэй технологиуд байдаг. Цаашилбал, тэднээс ч дэвшилт шинэ технологиуд өнөөдөр бий болоод байна.

Би байгаль дэлхий, хүний амьдралд огт аюулгүй сэргээгдэх эрчим хүчний технологид итгэдэг. Хэрэв та энэ салбарын хөгжлийг ажиглан хардаг бол таван жилийн дараанаас нарны эрчим хүчний өөрийн өртөг АЦС бүү хэл, нүүрсний цахилгаан станцаас хямд болох хандлага байгааг олж харж байгаа байх.

Монгол бол нар, салхины орон. Дэлхийн говь цөлүүдэд тусч байгаа нарны энергийг ердөө зургаан цагийн

турш л хүлээн авч цахилгаан болгож чадвал өнөөгийн хүн төрөлхтөний бүтэн нэг жилийн хэрэгцээг хангахад бүрэн хүрэлцээтэй гэсэн тооцоо байдаг. Жишээ нь, Фукушимагийн дараа Япон улс нарны цахилгаан станц байгуулахыг маш их анхаарч эхэлсэн ч нарны хавтангууд байрлуулах газар ховор байна гэж бичиж байна. Харин Монголд бол?

Монголын “эрчим хүчний” нар, салхины нөөцийг ашиглан өнөөгийн Хятад улсыг ч цахилгаанаар бүрэн хангах бололцоотой гэсэн эрдэмтдийн тооцоо байдаг. Монгол бол өргөн уудам нутагтай, том хэрэглэгч цөөтэй, төвлөрсөн цахилгаан дулааны систем нэг их тохиромжтой газар биш. Уул уурхайн гол ордууд нь ихэнхдээ нүүрсний ордууддаа ойр байрладаг. Мөн усны нөөц маш багатай.

Бид нар, салхины нөөцдөө тулгуурлан, магадгүй Өвөр Монголтой хамтран Их говьдоо Desertec маягийн төсөл хэрэгжүүлж, Зүүн хойд Азийн эрчим хүчний том төв болох ирээдүй ч харагдаад буй. Энэ бүгдийг одоо л бодож эхлэх цаг болсон.

Өнөөдөр, өндөр хөгжилтэй, цахилгааны асар их хэрэгцээтэй Герман, Швейцарь зэрэг улс орон өөрийн эрчим хүчний ирээдүйгээ АЦС-гүйгээр харж байна. Тэд энэ бүх технологийг хэрэглэж, их мэдлэг, туршлага хуримтлуулж, түүндээ түшиглэн хөгжлийн дараагийн алхмаар сэргээгдэх эрчим хүчийг сонгож байна.

**Зургадугаарт,** Бид ч бас тэр зүг рүү явъя. АЦС-ын санааг дэмжихгүй байх бусад олон шалтгааныг би хэлж чадна. Гэхдээ энэ удаадаа үүгээр дуусгая.

Төгсгөлд нь нэмж хэлэхэд, би цөмийн физикийн хөгжлийг биширдэг, түүнийг бүтээж буй хүмүүсийг хүндэлдэг. Мөн АЦС бол шинжлэх ухаан технологийн гайхамшигтай нэгэн бүтээл гэж боддог. Ирээдүйд хүн төрөлхтөн цөмийн дотоод хүчийг ашиглан ихийг бүтээх нь гарцаагүй.

Түүхийн туршид хүмүүс олон сайхан шинэ технологийг бүтээж, тэр бүгд нь өөрийн цаг үедээ хэрэглэгдэж, халагдан солигдсоор ирсэн байдаг билээ. Өнөөгийн улс орнууд ч өмнөх үеийн бүх ололтоос сурч, сургамж авч, эрчим хүчний хөгжлийн шинэ замаа тодорхойлж байна.

Тэд байгаль дэлхийдээ ээлтэй, амьдралд аюулгүй, сэргээгдэх эрчим хүчийг сонгож байна. ■



Цар үе

## Улс төрд олзлогдсон Оюутолгой

Д.Бэхбаяр

Монголын улс төрийн хийрхэл эхэллээ. Гэхдээ тэр хийрхлийн гол сум нь “Оюутолгой” төсөл болов. Олон жилийн туршид тал бүрээс нь шинжлэн байж баталсан нөгөө л төслөөрөө оролдож гарлаа. Монгол Улсын цаашдын үсрэнгүй хөгжлийн гарааны эхлэлийг тавилаа гэсэн төслөөрөө дахин асуудал үүсгэх нь тэр. Монголын улстөр ийм хөөрхийлөлтэй юм уу, эсвэл жижиг улс орны жижиг улстөрчид ийм ахархан бодолтой байдаг юм уу хэмээн асуусан нэгэн эрхмийн асуулт өөрийн эрхгүй толгойд буулаа. Эргэцүүлж бодлоо. Дахиад нэг асуулт. Манай улстөрчид хамгийн түрүүнд улс орон, ард иргэдийнхээ эрх ашгийг бодож шийдвэр гаргадаг гэж үү. Яалаа гэж дээ хэмээн инээх л хүн олон тааралдах. Тэд өөрсдөө л ард иргэддээ ийм байдлаар үнэлүүлэх ажлыг хийдэг шүү дээ.

Тухайлбал, Оюутолгой төсөл байна. Долоон жил сайдалцаж, муудалцаж явж явж арайхийн баталсан төслөө өнөөдөр зогсооход хүргээд байна. Удтал тунгаан шүүсэн процесс явагдсан шүү дээ уг нь. Улс орон ард иргэдийнхээ төлөө ганц сайн зүйл хийлээ гээд л ам уралдан ярьдаг нөгөө нам, улс төрийн хүчнүүдийн

хүмүүс яагаад баталсан төслийнхөө эсрэг загнах болсон юм бэ. Яагаад баталснаас хойш хоёр жилийн дараа буюу УИХ-ын сонгууль дөхөхөөр энэ асуудлыг гаргаж ирэх болов. Асуудал хэтэрхий ойлгомжтой харагдаж байхад улс орон, ард иргэдийнхээ нэрийг бүү зээлдээч, бас толгойг нь бүү эргүүлээч. Зүгээр л ирэх сонгуулиар олон нийтийн санаа бодлыг урвуулан авахын тулд л хийж буй улс төрийн алхам л гэж харагдаад байна шүү дээ. Эсвэл энэ том төслийг батлах, баталсных нь дараахан асуудлыг өнөөдрийнх шиг хурцаар тавьж, гаргаж ирж яагаад болоогүй юм бэ?

Оюутолгойн ордын 34 хувийг Монголын Засгийн газар, үлдсэн хувийг “Айвенхоу майнз лимитед”, “Рио Тинто интернэшнл холдингс лимитед” компаниуд эзэмшихээр гэрээнд тусгагдсан. Тэгвэл Засгийн газрын эзэмших хувийг 50 хувьд хүргэх шаардлага нь ирэх сонгуулиар суудалдаа үлдэх алсын бодол агуулсан улс төржилтийн бодлого гэж үзэх олон хүн байна.

Мэдээж монгол хүн бүр л 50 хувьд хүргэх санааг сайшаан хүлээн авч таараа. Эцэг өвгөдийнхөө үлдээсэн газрын их баялгийг болж өгвөл 50,

бүр цаашилбал 100 хувь эзэмших юмсан гэсэн бодол бүх монголчуудын сэтгэл зүрхэнд байгаа шүү дээ. Гэхдээ өнөөдрийнх шиг зохиомлоор сонгууль угтсан улс төржилт маягаар ийм үр дүнд хүрээсэй гэж хэн ч хүсэхгүй нь ойлгомжтой зүйл. Яагаад заавал шар толгойтнуудыг шүтэх ёстой юм, яагаад тэднээр ажлаа хийлгэх ёстой юм гэсэн эх оронч маягийн ярианууд явдаг болсон. Энэ нь нэг талаар зөв ч нөгөө талаар бодох ёстой зүйл болж хувирч байна л даа. Өөрөөр хэлбэл, Оюутолгойн 50 хувийг эзэмшээд бөөн мөнгөтэй болж, улс орон цэцэглэж хөгжөөд, ард иргэдийн хэтэвч зузаараад гэх сайхан мөрөөдөл дунд хөлбөрөх зүүдний цаана 50 хувийг эзэмшихээс ч долоон дор асуудлууд урган гарах юм биш үү. Хэд хэдэн байр сууринаас санал бодлоо хуваалцъя.

**Нэгдүгээрт,** Оюутолгой бол 1990 оноос хойших хамгийн том бүтээн байгуулалт. Зургаан тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг ямар ч дэд бүтэцгүй газарт хийнэ. Хамгийн сүүлийн үеийн дэвшилт технологи нэвтрүүлнэ. Олон мянган ажлын байр бий болгож, Монгол Усын хөгжилд онцгой хувь нэмэр оруулах төсөл. Тиймээс ажилд нь ямар нэг

► саад учруулахгүйгээр явуулах нь олон талын үр дүнтэй бус уу.

**Хоёрдугаарт,** Монголд хөрөнгө оруулагчийн эрх зүйн орчин хэр бүрдсэн бэ. Өөрөөр хэлбэл, хөрөнгө оруулалтын эрсдэл үүсч байна. Монголын улстөрийн тогтворгүй, ойлгомжгүй байдал энэ эрсдэлийг үүсгэж байна. Нэг л өглөөний нарнаар хууль баталж, маргааш нь хүчингүй болгодог тогтолцоо хөрөнгө оруулагчдыг төдийгүй үндэсний бизнесмэнүүдийг бухимдуулсаар ирсэн билээ. Оюутолгой төслийн 66 хувийг эзэмшсэн компаниуд маш том эрсдэл хүлээгээд зургаан тэрбум ам.долларыг дэлхийн санхүүгийн зах зээлээс босгох ажилдаа орсон байж таарая. Тэгвэл хөрөнгө оруулагчид 66 хувийн эзэн гэдэг утгаар хандаж, ойлгоод ийм ашиг олноо л гэж тооцоод мөнгө өгнө. Гэтэл нэгэнтээ батлагдаад ажлынхаа 50 хувийг нугалаад байхад нь гэнэт хувийг өөрчилнө, гэрээнд өөрчлөлт оруулах тухай ярьж эхлэхээр гадаадын хөрөнгө оруулагчид Монголын тухай ямар сэтгэгдэлтэй байх вэ? Монголчууд бид за л гэсэн бол ёгүй гэдэг улс. Дэлхийн бизнесийн зарчим ч ийм. Эргэж хургаад л улстөржөөд л явбал хөгжил яриад яах вэ дээ. Хөрөнгө оруулагчийн итгэл алдрах нь ч ойлгомжтой. Гаднын хөрөнгө оруулагчид биднээс ганцхан юмыг л шаарддаг хүсдэг. Тэр нь мэдээж хууль эрх зүйн тогтвортой орчин. Хэрвээ Оюутолгойг зогсоовол ар араасаа шилээ даран ашиглалтад орох гэж байгаа бусад уул уурхайн төслийн хувь заяа яах болж байна. Зарим хүмүүс хэлдэг л дээ. Энэ муусайн шар толгойтнуудыг гуйж яадаг юм гэх мэтээр. Бид өмнө нь ямар байлаа. Гаднынхныг л царайчилж, гуйж байж өдгөө ийм хөгжилд хүрсэн нь гашуун үнэн бус уу. Хэрэв Оюутолгойн гэрээнд өөрчлөлт орох тохиолдолд Тавантолгойн асуудал ч хэсэгтээ зогсож, ойлгомжгүй байдал үүснэ гэдгийг мэргэжилтнүүд толгой сэгсрэн онцолж байна.

**Гуравдугаарт,** Нийгэмд том хүлээлт үүссэн. Оюутолгой бол саалийн сүүтэй үнээ. “Эрдэнэт” үйлдвэрээс хэд дахин том шүү дээ. Ажлын байр ч олноор нэмэгдэнэ. Мөнгө ч урсана. Бэлэн мөнгө ч ихээр авна. Баяжина. Сонгууль дөхөж байгаа юм чинь улстөрийн намууд ч бэлэн мөнгө амлана, өгнө, түүгээр нь машин тэрэг авна....гээд л мөрөөдөх иргэдийн мөрөөдлийн жагсаалт хязгааргүй. Манай улс төрийн намуудын, улстөрчдийн харалган бодлогын муу

үр дагавар нь иргэдийг энэ том бүтээн байгуулалтад өөрсдөө гар бие оролцож баялаг бүтээхийг бодох бус бэлэнчлэх сэтгэлгээнд суулгасныг харуулна. Ард иргэдийн энэ хүлээлт дээр улстөрчид тоглоод байна. 34 хувь дээр багахан хувийг нэмээд авчихвал сонгуулиар хэлэх юмтай, хийсэн ажилтай болно, олон нийтийн санааг урвуулан авч болно. Ийм л улстөрийн тоглолт яваад буй.

**Дөрөвдүгээрт,** Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээг 2003 оноос эхэлсэн. Анхлан Тогтвортой байдлын гэрээ нэртэй байв. Дээр доргүй ярьж, иргэдийн санаа бодлыг авч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр орж, шүүн тунгаагдсан төсөл. С.Баярцогт, Д.Зоригт хоёр хоёулхнаа сууж байгаад шийдчихээгүй шүү дээ. Хэд хэдэн Засгийн газар дамнасан асуудал. Процессын хувьд зөв явагдаж, олон жил дуншиж байж батлагдсан гэрээ гэдэгтэй хүмүүс санал нэгдэх болов уу. Алдаж, оносон зүйл бий гэдэгтээ мэргэжлийн хүмүүс ч санал нийлдэг. Анхных гэдэг утгаараа. Гэхдээ ийм хэмжээнд хүртэл хурцатгах шаардлага байхгүй.

#### “Mongolian Economy”-гийн асуулт

**Оюутолгойн Хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулах талаар яригдаж эхэллээ. Та үүнийг юу гэж үзэж байна вэ?**

**Ц.Түмэнцогт: /“Женерал Электрик интернэшнл” компанийн Монгол дахь Суурин төлөөлөгч/**

-Оюутолгойн их бүтээн байгуулалт дөнгөж л эхлэл төдий явж байна. Ирэх жил баяжуулах үйлдвэр нь ажиллаж эхэлнэ. Манай Засгийн газар, УИХ бүгдээрээ зөвшөөрөөд л 2009 онд Оюутолгойн гэрээг баталсан. Гэтэл одоо тэр гэрээгээ өөрчлөнө гэдэг арай л биш асуудал юм. Тухайн компани одоо ч ашгаа өгч эхлээгүй байна шүү дээ. Харин тодорхой хугацааны дараа Оюутолгой өөрсдийн зардлаа нөхөж мөн Монгол Улсад ашгаа өгч чадах хэмжээний үйл ажиллагаа эхэлсэн тэр үед гэрээнд өөрчлөлт оруулах тал дээр ярилцаж болох байсан. Гэтэл 30 жилийн хугацаатай гэрээ байгуулчихаад хоёр жил ч хүрэлгүй энэ талаар ярих нь зохимжгүй юм. Тоглоомын дүрмээ замын дундаас өөрчлөх нь дараа дараагийн төсөл, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж магадгүй. Цаашилбал энэ үйлдэл нь гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдах, сонирхол буурах гэх мэт сөрөг үр дагавартай. Оюутолгой маань ардчилал гарснаас хойших хамгийн том бүтээн байгуулалт. Тиймээс олон улсын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдахгүй байх нь хамгийн чухал.

**Эдвард Т.Стору: /Хойд Америк, Монголын бизнесийн зөвлөлийн ерөнхийлөгч/**

-Оюутолгойн гэрээг өөрчлөх талаарх мэдээг хөрөнгө оруулагчид нэлээн айдастайгаар хүлээн авсан. Би ч мөн адил. Маш их хөрөнгө мөнгө зарсан түүнчлэн хоёрхон жилийн өмнө гэрээ байгуулсан гэрээ шүү дээ. Тиймээс айдас дагуулах нь ойлгомжтой. Үүнээс үүдээд тодорхойгүй байдал үүсч байна. Хэрвээ энэ тодорхойгүй байдал улам даамжирвал гадаадын томоохон хөрөнгө оруулагчид зугтаж магадгүй. Тиймээс Монгол Улс гэрээ хийх нөхцлөө тодорхой болгох хэрэгтэй. Энэ нь аль аль талдаа чухал асуудал. Хөрөнгө оруулалтын хамгийн гол чухал нь тогтвортой ашигтай ажиллахад байдаг. Гэтэл энэ шаардлага хангагдахгүй ►►

► бол одоогийн хөрөнгө оруулагчид эрсдэлд орох мөн ирээдүйд орж ирэх байсан томоохон хөрөнгө оруулагчдын итгэл алдах зэрэг томоохон асуудалтай тулгарна.

**Петтер Морроу: /Хаан банкны зөвлөх/**

-Оюутолгойн талаар Монгол Улс долоо найман жил ярьсан. Түүний эцэст 2009 онд гэрээ байгуулж хоёр тал хамтран ажиллах болсон. Тиймээс нэгэнт зөвшөөрсөн, хоёр талын ойлголцлын үндсэн дээр байгуулсан гэрээгээ хүндэтгэн үзэх хэрэгтэй. Гэхдээ гэрээнд өөрчлөлт оруулах тохиолдол зарим үед гардаг. Тиймээс Монгол Улс энэ асуудлыг нааштайгаар дотооддоо шийдэх боломжтой. Гэхдээ гэрээ яаж ч өөрчлөгдсөн тогтвортой байдлыг хангах нь юу юунаас илүү чухал юм.

**Д.Дамба: /Монголын уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч/**

-Хуулинд тодорхой заачихсан юмыг манайхан өөрчлөх гээд байх юм. Ашигт малтмалын хуульд хувийн хөрөнгөөр хайгуул хийж, тогтоосон орд газрын 34 хувийг төр эзэмшинэ гээд тодорхой заагаад өгчихсөн байгаа шүү дээ. Харин улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийж нээсэн орд газрын 50 хүртэлх хувийг улс эзэмшинэ гэсэн заалт бий. Оюутолгой бол цэвэр хувийн хөрөнгөөр хийсэн ажил. Тэгэхээр хуулийн заалтаас үзвэл 34 хувийг манай төр эзэмших нь тодорхой. Энэ хуулийн заалтын дагуу л гэрээгээ хийсэн. Харин одоо яриад байгаа өөрчлөлтийг хийхийн тулд хуулийн заалтаа л өөрчлөх шаардлагатай болно. Тиймээс Оюутолгойн гэрээний өөрчлөлтийг одоогоор хийх боломжгүй. Харин Тавантолгой бол өөр. Төсвийн зардлаас хайгуул хийж нээсэн орд учраас төр 50 хувийг эзэмших нь тодорхой. Засгийн газар өөрөө хууль зөрчиж болохгүй шүү дээ.

**-Давид Петорсон: /Оюутолгой ХХК-ийн Бүсийн хөгжил, олон нийтийн харилцаа хариуцсан дэд ерөнхийлөгч/**

-Хоёр жилийн өмнө хийсэн уг гэрээ маань үр дүнтэй хэрэгжээсээ гэж хүсэж байна. Гэрээ тогтвортой байна гэдэг бидний хувьд хамгийн чухал. Тиймээс Оюутолгойн гэрээний асуудлаар Монголын Засгийн газартай амжилттай тохиролцож чадна гэдэгтэй итгэлтэй байгаа.

**Д.Жаргалсайхан: /Эдийн засагч/**

-Гэрээгээ хүлээн зөвшөөрч гарын үсэг зурчихаад одоо юуг нь өөрчлөх гээд байгаа юм бэ. Ойлгохгүй байна. Өөрсдийнхөө хийсэн, мөн Монгол Улсын хэмжээний асуудлаар тоглож болохгүй. Гэрээг байгуулахаас өмнө Иргэний нийгмийн төлөөлөл зөндөө л хэлсэн. Тэр үед анхаарч сонсоогүй ш дээ. Гэтэл одоо гэрээ хийх бүх явцыг өөрсдийн биеэр удирдан гарын үсэг зурсан нөхөд маань гэнэт өөрчлөх тухай шийдвэр гаргадаг нь ёстой ойлгомжгүй юм. Нэгэнт хийсэн зүйлийнхээ үр дүнг үзэхгүй холбирч болохгүй. Энэ нь Монгол Улсад итгэх гаднын олон орны итгэл унаад зогсохгүй нэр хүндэд сэв суулгах аюултай шүү дээ. ■

## News

## Монгол Улсыг дэлхийн нүд, чих байнга харж байдаг болчихож



Энэ үгийг Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Ерөнхий сайд С.Батболд, УИХ-ын дарга Д.Дэмбэрэл тэргүүтэй удирдлагуудтай уулзах үеэрээ хэлсэн юм. Тэрбээр “Оюутолгойг зогсоож болохгүй. Өнөөдөр гурван төгрөг тутмын нэг нь Оюутолгойгоос орж байна. Иймээс энэ төслийг саатуулах нь Монгол Улс, монгол хүн бүрт хохиролтой. Европт эдийн засгийн хямрал нүүрлэж, зэсийн үнэ огцом унаж буй зэрэг нь хөрөнгө оруулагчдад сөргөөр нөлөөлж буй нь ойлгомжтой. Манай дотоодод болж байгаа нөхцөлөөс хамаарч гаднын хөрөнгө оруулагчид, зах зээлд Монгол Улсын нэр хүнд ихээхэн уналаа. Олж авсан жаахан нэр хүндээ алдмааргүй байна. Хөрөнгө оруулагчдад ч бас асуудал бий. Монголыг, Африкийн аль нэг оронтой зүйрлээд л. Үүнийхээ оронд өөд өөдөөсөө хараад шийдэх арга зам хайя. Мөн Оюутолгойг улс төрийн, сонгуулийн сэдэв болгомооргүй байна” гэж хэлжээ. Харин Ерөнхий сайд С.Батболд “Оюутолгойн асуудлыг бид хамтдаа шийдэх хэрэгтэй. Бодит үр ашгаа ирэх жилээс монголчуудад өгөх ёстой гэсэн шаардлага тавьсан. Засгийн газар, хөрөнгө оруулагчидтай хамтран мэдэгдэл гаргахаар ажиллаж байна” гэлээ.

УИХ-ын дарга Д.Дэмбэрэл Ерөнхийлөгч болоод Ерөнхий сайдтай Оюутолгойн асуудлаар санал нэгтэй байгаагаа илэрхийлээд “Үнэхээр л бид улс төрийн бодлоготонууд мөн л бол үндэсний эрх ашгаа дээдэлж ажиллах цаг болсон. Ард түмэн тогтвортой улс төрийг хүсэж байна” гэсэн бол УИХ-ын дэд дарга Н.Энхболд Оюутолгойн асуудлаар санал нэгтээ байгаад баярлаж байна гэдгээ илэрхийлэхийн сацуу Оюу толгойн маргаантай асуудлын улмаас “Айвенхоу Майнз”-ын хувьцааны үнэ унасан талаар санууллаа.

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж “Монголын төр хөрөнгө оруулагчдын итгэлийг дааж чадна. За гэвэл ёгүй улс шүү гэдгээ батлах учиртай. Монголын төр, засгийн удирдлагууд энэ талаар нэгдсэн байр суурьтай байгаа нь уулзалтын үеэр харагдлаа” хэмээн онцлон тэмдэглэв. ■

Тэд бидний тухай

## “Рио Тинто” компани Монголын уул уурхайд тодорхой бус байдалтай тулгарлаа

Ийм гарчигтай нийтлэл “The Wall Street Journal” сэтгүүлд гарсныг уншигч танд хөрвүүлэн хүргэж байна.



БНХАУ-ын хилээс 80 километрийн зайтай орших Оюутолгойн уурхай дээр байгаа “Айвенхоу Майнз Монголия Инк” компанийн ажилчдын зураг бөгөөд уг уурхай нь 35 жилийн туршид жилдээ 450 000 тонн зэс болон 330 000 унци алт олборлохоор төлөвлөсөн юм.

Мат Чембэрс, The Australian, 2011 оны 9 дүгээр сарын 26

**“Рио Тинто” компанийн мэдэгдэж байгаагаар Монголын зэс, алтны томоохон төсөл Оюутолгойн ашиглалтын зардал нь 10 тэрбум ам.долларт хүрэх магадлалтай юм байна.**

Монголын Засгийн газраас Оюутолгойн уурхайгаас хүртэх Монголын хувь хэмжээг ойрын хугацаанд нэмэгдүүлэх хүсэлт бүхий албан захиаг явуулах гэж байгаатай холбогдуулан 2009 оны түүхэн Хөрөнгө оруулалтын гэрээний ирээдүй тодорхой бус байдалд ороод байна. “Рио Тинто” компани нь уурхайн үйл ажиллагааг чиглүүлж ажилладаг бөгөөд Канадын уурхайн бизнес эрхлэгч Роберт Фридландын тэргүүлдэг “Айвенхоу Майнз” компанийн 48.5 хувийг эзэмшдэг юм. “Рио Тинто” компанийн зэсийн асуудал хариуцсан захирал Андрью Хардин “Уул уурхайн томоохон төслийн хоёрдугаар шатны газар доорх ажиллагаа нь нэгдүгээр шатны зургаан тэрбум ам.долларыг оруулаад төслийн хөрөнгийн зардлыг 10 тэрбум ам.долларт хүргэх магадлалтай байна” гэж Улаанбаатар хотноо сэтгүүлчдэд ярилцлага өгчээ. Тэрбээр цааш хэлэхдээ “Хоёрдугаар шатны үйл ажиллагааны судалгааны ажил бүрэн дуусаагүй байгаа тул зардлын тооцоо өөрчлөгдөж болно” гэжээ.

Оюутолгойн ордын хоёрдугаар шатны үйл ажиллагаа нь эхний арван жилийн дундаж олборлолт болох 450 мянган тонн зэсийг 800 мянган тоннд хүргэх магадлалтай аж. Гэхдээ уурхайн барилгын ажлын хэрэгжилт тал дундаа ороод байгаа энэ үед ордын хувь эзэмшлийг тэнцүү болгох УИХ-ын сонгуулийн өмнөх Монголын Засгийн газрын шаардлага нь уурхайн төслөөс олох ашгийн хэмжээг

бүрхэг байдалд хүргэж байна.

Монголын Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт “Засгийн газар хөрөнгө оруулалтын гэрээг дахин хэлэлцэх тухай хүсэлт бүхий захиаг “Айвенхоу Майнз” компанид бичиж байгаа талаар мэдэгдээд Засгийн газраас Монголын 34 хувийг 50 хувьд хүргэхийг хүсэж байгаа юм” гэжээ. УИХ-ын 20 гишүүнийн Засгийн газарт Оюутолгойн ордын гэрээг дахин хэлэлцэх албан шаардлага хүргүүлсний дараа эдгээр мэдэгдлүүд гарсан байна. “Австралиан” сонин “Рио Тинто” компани ийнхүү шахалт үзүүлэх нь өөрчлөлт авчрахгүй гэдэгт итгэлтэй байгаа тухай мэдэвчсэн бол “Оюутолгой” компанийн гүйцэтгэх захирал Камерон МакРэй “Бид сониноос л мэдээллийг харсан төдий бөгөөд албан ёсоор ямар нэгэн мэдэгдэл хүлээж аваагүй” гэжээ.

Тэрбээр “Гэрээнд өөрчлөлтийг хүчлэн оруулах байдлаар тогтворгүй байдлыг бий болгох нь хөрөнгө оруулагчдын дунд болгоомжлол, тодорхой бус байдлыг бий болгоно. Тиймээс энэхүү хөрөнгө оруулалтын гэрээг тогтвортой байлгах нь Монгол улс дэлхийд маш чухал эерэг дохиог өгөх болно” хэмээн онцлон ярьсан байна. “Рио Тинто” компанийн хувьд сонгуулийн өмнөх улс төрийн байр суурь ийм шахалт үзүүлэхэд хүргэж буй талаар мэдээлж байна.

“Рио Тинто” компанийн зэсийн асуудал хариуцсан захирал Андрью Хардин “Айвенхоу Майнз” компани яагаад “Рио Тинто” компанийн хамгийн сүүлд хөгжлийн талаар илэрхийлсэн мэдэгдэлд эсэргүүцэл илэрхийлснийг ойлгохгүй байна, мөн яагаад “Рио Тинто” компанийн захирлууд Оюутолгойн талаар “зөвшөөрөлгүй бөгөөд дутуу мэдэгдэл хийсэн хэмээн мэдэгдсэнийг ойлгохгүй байна” гэжээ.

Андрью Хардин нь “БНХАУ-аас Оюутолгойд 450 МВт эрчим хүчийг нийлүүлэх тухай асуудал Монгол, Хятадын хооронд шийдэгдэхгүй бол 2013 оны арилжааны үйлдвэрлэлийн зорилгод хүрэхгүй байх магадлалтай” хэмээн мэдэгдсэний дараагаар “Айвенхоу Майнз” компани ийнхүү хариу мэдэгдэл хийжээ. Түүнчлэн “Айвенхоу Майнз” компани нь Оюутолгойн эхний шатны үйл ажиллагааг дуусгавар болгож, хоёрдугаар шатны үйл ажиллагааг эхлүүлэхэд дөрвөн тэрбум ам.долларыг босгох шаардлагатай байгаа тухайгаа хэлжээ. “Рио Тинто” компанийн санхүүгийн асуудал хариуцсан захирал Гай Эллотт “Рио Тинто” компанийн хөрөнгө оруулагчдын уулзалтад “Айвенхоу Майнз” компанийн тухай дурьдаад “Айвенхоу Майнз” компани эсвэл “Рио Тинто” компанийн ураны охин компани болох “Австралийн Энержи Ресурс”-ыг бүрэн худалдан авах боломжтой хэдий ч үүнийг шинэ төсөл эсвэл өөр худалдан авах боломжуудын эсрэг нягтлан авч үзэх ёстой хэмээсэн бол Хардин “Рио Тинто” компани нь “Айвенхоу Майнз” компанитай “мэргэжлийн ажил хэргийн холбоотой” байдаг гэжээ. ■

## Оюутолгойн Хөрөнгө оруулалтын гэрээний талаарх Хамтарсан мэдэгдэл

Монгол Улсын Засгийн газар болон “Айвенхоу Майнз”, “Рио Тинто” компаниуд Оюутолгойн Хөрөнгө оруулалтын гэрээний талаар санал солилцож дууссан талаараа доорх хамтарсан мэдэгдлийг гаргажээ.

1. Хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсын хууль тогтоомж, түүнчлэн 2009 оны 7 дугаар сард УИХ-аас гаргасан 57 дугаар тогтоолд бүрэн дүүрэн нийцүүлж байгуулсан гэдгийг талууд дахин нотлов.

2. Оюутолгойн Хөрөнгө оруулалтын гэрээ нь заавал дагаж мөрдөх гэрээ гэдгийг талууд бататгаж, тус гэрээнээс Монголын ард түмэн үлэмж хэмжээний ашиг тус хүртэж байгааг тэмдэглэв.

3. Дэлхийн эдийн засгийн байдал ихээхэн тогтворгүй байгаа энэ үед Оюутолгой төслийг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх нь Монголын Улсын эдийн засгийг хямралын нөлөөллөөс хамгаалахад чухал юм гэдгийг талууд онцлон тэмдэглэв. Монгол Улсын хөрөнгө оруулалтын орчинд итгэлтэй байх нь эдийн засгийн өсөлтийг дэмжих урьдчилсан нөхцөл юм.

4. Оюутолгой төслийн хөрөнгө оруулагчид Монгол Улсын эдийн засгийн хөгжил, орон нутгийн дэд бүтцийг хөгжүүлэхэд хөрөнгө оруулна хэмээн гэрээгээр тохиролцсон үүргээ биелүүлэхээ бататгав. Оюутолгой ХХК нь Монгол дахь хамгийн том дэд бүтцийн хөтөлбөрийг санхүүжүүлснээр Гашуун сухайт хилийн боомт хүртэл авто зам барьж, олон улсын стандартын

нисэх онгоцны буудал, усан болон цахилгаан түгээх систем, мөн Монгол Улсын нутагт таван хотод мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийг барьж байгуулна.

5. Оюутолгой ХХК нь Өмнөговь аймаг болон Ханбогд сумыг хөгжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэн бизнесийг хөгжүүлэх санаачлагуудад үргэлжлүүлэн хөрөнгө оруулах замаар Монголын ханган нийлүүлэгчдийг хөхүүлэн дэмжинэ.

6. “Рио Тинто” компани нь төслийг удирдан хэрэгжүүлж байгаагийн хувьд уг төсөлд оролцож буй Монгол Улсын иргэдийг Оюутолгой төсөлд болон уг төсөлтэй холбогдох бусад салбарын чиглэлээр сургах, тэднийг дэвшүүлэн удирдах албан тушаалд ажиллуулахын чухлыг бататгав. Монгол Улсын иргэдийн оролцоог 90 хувь хангана гэсэн зорилттой уялдуулан сургалт, гадаад, дотоод тэтгэлэг, дадлагажуулах хөтөлбөр, хангамжийн бодлого, журмыг боловсруулж хөрөнгө оруулалт хийх аргаар Монгол Улсын иргэдийг төслийн удирдан манлайлах үүрэгт хурдан шуурхай бэлтгэнэ.

7. Монгол Улсын Засгийн газар болон “Айвенхоу Майнз”, “Рио Тинто” компаниуд Оюутолгой төслийг ашиглалтад оруулах талаар хамтын ажиллагаагаа эрчимжүүлнэ гэдгийг дахин нотлов. Цаашид, Оюутолгой төслийн үйл явц, төслөөс Монгол Улсын эдийн засаг болоод ард түмэнд үзүүлж буй үр ашгийн талаар олон нийтэд байнга мэдээлж байх тал дээр талууд хамтран ажиллах болно. ■

2011.10.06

### Эрдэс

## Зэсийн үнэ огцом уруудсаар

Лондоны металлын бирж дэх зэсийн үнэ огцом уруудсан хэвээр. Ханшийн уналт он дуустал үргэлжилж 6500 ам.доллар болж буурах төлөвтэй байна гэж “Блүүмбэрг”-ийн судалгаанд дурьдсан байна. Энэ оны хоёрдугаар сард дээрх металлын бирж дээр тонн нь 10190 ам. долларт хүрч, өсөлтийн рекорд тогтоож байсан зэсийн ханш ийн уруудаж байгаа нь идэх талх, өмсөх хувцас нь зэсийн орлогоос хамаардаг шахуу болсон монголчуудын хувьд сэтгэл гонсойх мэдээ юм. Тиймээс таксины жолооч хүртэл үйлчлүүлэгчтэйгээ “Зэсийн үнэ ч сүүлийн үед дэлхийн зах зээлд дээр зогсолтгүй уруудаад эхэлсэн гэх шив дээ. Шинжээчид уг металлын ханшийг мөд эргэж сэргэхгүй байх гэж таамаглаж байгаа юм байна. Манай Засгийн газар зэсийн үнэ өндөр байхад овоо мөнгө хийж чадсан болов уу” хэмээн ярьж явна.

Зэсийн орлого үнэхээр манай төсвийн дийлэнхийг бүрдүүлж байгаа болохоор ханш унахад хэн хүнгүй ийн санаа зовох нь аргагүй. Тэгээд ч одоогоос 3 жилийн өмнө буюу 2008 оны зун 8000 ам.долларт хүрсэн тонн зэсийн ханш мөн оны өвөл гэхэд 3000 ам.доллараас доош ортлоо навс унаж байсан билээ. Энэ байдлаас болж Монголын эдийн засаг багагүй хугацаанд санхүүгийн хямралд орж, шаналж явсан сургамж бий учраас өнөөдөр иргэд ийн санаа зовинох нь аргагүй шүү дээ. Харин өнөөдөр Лондоны металлын бирж дээр үнэ уналаа гэж сонсонгуут санаа нь зовох ёстой сайд, дарга нар нь юу ч болсон шинжгүй, эсрэгээрээ тодотгол хийж, төсвийн зардлаа тэлэхээр сэтгэл шулуудаад байгаа нь цаг үетэйгээ авчлалдахгүй ойлгомжгүй зүйл юм. Уг нь бол дэлхийн зах зээлд дээр зэсийн үнэ унаж байгаад таксины жолоочийн сэтгэл биш, төрийн түшээдийн санаа эхлээд зовох учиртайсан.

Энэ талаар мэргэжлийн эдийн засагч, шинжээч нарын санаа

бодлыг сонирхоход, “Зэсийн ханшийн огцом уналт Монголын эдийн засагт өмнөх шигээ хүчтэй нөлөө үзүүлэхгүй байх. Учир нь, манай нүүрс мэтийн бусад эрдсээс олох экспортын орлого гурван жилийн өмнөхөөсөө нэмэгдсэн болохоор. Гэхдээ анхаарч эхлэхгүй л бол горьгүй” хэмээн ярьж байна. Ханшийн уналт хэдий болтол үргэлжилж, хэд болохыг хэн ч хэлж мэдэхгүй учраас таамаглаж тааварлахад бэрхтэй. Гэхдээ л хэт өндрөөс огцом доошилсон ханшийн уналт урт хугацаанд үргэлжлэх юм бол манай бийлэгжүү зантай төр, засгийн хүмүүс маань “боломжтой байхдаа орлогоо хуримтлуулж байхгүй яв даа” хэмээн амаа барихыг үгүйсгэхгүй.

Манайхан л тоож анзаараагүй болохоос сүүлийн саруудад зэсийн үнийн муу мэдээг зөгнөсөн үйл явдлууд дэлхийн зах зээл дээр болоод л байж. Тухайлбал, “дэлхийн эдийн засаг унахад зэсийн үнэ буурдгийг бид гурван жилийн өмнө харсан шүү дээ” хэмээн “Standart bank” хөрөнгө оруулалтын банкны таваарын стратегич Волтер дэ Вэт ярьсан удаатай. Зэсийн үнэд макро эдийн засгийн үзүүлэлтүүд хүчтэй нөлөөтэй байдаг учраас АНУ, Европын төсвийн хямрал, Хятадын инфляци уг металлын ханшид сөргөөр нөлөөлөх вий гэсэн болгоомжлол трейдрүүдийн толгойг эртнээс гашилгажээ.

Зэсийн ханш уруудах тухай мэдээ таамгаас илүүтэй Хятад болон хөгжиж буй орнуудын зэсийн хэрэгцээ нэмэгдэж байхад олборлолт эрчимжиж чадахгүй байгаагаас энэ оны дөрөвдүгээр улиралд зах зээл зэсийн хомсдолд орны гэсэн шинжээчдийн таамаг мэдээлэл нэлээд түгж байсан билээ.

Дэлхийн нийт зэсийн хэрэгцээ жилдээ ойролцоогоор 18 сая тонн байдгаас 30 гаруй хувийг нь урд хөрш дангаараа хэрэглэдэг гэнэ. Энэ зэсийн “мангас” улсын макро эдийн засгийн байдлаас хамааралтай. ■



Discover Mongolia-2011

## Тулгын гурван чулуу байж гэмээнэ тогоо тавьж, хоол болно

### Оюутолгой хүртэл...

Олон арван жилийн турш гаднын хөрөнгө оруулагчид Монголын говийн элсэн дорх баялагт нүд унагаж ирсэн. Гэхдээ авлига, хууль эрх зүйн тогтворгүй байдал зэргээс болж зайгаа барих нь элбэг. Ганцхан гэрээ байгуулахын тулд зургаа, долоон жилийн тэвчээр шаарддаг Монгол Улсад ямар ч ажил хэрэгч хүн уул уурхайн бизнес эрхлэх зориг гаргахгүй нь лавтай. Учир нь энэ бол хамгийн эрсдэлтэй тоглоом. Харин 2009 онд Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ батлагдсан нь Монголд ажил урагшилдаг юм байна гэх ойлголтыг хөрөнгө оруулагчдын толгойд сайтар суулгаж өгсөн нь үнэн. Чухам үүний л ачаар гаднын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэж, эрдэс баялгийн салбар дахь том жижиг уурхайн ажил эрчимжсэн шүү дээ.

“Оюутолгой” компанийн гүйцэтгэх захирал Камерон МакРэйн “Discover Mongolia-2011” чуулга уулзалтын үеэр тавьсан илтгэл олны анхаарлын төвд байв. 2015 он гэхэд дэлхийн ээсийн топ таван уурхайн нэг болох Оюутолгой 2019 он гэхэд 465 сая тонн зэс олборлож, олон жил Монгол

Улсын төсвийг “угжиж” ирсэн “Эрдэнэт” уулын баяжуулах үйлдвэрийн хүчин чадлыг дөрөв дахин давж гарах аж. Харин уурхай бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхэлсэн цагт Монголын эдийн засгийн цар хүрээ хоёр дахин тэлж, ДНБ жилдээ арван хувиар өсөхөөр байгаагийн таван хувийг Оюутолгой түүчээлэх тооцоо гарчээ. Тийм ээ, монголчууд үнэхээр баян нутгийн эзэд. Гэхдээ энэ ертөнцөд Монголоос өөр хөрөнгө оруулчихаар газар байхгүй мэт ойлгож, цээжээ дэлдэх нь зөв үү. Саяхныг хүртэл хөрөнгө оруулагчид Оюутолгойг ч, Тавантолгойг ч тэр нэг нүдээрээ үздэггүй байв. Ямар сайндаа л “BHP Billiton” тоглоомоос гарах вэ дээ. Харин одоо байдал өөрчлөгдөж, Монголын уул уурхай үнэхээр моодонд орж, “BHP Billiton”-ы шийдвэр буруу байсныг баталж байна. Гэхдээ бид ганц л буруу алхам хийхэд “Алтан загасны үлгэр”-ийн эмгэн шиг эвдэрхий тэвшээ тэврээд үлдэх эрсдэл хажууханд бий.

“Reuters”, “Bloomberg” зэрэг гаднын хэвлэл мэдээллийн агентлаг энэ жилийн “Discover Mongolia”-гаас сенсаац шүүрч чаджээ. Хаврын тэнгэр шиг ааштай Монголын Засгийн газар

Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээндээ хүртэл гар хүрэх төлөвтэй болсон тухай ам уралдан ярьцгаах байна. Энэ бүхэн Монголын тогтворгүй байдлыг илтгэж байгаа тухай мэдээлэл хөвөрсөөр.

“2009 онд хөрөнгө оруулалтын гэрээ байгуулснаар Монгол Улс бизнест нээлттэйг дэлхийд баталж харуулсан” хэмээн Камерон МакРэй онцлоод, “Хэрвээ гэрээг өөрчлөхдөө тулбал монголчууд амлалтаа биелүүлдэггүй, хөрөнгө оруулагчдын аюулгүй байдлыг хангадаггүй гэх ойлголтыг олон улсад өгнө шүү дээ” хэмээн анхааруулга, асуулт зэрэг илгээжээ.

### Урагшаа биш, хойшоо хоёр алхам

Дэлхийн банкнаас гаргасан Монголын эдийн засгийн хоёрдугаар улирлын тойм тоон утгаараа үсрэнгүй хөгжил гэдгийг харуулах ажээ. Эдийн засаг 17.3 хувиар өссөн бол тээврийн салбар 39.9, барилга угсралтын ажил 38.4 хувиар эрчимжсэн байна. Гадаад худалдааны эргэлт ДНБ-ий хэмжээнээс ч хол давах болов.

“Гэхдээ энэ бүхэн хуурай тоо юм. Эдийн засгийн энэ их өсөлтөд уул уурхайн салбар ямар нөлөө үзүүлж байгааг харуулах нарийн судалгаа хэрэгтэй боловч алга. Таамаг бол байдаг. Тухайлбал, орон сууцны эрэлт хэрэгцээний 50 гаруй хувь нь уул уурхайн салбараас гарч ирж байгаа гэж байна” хэмээн МИН группийн ерөнхийлөгч Д.Жаргалсайхан онцолж байсан. Тэгвэл эдийн засгийн үсрэнгүй өсөлтийн зүтгүүр болсон эрдэс баялгийн салбар маань ямаршуу байна вэ?

“Discover Mongolia-2011” чуулганы эхний өдөр баялгаа ашиглан хөгжилд хүрэх арга замын талаар “Behre Dolbear” группийн ерөнхийлөгч Бернард Гуарнера илтгэл тавьсан нь олны сонирхлыг татаж байлаа. “Тодорхой бус байдлыг хөрөнгө оруулагчид үзэн яддаг” хэмээн тэрбээр байн байн цохон тэмдэглэх аж. 1911 оноос үйл ажиллагаагаа эхэлсэн тус групп эрдэс баялгийн чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг орнуудын эрх зүйн орчин, эдийн засгийн байдал, хүний нөөцийн чадавх, дэд бүтцийн хөгжил зэрэг уул уурхайн хөрөнгө оруулалт хийхэд нөлөөлдөг олон хүчин зүйлийг тусгаж, зүйл болгон дээр тусгай индекс гарган улс орнуудыг хооронд нь харьцуулдаг юм билээ. Энэ бүхний эцэст “Хаана хөрөнгө оруулж болохгүй вэ?” гэх хачин нэртэй судалгааны тайлангаа жил

► бүр гаргадаг. Өнгөрсөн онд Монгол Улс уг жагсаалтын наймдугаарт эрэмбэлэгдэж байсан бол энэ онд хоёр шат ухарч, аравдугаарт оржээ. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоо зогсоож, уул уурхайн малгай хуульдаа өөрчлөлт оруулах гэж байгаа нь манай уул уурхайн салбар урагшаа биш, хойшоо алхаж байгаагийн нэг тод жишээ билээ.

Эрүүл чийрэг уул уурхайн салбар улс оронд эд баялаг, хөгжил цэцэглэлтийг авчирдаг тухай Бернард Гуарнера онцлоод, “Харин эрүүл чийрэг уул уурхайн салбарыг зөвхөн татвар болон зохицуулалтын тогтвортой байдал л бий болгодог” гэв.

### Тулгын гурван чулуу

Д.Жаргалсайхан “Discover Mongolia-2011” чуулганы эхний илтгэлийг тавихдаа төр, иргэд, хөрөнгө оруулагч гэдэг нь уул уурхайн салбарын тулгын гурван чулуу болохыг тэмдэглэсэн.

Уул уурхайн ажил эрчимжиж байгаагаас Засгийн газрын орлого ч нэмэгдэж буйг улсын төсөв ашигтай гарч байгаагаас харж болно. Татвар, хураамж, ногдол ашгийн хэлбэрээр төр, засаг эрдэс баялгийн салбараас цаашдаа ч асар их орлого олох нь гарцаагүй. Оронд нь харин тогтвортой байдлыг л бизнес эрхлэгчдэд бий болгож өгөх хэрэгтэй. Оюутолгойгоос л гэхэд зөвхөн энэ онд авах татварын хэмжээ 300 сая ам.долларт хүрнэ гэсэн тооцоо байгааг Камерон МакРэй онцолсон юм.

Иргэдийн зүгээс уул уурхайн салбарт орж ирж буй энэ их хөрөнгө оруулалтаас хэрхэн ахиу хүртэх вэ гэдгээ бодох цаг иржээ. Өндөр цалинтай ажилд орж, өндөр ашигтай бизнес хийж чадах, эсэх нь зөвхөн монголчуудын идэвх санаачилгаас л хамаарах юм. Үүний хажуугаар Засгийн газар уул уурхайн орлогоо хэрхэн зөв зүйтэй зарцуулж байгаад хяналт тавих нь иргэдийн эрх төдийгүй үүрэг буюу.

Олон сая доллар зарцуулж хайгуул хийчихээд юу ч олохгүй бол хөрөнгө оруулагч хоосон цаас өвөртлөөд хоцрохоос өөр аргагүй. Олоод, олборлолоо гэхэд дэлхийн зах зээл дэх ашигт малтмалын үнэ ямар их хэлбэлзэлтэй байдаг билээ дээ. Ийм их эрсдэлийг үүрэхийн хажуугаар Монголд татвар төлж, ажлын байр бий болгож буй хөрөнгө оруулагч тогтвортой байдлыг нэхэх эрхтэй. Гэвч Монголын баялгийг олборлож л байгаа бол Монголын хуулийг чанд хатуу мөрдөх ёстой. Харин тэр бүх зохицуулалт нь

тодорхой, ойлгомжтой, тогтвортой байг.

ДНБ-ий 30, экспортын орлогын 90 орчим хувийг эрдэс баялгийн салбар бий болгож буй өнөө үед бид уул уурхай хэрэгтэй, хэрэггүй гэж маргах нь утгагүй хэрэг. Харин уул уурхайгаа дөрөөлөөд хэрхэн бүгдээрээ хөгжих вэ гэдэг л чухал билээ. Тиймээс ч ес дэх удаагийн “Discover Mongolia” чуулга уулзалтыг “Монголыг хамтдаа хөгжүүлэе” гэсэн уриан дор зохион

байгуулсан юм. Уг чуулганы төлөөлөгч 1500 гаруй хүн дээрх уриалгыг ч, уур амьсгалыг ч эрхэмлэсэн бас мэдэрсэн биз ээ.

Тулгын гурван чулуу хамтдаа байж гэмээнэ тогоо тавьж, хоол болно. Тэгвэл төр, иргэд, хөрөнгө оруулагч муур хулгана болж тоглох биш, нэг тийш харж, бие биеэ ойлгож гэмээнэ аль аль талдаа ашигтай ажиллаж, үр дүнд нь Монгол Улс хөгжих бус уу. ■

### Албаны хүний үг

## Б.Ариунсан:

## Төрөөс хөрөнгө оруулалтын таатай орчин бүрдүүлэх бодитой алхмууд хийж байна



*Уул уурхай, металлургийн салбарт хөрөнгө оруулагчдын олон улсын “Metals Mongolia-2011” чуулга уулзалт энэ оны арваннэгдүгээр сарын 3, 4-нд болно. Анх удаа Төрийн ордонд өндөр дээд хэмжээнд зохион байгуулах гэж буй уг хурлын талаар Эрдэс баялаг, эрчим хүчний яамны дэд сайд Б.Ариунсантай ярилцлаа. Тэрбээр чуулга уулзалтыг зохион байгуулах хорооны дарга юм.*

**-Уул уурхай, металлургийн салбарт хөрөнгө оруулагчдын олон улсын “Metals Mongolia-2011” чуулга уулзалтын бэлтгэл ажил хэрхэн хангагдаж байна вэ, ер нь чуулга уулзалтыг зохион байгуулах болсон зорилго нь юу вэ?**

-Чуулга уулзалтын бэлтгэл ажил үндсэндээ хангагдсан гэж хэлж болно. Оролцох хүмүүстээ урилга хүргүүлж, илтгэл тавих хүмүүс маань илтгэлээ бэлтгэж байна. Олон улс орны төлөөлөгчид оролцохоор саналаа

ирүүлж байна.

Гол зорилго бол Монгол Улсад металлын аж үйлдвэрийг хөгжүүлэх, ингэснээр улс орны хөгжлийг түргэтгэх явдал юм. Манай орон эрдэс баялгийн арвин нөөцтэй. Түүний дотор нүүрс, төмрийн хүдэр, зэс, молибден, алтны үндсэн орд төдийгүй, газрын ховор элементийн ордууд ч илэрч байна. Сүүлийн жилүүдэд ашигт малтмалын олборлолт, экспортын хэмжээ огцом нэмэгдсэн. Гэхдээ уул уурхайн олборлох, баяжуулах үйлдвэрлэл ►

ажлын байр төдийлөн нэмэгдүүлдэггүй. Тэгвэл хүнд аж үйлдвэрийн салбар нь дэд бүтэц, хөрөнгө оруулалтын хөгжлийг шаарддаг. Үүнийг дагаад олон тооны ажлын байр бий болж, улс орны өрсөлдөх чадвар нэмэгддэг. Иймээс Монгол орон боловсруулаагүй түүхий эдийг нийлүүлэх бус нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүнийг экспортлох баримжаатай, металлургийн цогцолборыг хөгжүүлэх чиглэл рүү явах шаардлага байгаа бөгөөд төр гол анхаарлаа үүнд хандуулж байна. Монгол Улс ашигт малтмалыг олборлох, баяжуулах үйлдвэрлэлээс металлургийн үйлдвэрлэл рүү шилжиж буй хариуцлагатай үе тохиож байна.

Энэ чуулга уулзалтаар тодорхой боломжит металлургийн үйлдвэрлэлийн төслүүдийг хөрөнгө оруулагч нарт танилцуулах, мөн ирээдүйд хэрэгжих төслүүдэд хүн, байгаль орчинд хамгийн хал багатай шилдэг технологи эзэмшигч олон улсын нэр хүнд бүхий компаниудын танилцуулга, мөн энэ төслүүдийг хэрэгжүүлэхтэй холбоотой ямар асуудлууд урган гарч байгаа зэрэг олон зүйлийг цогцоор нь ярилцахыг зорьж байна.

**-Та сая олборлох, баяжуулах үйлдвэрлэлээс металлургийн шат руу шилжиж буй хариуцлагатай үе тохиож байгааг онцоллоо. Үнэхээр ч эрдэмтэн, судлаач бүр энэ чиглэл рүү явах цаг болсон гэдэгтэй санал нийлж байна.**

**Чуулга уулзалтыг анх удаа зохиож байгаа гэдгээр нь хэр ач холбогдол өгч байна вэ?**

-Уг чуулга уулзалтад аж үйлдвэрийн салбарыг эх орондоо амжилттай хөгжүүлсэн Япон, Солонгос, Энэтхэг, Европын улс орнууд болон манай хоёр хөрш, мөн манай улсшиг далайд гарцгүй, ашигт малтмалын ихээхэн нөөцтэй бөгөөд аж үйлдвэрийн салбарыг амжилттай хөгжүүлж буй Казахстан улсын төлөөллөөс гадна металлургийн үйлдвэрлэлийн технологиор дэлхийд тэргүүлэгч компаниуд оролцож байна. Тухайлбал, металлургийн үйлдвэрлэлийн технологиор дэлхийд тэргүүлж яваа Финляндын "Outotec" компани саяхан манай яамтай хамтарч ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан. Энэ компани чуулга уулзалтын ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаж байгаа. Мөн мэргэжлийн холбоод оролцон саналаа хэлнэ. Манай төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүд оролцоно. Гол нь эндээс бид

металлын үйлдвэрлэлийг Монголд ямар байдлаар хөгжүүлбэл илүү үр дүнтэй вэ гэдгийг ярилцаж хэлэлцэх юм. Мэдээж бид анхны хурлаар бүх зүйлийг шийдчихнэ гэж хэлж чадахгүй. Гэхдээ энэ бол маш том эхний алхам байх болно.

**-Металлургийн үйлдвэрлэлтэй дэд бүтцийн асуудлыг хэрхэн уялдуулах вэ?**

-Засгийн газраас Сайншандын аж үйлдвэрийн цогцолбор байгуулна гэж байгаа. Сайншандын аж үйлдвэрийн цогцолборт ямар үйлдвэрүүд байж болох талаар олон улсын нэр хүнд бүхий зөвлөх компаниуд судалгаа хийж байна. Энэ оны арванхоёрдугаар сард тайлан бэлэн болно. Манай улсын төмөр замын бодлогод Өмнийн говь дахь уурхайнуудыг Сайншандтай төмөр замаар холбоод цаашлаад ОХУ руу холбох гэж байгаа. Холбогдох бодлогын бичиг баримтууд батлагдан дэд бүтэц байгуулах ажлууд хийгдэж эхэлж байна. Үе шаттайгаар хэрэгжинэ. Гэвч энэ нь нэлээд цаг хугацаа авах том төсөл.

Тэгвэл дэд бүтэц нь хөгжсөн, хүнд үйлдвэр байгуулах боломжтой Дархан, Эрдэнэт, Багануур, Чойр гээд бүс нутгуудад ойрын үед металлургийн үйлдвэр хөгжүүлэх боломж байна гэж манай яам үзэж байгаа. Жишээ нь Дархан, Сэлэнгийн бүсийн төмрийн хүдрийн ордыг түшиглээд хар төмөрлөгийн цогцолбор, Эрдэнэтэд зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр байгуулах боломжтой.

**-Хөрөнгө оруулалт татахын тулд тогтвортой хууль эрх зүйн орчин хамгийн чухал шүү дээ.**

-Сүүлийн үед манайд уул уурхайн салбарт асар их хэмжээний хөрөнгө оруулалт орж ирж байна. Энэ нь манайд хөрөнгө оруулалтын орчин ямар байгаагийн нэг жишээ. Дэлхийн зах зээл дээр уул уурхайн бүтээгдэхүүний ханш өндөр байгаа, дээрээс нь манай орон Азидаа хамгийн бага татвартай улсын тоонд тооцогддог тул хөрөнгө оруулалт олборлох салбарт их орж байна. Харин металлургийн үйлдвэр асар их хөрөнгө оруулалт шаарддаг, мөн урт хугацаанд үр ашгаа өгдөг тул хөрөнгө оруулагчид хууль эрх зүйн таатай, тогтвортой орчинг хүсэмжилдэг.

Төр, засгийн зүгээс тодорхой бодит алхамуудыг хийж байна. Жишээ нь өмнө нь уул уурхайн бүтээгдэхүүнийг экспортлоход НӨАТ-ын буцаалт хийдэг байсан. Өнгөрсөн онд хийсэн хуулийн

өөрчлөлтөөруулурхайн бүтээгдэхүүнд НӨАТ-ын буцаалт хийхгүй, харин нэмүү өртөг шингэсэн болон эцсийн гэгдэх 17 бүтээгдэхүүнд л уг татварын буцаалт хийдэг болсон. Мөн шинээр батлагдсан ашигт малтмалын зах зээлийн үнээс хамаарсан өсөн нэмэгдэх роялтын татвар гэж бий. Үүн дээр шаталсан гурван татвар тавьж өгсөн. Тэр нь юу вэ гэвэл, хэрэв Та ашигт малтмалыг түүхийгээр нь экспортолбол өндөр татвар төлнө, баяжмал болговол арай бага татвар төлнө, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэвэл бүр бага татвар төлнө гэсэн зохицуулалт юм. Цаашлаад Үйлдвэр технологийн паркийн тухай хуулийг УИХ-аас баталсан. Энэ хуулийн дагуу тодорхой бүс нутагт хүнд үйлдвэр байгуулбал зургаан төрлийн татварын хөнгөлөлт үзүүлэхээр болсон.

**-Нөгөө талаас гаднын хөрөнгө оруулагчдад найр тавьж, хууль эрх зүйн орчноо хэт зөөллөх юм бол монголчуудын олох ашиг багасна гэсэн шүүмжлэл, болгоомжлол байна. Энэ талаар Та ямар бодолтой байна вэ?**

-Хэт их татвар тавихаар хөрөнгө оруулагчид өөр оронд хөрөнгө оруулалт хийх боломжууд үүсчихдэг. Тиймээс балансыг нь барих хэрэгтэй. Ялангуяа боловсруулах үйлдвэр маш олон ажлын байр бий болгодог. Жишээ нь зэсийн баяжмал хайлуулах үйлдвэр баригдлаа гэхэд түүнээс гарсан бүтээгдэхүүнийг дахиад цааш нь боловсруулах төрөл бүрийн жижиг, дунд үйлдвэрүүд хөгждөг. Хар төмөрлөгийн үйлдвэр гэхэд л аж үйлдвэр хөгжих үндэс болдог. Үүний жишээ бол БНСУ-ын хөгжил юм.

**-Манай улс металлургийн үйлдвэрлэлийг хөгжүүлж чадсан бусад орны хэмжээнд хэзээ хүрэх боломжтой вэ?**

-Монголд дэлхийн хэмжээний том ордууд нээгдэж байна. Цаашид ч нээгдэх боломжтой. Зөв бодлогоор хөгжүүлж, зохицуулж чадах юм бол металлургийн үйлдвэр олноор байгуулагдаж, Монгол орон асар хурдан хөгжих болно. Яг ямар үе шатаар хүнд үйлдвэрлэл хөгжүүлэх вэ гэдгийг манай яам Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороотой хамтран судалгаа хийж, төлөвлөгөө гаргаж байгаа. Чуулга уулзалтын үеэр ч энэ сэдвээр санал солилцож дэлгэрэнгүй ярилцана.

**-Ярилцсанд баярлалаа.**

-Баярлалаа. Чуулга уулзалтад идэвхитэй оролцохыг уриалж байна. ■



Фотог Б.Бямба-Очир

Нэг өдөр

## Зөв газраа зөрүүд зангаа гаргаж яваа хүн

*Манай сэтгүүл энэ дугаараас эхлэн “Нэг өдөр” булан нээж байна. Анхны зочноороо “Нийслэлийн хөрөнгө оруулалтын газар”-ын дарга Б.Төмөрчулууныг урьж, түүний нэг өдөр хэрхэн өнгөрдгийг сонирхлоо. Тэрбээр “Сэргэн мандалт” группын үүсгэн байгуулагч бөгөөд НИТХ-ын гишүүн. Эннэ өдрийн зочинтой хамт манай сэтгүүлч Э.Зоригт байлцсан юм.*

2011.09.29. 07:05 цаг

Өглөөний цэнгэг агаарт Б.Төмөрчулуун орчныг тольдон алхана. Хэдийгээр зүгээр л агаарт зугаалж байгаа мэт боловч үнэндээ тэрбээр өдрийн ажлын дэс дарааллаа толгойныхоо сэргэг дээр тунгаан байгаа нь энэ. Тэрбээр эрт босох, эрүүл байх гэдэг нь их ажил амжуулахын үндэс хэмээн үздэг. Хэрвээ түүний өмнө шидтэн гарч ирээд “Чи гурван хүслээ хэл” гэвэл хамгийн түрүүнд “Эрүүл байхыг л хүснэ дээ” гэсэн юм.

07:15 цаг

Б.Төмөрчулуун даргын гэрийнх нь том өрөөний нэг талын хана нь бурхдаар дүүрэн. Үйл болоод бодол энэ орчинд уусан сэтгэл тайвшрах шиг. Гэрийн эзэн өглөө бүр тэрхүү бурхадыхаа өмнө “Эх болсон зургаан зүйл, алив амьтны тусын тулд” хэмээн сүсэглээд гардаг.

07:25 цаг

Тэрбээр энэ өдрийн ажлынхаа жагсаалтыг харан зарим зүйлийг утсаар амжуулж, Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын зүг яарна. “Нэг өдрийн ажлын төлөвлөгөөгөө юу хийх ёстой вэ гэдгээ жагсаагаад бичихдэг. Жагсаасан ажил өөрөө байрлалаа олчихно. Цаг минутаар нь төлөвлөөд байдаггүй” гэж сонирхуулсан юм.

07:45 цаг

Бичиг цаас овоолсон ширээний ард суусан даргын энэ өдрийн албаны ажил эхэлнэ. Түүний хамгийн их хийдэг ажил нь гарын үсэг зурах. “Өдөрт дунджаар 130-150 гарын үсэг зурдаг. Зарим ачаалалтай үед үүнээс ч их зурна. Гэхдээ гарын үсэг зурах гэдэг зүгээр нэг нэрээ бичих хэрэг биш юм. Ямар агуулгатай хэнд хэрэгтэй гэдгийг сайтар нягтлах хэрэгтэй. Хэрвээ хайнга хандаж, Улаанбаатар хотод минь хэрэггүй ажлын гэрээнд гарын үсэг зурчихвал яана” хэмээн тэрбээр ярих.. ➤

► Өдөрт 300 төгрөгийн үнэтэй бал гурван ширхэгийг дуусгачихдаг байна. 300 төгрөгийн бал тасалдахгүй сайн гардаг гэсэн шүү. 1990-ээдоноос хойш цуцашгүй хөдөлмөрлөж Монголын томоохон группуудын нэгийг байгуулан бизнесмэн явсан энэ эр эд материалын сонирхол туйлын бага бөгөөд бөгж, түрийвч, цүнх тэр ч бүү хэл бугуйн цаг хэрэглэдэггүй. “Брэнд” гэх ойлголтыг хий хоосон зүйл хэмээн үзэх бөгөөд харин монгол уламжлалаа илүү хүндэлдэг. Зөв газраа, зөв цагт үндэснийхээ дээл хувцсаар гоёх дуртай. Сүүлийн үеийн залуус уг үндсээ мэдэхгүй гаднын соёлыг илүүд үзэх нь түүний сэтгэлийг их зовоодог байна. Шидтэнд хэлэх хоёр дахь хүсэл нь “Монгол залууст хэрсүү ухаан, суурь хүмүүжил олгооч” хэмээн хүсэх аж. Гэхдээ “Хүссэн бүгдийг биелүүлээд байдаг шидтэн байсан бол амьдрал утгагүй. Хүн өөрөө зүтгэж, өөрийн гэсэн ухамсартай байж гэмээнэ амьдралын үнэ цэнэ оршдог” гэсэн юм. Хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурахдаа “Нийслэлд ямар ашигтай, тэр дундаа залууст хэр өгөөжтэй” гэдгийг түлхүү анхаардаг. Залуус гэдэг “Эх орны хойч үе. Тиймээс тэд зүгээр нэг гангараа, аль эсвэл дайчилгаа огт биш” гэлээ.

### 10.00 цаг

Хэд хэдэн хуралд оролцох, зарим ажилтай танилцахаар явах, шалгах гээд хоолойгоор татсан ажилтай байлаа. Гэхдээ тэрбээр албаны энэ их ажлын хажуугаар эмнэлэгт хэвтсэн найзыгаа эргэхээ мартаагүй. Хамгийн ач холбогдол өгдөг хурал нь 15.00 цагаас НИТХ-ын гишүүд, иргэдийн санал гомдлыг сонсох. Хэчнээн чухал ажилтай байсан ч уг хурлыг тасалдаггүй. Тэрбээр “Ард түмэн миний номын сан. Тиймээс тэднийхээ үзэл бодлыг сонсож, амьдралд нь ойр байхыг хичээдэг” гэв.

### 16.30 цаг

Түүний ажил үргэлжилсээр... Ямар нэг ажил хийх бүртээ “би хаана, хэзээ ард иргэддээ хэрэгтэй юу хийж чадах вэ” гэдэг асуултыг өөртөө тавьж ажилладаг. Ажлын дараа гэртээ амарч байсан ч “Би хөршийнхөө төлөө юу хийж чадах вэ” гэдгийг бодож, түүнийгээ амьдралд хэрэгжүүлдэг гэсэн шүү.

### 17.15 цаг

Тэрбээр төлөвлөсөн ажлаасаа одоогоор өдрийн хоолонд орох, найзыгаа эргэх хоёрыг л амжуулж чадаагүй явна.

### 19:30 цаг

Хэдийгээр хөдөлмөрийн гэрээнд тусгасан түүний ажлын цаг дууссан ч ажилласаар. Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрынхаа ажилтнуудаа урамшуулах талаар хуралдаж буй нь энэ. Хэнд орон сууц өгөх талаар удаан хуралдсаны эцэст шийдвэр гарлаа. Уг шагнал эздээ олжээ. Төмөрчулуун дарга энэ баярт мэдээг шагналын эздэд баяртайгаар дуулгаж байв.

Төмөрчулууныг анд нөхөд нь “Ажлын төлөө төрсөн нэгэн” зарим нь “Өглөөний хүн” гэх нь ч бий. Зах зээл дөнгөж эхэлж байсан тэр үед л “Сэргэн мандалт” группыг үүсгэн байгуулсан бөгөөд өдгөө төрийн хар хүн болсондоо сэтгэл хангалуун явна. Тэрбээр “Би зөв цагтаа, зөв газраа зөрүүд зангаа гаргаж яваа хүн” хэмээн өөрийн хийж буй төрийн ажилдаа сэтгэл хангалуун явдаг. Үнэхээр түүний буруу үйлийн эсрэг зөрүүд занг хэн ч дийлдэггүй аж.

### 19:40 цаг

“Их тэнгэр” цогцолборт орших гэрийнхээ зүг яарна. Гэрийнхээ хийсэн гурилтай шөлийг иднэ гэхээс сайхан санагдана. Өнөөдөр их ажлын хажуугаар түүнд өдрийн хоол идэх зав ч гараагүй билээ. Хэдийгээр энэ мэт ажил ихтэй байдаг ч ажил, амьдрал зэргийн донжийг олоод байж болдог юм гэх.

### 20:10 цаг

Цас зөөлөн хаялж, орчин тойрон намуухан агаад сэтгэл татам. Гэрийн гэртээ орохоосоо өмнө байшингаа тойрон өдрийн хийсэн ажлаа дүгнэн халаасандаа гараа хийн зөөлөн алхална. Тогтсон энэ уламжлалаа тэр хэзээ ч зөрчдөггүй. Шөнийн хэдэн цагт ажил нь дууссан ч бай хамаагүй өдрийн хийснээ дүгнэн алхдаг. Тэрбээр өдгөө 50 насыг зооглохдоо өдөр өдрийн ажлаа дүгнэсээр өдгөө өөрийнхөө тухай “Ард олонд таашаагдах хэмжээний санал надад бэлэн байгаа” хэмээн бодно.

### 20:20 цаг

Гэрийн эзний ёсоор хоймортоо заларч, гэргийнхээ хийсэн гурилтай шөлийг амтархан идэж, их ажилд дарагдсан ядаргаа нь гарч, магнайд нь хөлс дааварлах ажээ. МҮОНТ-ийн оройн мэдээг үзэж цаг үеийн мэдээллээс ч хоцрохгүйг эрмэлзэнэ.

### 22:30 цаг

Өөрийн сэтгэлд бууж, бодолд өнжсөн үгсийг тэрбээр тэмдэглэлийнхээ дэвтэрт бичнэ. Таны хамгийн үнэтэй өв юу вэ гэхэд “Миний сүүлийн 30 жилд хийсэн хамгийн том ажил гэвэл өдрийн тэмдэглэлээ л хэлэх байна. Энэ чинь тэр чигээрээ л би гэсэн үг” гэв. Тэрбээр яруу найраг бичдэг бөгөөд эцэг өвөгдөөс уламжилж ирсэн эх хэлний өв соёлыг хадгалж үлдэх нь түүний чин хүслэн юм.

### 22:50 цаг

Өнөөдөр анхны цас орлоо. Эргэн тойрон нимгэн цасанд хучигдан хорвоо дөрвөн улирлын өнгөөр солонгорно. Шөнийн тэнгэрт одод анивалзаж, Төмөрчулуун унтлагынхаа өрөө рүү явлаа. Тэрбээр зүүдний ертөнцөд хүртэл ажилладаг нэгэн. Учир нь, түүний зүүд зөнтэй байдаг аж. Тухайлбал, “Өчигдөр би бурхан зүүдэлсэн, маргааш бурхан аравнайлах ёслолд явахаар болчихсон” гээд инээнэ.

Та сайхан амраарай.

...Хайр гэрэлтсэн ээжийнхээ инээмсэглэлд хөтлөгдөөд  
Ханагар сайхан аавынхаа харцанд хайрлагдаад  
Хаана ч байхгүй урсгал зөөлөн Монголдоо  
Хаврын шувуудтай уяран хайлж, урсаж ирнэ дээ...  
Б.Төмөрчулууны шүлэг, Д.Чулууны ая, С.Жавхлангийн дуулсан “Монгол дуудлага” дууны хэсгээс ишлэв. Энэ мэт үгийн урнаар сэтгэлээ хөглөж өдөр өдрийн нарыг бардам туулж яваа “Өглөөний хүн” хочит Б.Төмөрчулууны ажил, амьдрал үргэлжилсээр. ■



Компанийн нийгмийн хариуцлага

# Нийгмийн хариуцлага “урт нас бэлэглэнэ”

Та нийгмийн хариуцлагаа (КНХ) ухамсарласан уу, ер нь нийгмийн хариуцлага гэж юуг ойлгох ёстой вэ, тэгвэл компаниуд энэ чиглэлээр юу хийх ёстой, Засгийн газраас энэ ойлголтыг хэрхэн дэмжих ёстой юм, дэлхий дахинаа дээрх асуудал хэр хөгжиж байгаа гэх мэтчилэн цуварсан асуултад Та тодорхой ямар хариу өгөх вэ. Компанийн нийгмийн хариуцлага нь дэлхийд нэлээд өндөр түвшинд хөгжиж байгаа бол манай улсад дөнгөж эхлэлийн л шатандаа яваа аж. Тиймээс Монголын компаниуд нийгмийн хариуцлагаа ойлгодоггүй, ойлгохыг хүсдэггүй, бага зэрэг ойлголттой хэсэг нь урлаг соёлынхныг дэмждэг ажлаа нийгмийн хариуцлага гэж тайлагнадаг болж хувирчээ. Үнэндээ бол КНХ нь өнөө үед шал өөр ойлголт ажээ.

“Өрсөлдөх чадвар ба компанийн нийгмийн хариуцлага, хариуцлагаа ухамсарласан аж ахуйн нэгжүүд эдийн засгийн тогтвортой хөгжлийн төлөө юу хийх ёстой вэ?” сэдэвт олон улсын бага хурал болсон юм. Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор өрнөсөн энэхүү хурлыг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /ГОУХАН/ийн Эрдэс баялаг, түүхий эдийн

иж бүрэн санаачлага хөтөлбөрөөс холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан бөгөөд “Mongolian Economy” сэтгүүл мэдээллийн түншээр оролцов.

Намрын өнгө бүхий алтан шар навчис хөлд хөглөрөх нь тусгай хамгаалалттай “Их тэнгэр” цогцолбор бүсийн байгалийн өнгийг улам тодосгож харагдуулна билээ. Намрын налгар өдрүүд их л урт үргэлжилдэг байсан сан гэж өнгөрсөн цаг дээр ярьдаг болсон нь эдүгээгийн он цагийн солигдлоор уур амьсгалд өөрчлөлт орж байгаатай холбоотой юм. Монголд компанийн нийгмийн хариуцлагыг хөгжүүлэх тухай ярилцсан есдүгээр сарын энэ хоёр өдөр ч уур амьсгалын өөрчлөлтийг мэдрүүлэх мэт сэрүүхэн байв. Энэхүү арга хэмжээнд оролцохоор компанийн нийгмийн хариуцлагыг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж яваа, мэргэжлийн хүмүүс тэртээ холоос манай орныг зорин иржээ.

Хурлын эхэнд Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга Д.Баттулга “Хамгийн гол нь өнөөдөр монголчууд бидний өрсөлдөх чадвар сайнгүй байна. Монголд хуулийн засаглал сул, төрийн оролцоо их байгаа нь асуудал юм. Нөгөө талаар ойр зуурын ашиг

хөөцөлдсөн аж ахуйн нэгжүүдээс болж, хэрэглэгчид хохирч, байгаль орчинд нөхөж баршгүй хохирол учирч байна. Тийм учраас эдийн засгаа хөгжүүлье гэж ярихын зэрэгцээ төр, засгаас барьж байгаа бодлого байгальд ээлтэй байх ёстой. Бид хойч үеийнхнийхээ уух усаар алтаа угаамааргүй байна. Өнөөдөр эдийн засгийн их ашиг амласан төслүүд байгаль орчинд ээлгүй байх аваас бид татгалзаж чаддаг байх ёстой. Тиймээс нэн тэргүүнд байгальд ээлтэй менежмент, техник технологийг оруулж ирэх нь Монгол Улсын тогтвортой байдлыг хангах түүнчлэн компанийн нийгмийн өмнө хүлээх үүргийг өндөржүүлж байгаа хэрэг юм. Өрсөлдөх чадвар гэдэг бол түр зуурын үзэгдэл биш. Энэ нь урт удаан хугацаанд компанийн оршин тогтнох эх үндэс, байгаль орчны эрүүл өсөлт гэж ойлгож байгаа” хэмээн ярьсан нь төлөөлөгчдөд нэгийг бодогдуулсан болов уу.

Учир нь, манай компаниуд хэдэн төгрөг гаргаад ямар нэг урлаг, соёл, спортын арга хэмжээг ивээн тэтгэх, эсвэл нутагтаа сүм дугана барьж, суварга босгохыг компанийн нийгмийн хариуцлага гэж ухамсарладаг. Иргэд нь ч тухайн компаниас мөнгө гуйгаад ▶▶

өгөхгүй бол нийгмийн хариуцлагагүй гэх. Өнөөдөр бид энэ ойлголтоос салах хэрэгтэй болжээ. Монголын компаниудын дунд хийсэн нийгмийн хариуцлагын талаарх судалгаагаар 24,8 хувь нь сайн, 28 хувь нь муу, 4,8 хувь нь маш сайн, 14,9 хувь маш муу хэрэгжүүлж байна гэсэн мэдээлэл ирлээ. Мөн манайх жижиг компани учраас нийгмийн хариуцлага бидэнд хамаагүй, том компаниуд л хийдэг гэсэн төөрөгдөл байгааг хүмүүс дурдаж байсан. “Жижигхэн компани ч юм хийж болно. Гэхдээ үүнийг яаж хийх талаар хичээл зүтгэл дээр тулгуурласан зохицуулалт хийх хэрэгтэй. Бид дарамт шахалтаар биш сайн дураар нийгмийн хариуцлагаа ухамсарлах ёстой. Өөрсдийн шинэ бодлогоо боловсруулах нь чухал. Өнөөдөр нийгмийн хариуцлага биелүүлж чадахгүй байгаа төр, компаниудаас нийгмийн хариуцлага шаардах хэрэггүй” гэж МҮХАҮТ-ын дарга С.Дэмбэрэл онцлон ярьсан.

Ер нь бол КНХ-ын тухай нэгдсэн томъёолол дэлхийд ч байдаггүй юм байна. Өөрөөр хэлбэл, улс орон, бүс нутаг, компани, байгууллагууд нийгэмд ямар үүрэг гүйцэтгэж, ямар эрх эдлэх ёстой болохоо өөрсдөө тодорхойлдог аж. Харин энэ асуудлын нийтлэг үндсэн элементүүдийн хүрээнд шударга хөдөлмөрийн стандарт, байгаль орчны нөлөөлөл, нийгмийн хөрөнгө оруулалт, салбар хоорондын хамтын ажиллагаа, авлига, хээл хахуулийн эсрэг тэмцэл, тунгалаг байдал, хувьцаа эзэмшигчдийн хүлээх санхүүгийн хариуцлага зэрэг багтдаг хэмээн ойлгож болох нь. Эндээс Та КНХ нь маш өргөн хүрээг хамардаг асуудал болохыг харж байна. Зөвхөн компаниудын л хийх ажил биш аж.

Засгийн газраас КНХ-ыг хөгжүүлэх хөшүүрэг, эрх зүйн орчныг бий болгох замаар дэмжиж ажиллах нь хамгаас чухал гэдэгтэй мэргэжилтнүүд санал нэгдэж байлаа. Өөрөөр хэлбэл, төр, засаг өөрөө хариуцлагаа ухамсарлаж, дорвитой ажил хийх ёстой аж. Засгийн газрын хийх гол ажил бол КНХ-тай холбоотой үндэсний стратегийг хамтран боловсруулж, хамтран хэрэгжүүлэх, хариуцлагатай компанийг урамшуулах, олон хувьцаа эзэмшигчдийн уулзалт, хэлэлцээрийг дэмжих, төрийн байгууллагуудын хариуцлагын бодлого хөтөлбөрийг

боловсруулахад чиглэх аж. Харин бизнесийн байгууллагын үйл ажиллагаа нь зөвхөн бизнес эрхлэхээс илүү өргөн хүрээг хамрах ёстой гэнэ.

“Компаниуд зөвхөн хууль дагаж, бусдыг ивээн тэтгэх байр сууриа өөрчилж, байгаль орчин болон нийгмийн асуудлуудыг идэвхтэй шийдвэрлэхэд анхаарлаа хандуулах цаг болсон. Нийгмийн сайн сайхан байдлыг сайжруулахад чиглэсэн ашигтай бүтээгдэхүүн, үйлчилгээг ханган нийлүүлэх, олон нийтэд стратегийн хөрөнгө оруулалт хийх, үндсэн үйл ажиллагаандаа хариуцлагатай болон ухамсартай зан үйлийг төлөвшүүлэх шаардлагатай” гэж Германы компанийн засаглалын төвийн удирдах зөвлөлийн гишүүн Михаел Бюрш тэмдэглэсэн билээ.

“Пийбоди” компанийг нийгмийн хариуцлагаар тэргүүлэгч гэж дэлхий дахинаа үздэг. Тус компанийн эрхэм зорилгод “Уурхайн олборлолт дуусахад бид тухайн газар нутгийг анх ямар байсан тэр хэмжээнд эсвэл түүнээс илүү нөхцөлд сэргээх” хэмээн тусгасан байдаг ажээ. Эдний эдийн засгийн үр өгөөж жилдээ 16 тэрбум ам.долларт хүрчээ. 2010 онд 6.9 гаруй тэрбум долларыг орон нутгийн байгууллага, үйл ажиллагааг дэмжих болон буяны үйл хэрэгт зарцуулсан байна. Компанийн шилдэг сайн засаглал бүхий арга ажиллагааны үндэс суурь нь үйл ажиллагаа ба ёс зүйн хатуу, чанд дүрэм журамтай нь холбоотой гэнэ. Санхүүгийн мэдээллийн хувьд шуурхай, зөв мэдээллийг түгээдэг туршлагатай аж.

“Манайх Монгол Улсад анх удаа нүүрсний уурхайн талбайн нөхөн сэргээлтийг чиглүүлж ажиллалаа. Монгол Улс нь нийгмийн хариуцлагын дэлхийн түвшинд боловсруулсан стандартыг буй болгоход тус дөхөм болохуйц хосгүй байршилтай. Компани болон нийгмийн хариуцлагын загварыг боловсруулахад “Пийбоди”, түүнтэй ижил төстэй компаниуд дэлхийн хэмжээнд загвар болохуйц туршлагаасаа хуваалцах боломжтой. Аюулгүй ажиллагаа, сургалт, технологи, хүрээлэн буй орчин ба орон нутаг, иргэдийн хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд шилдэг, тэргүүний стандартыг буй болгох нь зүйтэй” хэмээн “Пийбоди” группийн Монгол Энэтхэгийг хариуцсан захирал Аршаед Сайед

хэлсэн билээ. Хэлэлцүүлгийн үеэр хуралд оролцогчдоос авууштай олон санал гарсан. Олон төлөөлөгч КНХ чиглэлээр сургалт, семинар хийх нь чухал юм байна гэсэн бол зарим нь нийгмийн хариуцлагын талаарх зөв ойлголтыг хүүхдүүддээ өгөх замаар хөгжүүлж эхэлье хэмээн санал бодлоо хуваалцаж байсан юм.

“Нийгмийн хариуцлагын зөв хөгжил үнэхээрийн танаас, таны үр хүүхдээс эхэлнэ. Бизнес эрхлэх нь дэлхий дахинаа улам л үнэ цэнэтэй болж байна” гэхэд “Монголын компаниуд КНХ-д илүүчлэх мөнгө алга байна. Тийм хэмжээнд хүртэл мөнгөтэй болоогүй байна шүү дээ” гэх оролцогчид ч байв.

КНХ-ыг хөгжүүлэхэд олон асуудалтай тулгарна. Гэхдээ та энэ нэр томъёог зөвхөн мөнгөний нүдээр бус өөр өнцгөөс нь хараад нэг үзээрэй. КНХ нь тухайн байгууллагад, компанид яагаад хэрэгтэй вэ гэвэл ерөнхийдөө урт хугацаанд компани ашигтай, тогтвортой ажиллая гэвэл хэрэглэгч, оршин суугч, хүрээлэн байгаа орчин, орон нутаг, улс үндэстний эрх ашгийг ямарваа нэгэн хэмжээгээр хүндэтгэж ажиллаж байж ашиг олох нь хамгийн чухал юм байна. Ингэж ажилладаг компанийн нэр хүнд дээшилнэ, нэр хүнд дээшлэхээр нийгэмд байр сууриа олж, өсөлт хөгжил нь ирээдүйд хангагдах боломж бүрдэх үр дүнд хүрдэг ажээ. Ийнхүү тус хурлын үеэр ярьсан асуудлуудын гол утгыг базаж хэлэхэд ийм байна.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг, түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрөөс КНХ-ын чиглэлээр энэхүү хурал дээр тавьсан олон сонирхолтой илтгэл болон хүмүүсийн яриаг эмхэтгэн компаниудад, олон нийтэд хүргэхээр ажиллаж байгаа бол манай сэтгүүлийн хувьд ч “Компанийн нийгмийн хариуцлага” булан нээж, энэ чиглэлээр туршлага, мэдлэгтэй хүмүүсийн үгийг хүргэх, нийгмийн хариуцлагаа ухамсарлан ажиллаж буй компани, байгууллага, хувь хүмүүсийг сурвалжлах, олон нийтэд танилцуулах юм. Та өөрийгөө, байгууллагаа компаниа нийгмийн хариуцлагаа ухамсарлан ажиллаж байгаа гэж үзвэл манай сэтгүүлд хандаарай. Энэхүү хурлын үеэр зарим төлөөлөгчийн бодлыг сонссон юм. ▶

## ► Та компанийн нийгмийн хариуцлагын талаарх ойлголтыг юу гэж үздэг вэ?

### Билл Горман /Монголын хөрөнгийн биржийн ерөнхийлөгч/:

-Уул уурхайд шаардлагатай гадаадын хөрөнгө оруулалт орох тусам тухайн улс улам баян чинээлэг бус харин ядуурал нэмэгдэх дүр зураг байдаг. Энэ нь байгалийн эрдэс баялгаар арвин хэрнээ эдийн засгийн гүйцэтгэл нь тааруу байгаа орнуудад ажиглагдсаар байна. 2002 оны Дэлхийн банкны судалгаагаар 1990-ээд оны үед экспортод эзлэх уул уурхайн хувь хэмжээ нь 50 хувиас их улсуудын нэг хүнд ногдох ДНБ-ий хувь хэмжээ жилд 2,3 хувиар уруудаж байсан байна. Ийм баялгийн хараалаас Монгол Улсыг зайлж гарахад компанийн нийгмийн хариуцлага л тусална. КНХ-ыг хөгжүүлэхийн тулд бизнес үйл ажиллагааны болон ёс зүйн дүрмийг боловсруулж мөрдүүлэх хэрэгтэй. Мөн ажиллагсдын аюулгүй ажиллагаа, эрүүл мэнд, ажиллах орчин болон боловсролын асуудалд анхаарах, уурхайн олборлолт явуулж буй газар нутгийн ард иргэдтэй нягт харилцаа холбоо тогтоох, үйл ажиллагаанаас үүдэж хүрээлэн буй орчинд үзүүлж болох сөрөг нөлөөллөөс сэргийлэх, тэдгээрийг арилгах ёстой. Эдгээр үйл ажиллагааг хэрэгжүүлснээр амжилтад хүрэх боломжтой.

### Б.Мандалбаяр: /“Дарханы дулааны цахилгаан станц”-ын гүйцэтгэх захирал/

-Дарханы цахилгаан станц нь Монгол Улсын гуравдагч том цахилгаан станц. Цахилгаан станцын өмнө хүлээж байгаа нийгмийн хариуцлага бол асар их. Ард түмнээ цахилгаан, дулааны эрчим хүчээр тасралтгүй хангах түүхэн үүргийг 46 дахь жилдээ бид гүйцэтгэж байна. Манай ажилтнууд үүргээ бүрэн ухамсарлаж, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг. Компани бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор тусгай хөтөлбөр хэрэгжүүлээд дөрвөн жил боллоо. Энэ хөтөлбөрийн үр шимээр бид Японы бүтээмжийн байгууллагатай хамтран ажиллаж, өөрийн үйл ажиллагааны түвшинг дээшлүүлсэн. Нийгмийн хариуцлага гэдэг нь бол манай станцын хувьд тогтвортой найдвартай ажиллах шүү дээ. Тиймээс чанарын удирдлагын иж бүрэн тогтолцоо болон Европын стандартыг нэвтрүүлэх асуудлыг компанийнхаа эрхэм зорилго болгон ажиллаж байна.

### А.Оюунчимэг: /Инкомнэт компанийн ерөнхийлөгч/

-Би өөрийгөө энэ хуралд ирсэн жижиг компанийн төлөөлөгч гэж бодож байна. Манайх сансрын холбооны чиглэлээр 10 жил тогтмол үйл ажиллагаа явуулж буй. Жижиг компани гэхлээр л нийгмийн хариуцлагагүй байна гэж байхгүй. Нийгмийн хариуцлагын тухайд хамгийн эхний ойлголт мэдээж татвараа төлөх тухай асуудал. Манай компани татвараа бүрэн гүйцэд төлдөг. Тухайн компанийг нийгмийн хариуцлагатай байхад нь манай хууль тогтоох дээд байгууллагууд бас тодорхой үүрэгтэй гэж боддог. Германы байгууллагаас хийж байгаа дээрх хурлаас олон сайхан мэдээлэл, олон санаа олж авлаа. Компанийнхаа

хувьд бид бүх үйл ажиллагааныхаа стандартыг хийх гээд оролдож эхлээд байна. Үйл ажиллагааны бүх процессыг стандартчилах юм бол ерөнхийдөө ажлын чанар сайжирна. Хэрэглэгчдэд хүрч байгаа үйлчилгээ тогтвортой байвал манай үйл ажиллагаа тогтвортой байна гэсэн үг. Тогтвортой байдал бол өрсөлдөх чадварын гол асуудал болж таарч байна. Зөв бизнес явуулах, зөв бизнесээ хөгжүүлэх, хүмүүсийнхээ нийгмийн байдлыг сайжруулах энэ бүхэн нийгмийн хариуцлагатай холбоотой.

### Б.Солонго: /MSC-ийн Маркетингийн захирал/

-КНХ гэдэг нь нэг дээр нэмэх нь нэг тэнцүү хоёр гэдэг шиг тодорхой биш, маш өргөн ойлголт. Манай хувьд татвараа төлөх, ажлын байр бий болгох, нийгмийн томоохон асуудлыг шийдэхэд оролцох зэргээр нийгмийн өмнө хүлээсэн үүрэгтэй. Тухайлбал, Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах зорилготой хэрэгжүүлж байгаа Мянганы сорилтын сангийн “Цэвэр агаар” төслийг MCS групп хамтран хэрэгжүүлж байна. Төр, засаг, хандивлагч байгууллага, хувийн хэвшил, худалдаж авч байгаа иргэд гээд бүгдээрээ дөрвөн талаасаа нийлээд агаарын бохирдлыг шийдэхээр тал талаас нь ажиллаж байна. Паалан гадаргуутай, байгальд ээлтэй зуухыг үнэгүй тараахгүй, иргэд хямдралтай үнээр худалдаж авах юм. Иргэн ч гэсэн өөрийнхөө хариуцлагыг хэрэгжүүлээд утаагүй хот болоход хувь нэмрээ оруулах ёстой. Энэ бол нийгмийн хариуцлага гэж ойлгож байна.

### Ц.Мөнхжин: /“Монголын өсвөр үеийнхний хөгжлийн үйлчилгээний төв” ТББ-ын захирал/

-КНХ-ийн талаар энэ бага хуралд оролцоод арай өөр ойлголттой боллоо. Өмнө нь компаниуд тухайн үйл ажиллагаа явуулж байгаа орон нутагтаа юм уу, эсвэл бараа бүтээгдэхүүн хэрэглэдэг хүмүүсийнхээ төлөө ямар нэгэн сайн зүйлсийг хийх ёстой. Тэр нь нэг удаагийн тусламж байж болно, эсвэл удаан хугацааны хөгжлийн хөтөлбөр байж болно гэж ойлгож байсан. Энд ирээд ер нь компаниудын хувьд нийгмийн хариуцлага гэдэг нь нэг үйл ажиллагаа, нэг хэлтэс тасгийн ажил биш юм байна, тухайн компани нийгмийн хариуцлагатай үйл ажиллагаа явуулж байж компанийн ашиг орлого ихсэж, өргөждөг юм байна. Тэгэхгүйгээр орчин үеийн нийгэмд бизнес хийхэд хэцүү болсон юм байна гэдгийг сайн ойлгож авлаа. Тэр утгаараа тухайн компани нь нийгмийн хариуцлагын бүх шатандаа төлөвлөгөө, стратеги боловсруулаад, тэрнийхээ дагуу нэг хэсэг хүмүүс бус компаниараа л ажиллаж байх ёстой юм байна. Гаднын байгууллагын хүмүүсийн ярьж байгаагаар КНХ гэдэг бол компанийн соёл, тухайн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх эхний шатнаас авахуулаад, тэр бүтээгдэхүүн хог болоод дахин ашиглагдах хүртэлх бүх процесс гэж ойлголоо.

### Б.Гантулга: /“Багануур” ХК-ийн Техникийн асуудал эрхэлсэн дэд захирал/

-“Багануур” ХК үүсгэн байгуулагдаад 33 жил болж байна. ►

▶ Энэ хугацаанд улс орны болоод нийгмийн өмнө тодорхой хариуцлага хүлээж ирсэн. КНХ гэдэг ойлголт сүүлийн үед маш хүчтэй яригдаж байгаа. Манай уурхай 1998 онд Монголд нөхөн сэргээлт гэсэн ойлголт байхгүй байх үед анх удаа нөхөн сэргээлт хийж байсан. Байгаль орчинд ээлтэй үйлдвэрлэл явуулах ёстойг ухамсарладаг. Манай эрхэм зорилгод ч энэ талаар тусгагдсан байгаа. Ер нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, нөгөө талаас байгаль орчин гэх мэт ийм нийгмийнхээ тал руу чиглэсэн асуудлыг эрхэм зорилгодоо оруулахыг чухалчилж ирсэн. Энэ чиглэлээр болдог сургалт бүрийг ажилтнууддаа хүргэхийг хичээдэг. 1100 орчим

ажилтантай. КНХ-ын ойлголтыг бүрэн ойлгож байна. Хэрэгжүүлмээр, анхаармаар зүйл байна. Хууль эрх зүйн хүрээнд ч гэсэн бодмоор юм харагдлаа. Илтгэлүүдээс сонсоход, гадаадынхны туршлага өндөр байгаа нь харагдаж байна л даа. Манай Монголын нөхцөлд төр, засаг анхаараад, компанийн нийгмийн хариуцлагын стандарт тогтоож өгвөл компаниуд үүнд нэгдэж ороод, нийгмийн хариуцлагаа гүн гүнзгийгээр утга төгөлдөр хэрэгжүүлбэл үр дүнтэй байх болов уу. Өмнө нь оюутнуудад тэтгэлэг өгөх, урлаг соёлынхонд туслах, тэмцээн уралдаанд явж байгаа тамирчдыг ивээн тэтгэх гэх мэт иймэрхүү явцуу хүрээнд ойлгодог байсан бол өнөөдөр глобал ойлголт авч чадлаа. ■

үйлчилгээний шинэ боломжийг Монголын аж ахуйн нэгжүүдэд танилцуулсан билээ. Логистик гэж чухам юу болох талаар Монголын логистикийн холбооны ерөнхийлөгч А.Мөнхболд “Маш энгийнээр хэлэхэд, харилцан хамааралтай, хамгийн үр ашигтай уялдаа холбоо юм. Үнэндээ бол монголчууд бид логистикч хүмүүс. Түүхийн явцад энэ логистикч байсан үзэл бодлоосоо холдсон. Чингис хаан өөрөө хамгийн сайн логистик менежер байсан. Чингис хаан бүх талын мэдлэггүй ч гэсэн хамгийн мэдлэгтэй хүмүүсээр өөрийгөө хүрээлүүлээд тэднийгээ зөв удирдаад л амжилтад хүрсэн. Чингисийн үеийн байлдан дагуулалтыг ажиглаад харахад, торгоны замыг л түлхүү дагасан байдаг. Тиймээс худалдааны логистикийн асар том сүлжээг байгуулж чадсан” гэв.

Логистик өнөөдөр яагаад бидэнд хэрэгтэй болсон бэ гэвэл монголчууд бид ямар нэгэн том төсөл, хөтөлбөр зарлахдаа тэр төсөлд юу, хэзээ шаардлагатай байгааг тооцохгүй хийснээс л олон асуудалтай учирдаг байна.

Логистикийг гурав хувааж болно. Худалдан авалт буюу түүхий эд нийлүүлэлт, үйлдвэрлэлт, борлуулалтын логистик. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн гинжин хэлхээг системээр нь төлөвлөнө гэсэн үг. Тэгэхлээр энэ бол зүгээр нэг хоёр бизнесмэнийн хоорондын яриа бус, системийн хувьд нь харж оновчтойгоор төлөвлөхийг хэлж байна. Амжилтгүй хэрэгжсэн олон төсөл манайд байдаг шүү дээ. Тэр бүгдийн улбааг харахад, ямар ч логистик байхгүй байна. Мэдээлэл, санхүү, материалын урсгалыг зөв зохистой зохицуулаад, тухайн төслийг амжилтад хүргэдэг шинжлэх ухаан аж. Өнөөдөр манай нийгэмд тулгараад байгаа хүнсний аюулгүй байдал, эмийн хангамж, нефть хангамж, хотын утаа, автомашины түгжрэл, нийтийн тээвэр, хил боомт, ашигт малтмалын экспорт, төмөр зам, байгаль орчин гэх мэт асуудлын шийдлийн хариу нь логистик болж байна. Учир нь өндөр хөгжилтэй бусад орон логистикийн дэд бүтцийг хөгжүүлснээр нийгэмд тулгарсан асуудлуудыг амжилттай шийдэж иржээ. “Монгол Улс өнөөдөр эрчимтэй хөгжлийн гараанаас уухилан хөдлөх гэж буй галт тэрэг мэт зогсож байна” гэж А.Мөнхболд хэлсэн. Уг галт тэрэг ▶



Логистик

## Логистикийн салбарыг хөгжүүлэх алхмыг хийлээ

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (ГОУХАН)-ийн Эрдэс баялаг, түүхий эд иж бүрэн санаачлага хөтөлбөр нь “Худалдааны логистик ба нийлүүлэлтийн менежмент” сэдэвтэй олон улсын бага хурлыг зохион байгуулсан юм. Энэхүү арга хэмжээг Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо, Монголын логистикийн холбоо, “Хасбанк”, Герман-Монголын бизнес эрхлэгчдийн холбоо, Монголын

бизнесийн зөвлөл хамтран зохион байгуулсан бөгөөд нийт 120 гаруй логистикийн салбарын бизнес эрхлэгч оролцсон.

Логистик гэдэг нэр томъёог сүүлийн жилүүдэд өргөнөөр хэрэглэдэг болсон ч хангамж, борлуулалтын сүлжээ гэхээсээ илүүтэй тээвэрлэлт гэж ойлгодог. Тус бага хурлаар Монголын логистикийн өнөөгийн байдал, хэтийн төлөв болон юуны өмнө логистикийн

► нь Герман, Норвегийн эсвэл Науру улсын замаар явах уу гэдэг асуудлыг шийдвэрлэх чиглэлээр логистикийн салбарын хувийн хэвшлийнхэн, төрийн бус байгууллагууд санал бодлоо хуваалцсан юм.

“Улаанбаатар Транс” ХХК-ийн ерөнхий захирал Ж.Батбаяр “Одоогоор логистик гэдэг зүйл Монгол улсад сайн нэвтэрч хөгжөөгүй байна. Тээвэр зуучлалын болон төрийн байгууллагууд энэ тал дээр ямар арга хэмжээ авч, яаж хурдтай өсөж байгаа цаг үетэйгээ нийцүүлэн логистикийг хөгжүүлэх талаар ярилцаж байна. Герман улсын холбогдох байгууллагууд өндөр ач холбогдол өгөөд манай логистикийн холбооны шугамаар хамтраад ийм бага хурал зохион байгуулж байгаа нь сайшаалтай зүйл. Герман нь дэд бүтэц, логистикийн чиглэлээр өндөр амжилт гаргасан улс. Логистикийг ганц тээвэрлэлттэй холбож болдоггүй юм байна. Харин бүтээгдэхүүн хэрэглэгч, үйлдвэрлэгч, тээвэрлэгч гэх мэтчилэн компаниудын олон

талын хамтын үйл ажиллагааны үндсэн дээр хамгийн хямд зардлаар, үр дүнтэй, эдийн засгийн хувьд хэмнэлттэй байдлаар хүрэх ёстой. Тэгж байж бараа бүтээгдэхүүн нь үнэ өртгийн хувьд эцсийн хэрэглэгч дээр их тааламжтай нөхцөл үүсэхийг хэлж байна. Хоёрдугаарт, Монгол орны дэд бүтцийн хөгжил, тэртусмаа уулуурхайн баялаг, уул уурхайн бүтээгдэхүүнийг ямар тээврийн хэрэгслийг сонгож, яаж шуурхай зохион байгуулах талаар ярьж байна. Зарим компани өөрсдийнхөө орчин үеийн технологи бүхий бараа бүтээгдэхүүнийг танилцуулсан байна. Энэ бүхнийг бид сайн судлах ёстой. Эдгээр компаниудаас санал болгож байгаа техник, технологи Монголд ашиглахад тохиромжтой юм бол мэдээж бид авч ашиглах хэрэгтэй. Тэгэж байж өөрсдийн үйл ажиллагааг шинэ шатанд гаргана гэж бодож байна” гэв.

Өвөг дээдсийн амь насаараа тэмцэн хамгаалж, харамлаж ирсэн байгалийн баялгийг эргэлтэд

оруулахдаа дэлхийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл нийлүүлэлтийн үйл ажиллагааг өөртөө татан, түүний нэг чухал гинжин хэлхээ болох нь алс ирээдүйд хийсэн хамгийн чухал шийдэл байх болно. Логистикийн салбарт тэргүүлэгч германчуудын мэргэжлийн туршлага, тусалцаа, дэмжлэг, хувийн хэвшлийн харилцан ашигтай хамтын ажиллагааны оролцоогоор Монголын логистикийн ирээдүйг тодорхойлоход тусалцаа үзүүлэхээр болжээ.

Штефан Хансельманн, Монголын логистикийн холбооны тэргүүн А.Мөнхболд нар хамтран ажиллах санамж гэрээнд гарын үсэг зурлаа. Санамж гэрээгээр германчууд Монголын талтай хамтарч логистикийн сургалт, семинар зохион байгуулах, логистикийн чиглэлээр төсөл хөтөлбөрт хамтран ажиллах, “Логистикийн академи” байгуулахад тусалцаа дэмжлэг үзүүлэхээр болсон юм. ■

**KHATAN TUUL**  
*Pure Water*

Packaging quantities of Pure water:  
 0.35 L /bottled/  
 0.5 L /bottled/  
 1 L /bottled/  
 19L /bottled/

Маркетинг: 99071655  
 Засналга авах утас: 70173386  
 Факс: 976-11-70174494

Produced and bottled by "Welton Trade" Co., Ltd of Mongolia

## Бизнесийн зөвлөгөө

# Зан чанар амжилтын бүрэлдэхүүн хэсэг

*Жэй Шапиро нь Английн зохиолч. Тэрбээр бизнес эрхлэгчдийг зан чанартай нь холбож үздэг бөгөөд “Бизнесийн ухааныг мэддэг байхаас гадна тухайн хүний зан чанар амжилтын бүрэлдэхүүн хэсэг мөн” гэж тодорхойлсон байдаг. Зохиолч хүн бизнесмэнд ямар зөвлөгөө өгөхийг сонирхоорой.*

## 1. Өчүүхэн амжилт заримдаа томоос илүү

Аливаа бизнес нь бодит амьдрал дээр хамгийн хэрэгтэй зүйлсээс эхэлдэг. Тиймээс бизнес эхлэх гэж байгаа бол өөртөө мөн бусдад асуулт тавиаарай. Энэ нөхцөлд зах зээлийн судалгаа мөн хэрэг болно гэдэгт итгэлтэй байна. Хэн таны үйлчлүүлэгч байх вэ гэдгээс эхлэн санаагаа баяжуулаарай. Зарим тохиолдолд зах зээлд ямар нэг цоорхой харагдвал цаанаа заавал учир шалтгаантайг санахад илүүдэхгүй. Хэрвээ Та бизнес анхлан эрхлэхээр сэтгэл шулуудсан бол амжилтад хүрэх баталгаа өндөртэй бизнесийг судлахад илүүдэхгүй болов уу. Түүнчлэн ямар ч шинэ санааг баяжуулаад цаашид илүү амжилтад хүрсэн түүхийг санах хэрэгтэй. Жишээлбэл, тоть шувууны тэжээл хүргэж өгч үйлчилдэг байлаа гэхэд бизнесийн санаагаа улам өргөн хүрээтэй болгож, бусад гэрийн тэжээвэр амьтны хоол хүргэж өгөхийг бод. Өргөн зах зээлд өчүүхэн амжилт гаргах нь заримдаа жижиг зах зээл дээр томоохон амжилт олохоос илүү ач холбогдолтой гэдгийг санаарай.

## 2. Мөнгөө байнга эргэлдүүл

Бэлэн мөнгөний урсгалгүй бизнес нь зүрхний цохилтгүй мэт амьгүй байна гэсэн үг. Иймээс Та аль болох түргэн хугацаанд мөнгөө эргэлтэд оруулах шаардлагатай. Үйл ажиллагаа эхлэхээсээ өмнө мөнгөө цуглуулж, ажлаа дуусахаасаа өмнө өргүй болсон бай. Хэрвээ Та жижиглэнгийн худалдаа эрхэлдэг бол үйлчлүүлэгчдээ бараа бүтээгдэхүүнийг нь машинаар шуурхай хүргэж өгөх үйлчилгээг санал болгож болно.

## 3. Сул зардлыг бага байлга

Үйл ажиллагаанд гарч буй зардлыг аль болох бага байлгахыг хичээ. Мэдээж Та бизнес эрхлэгчийн хувьд ажлын байр, эдэлж хэрэглэж байгаа зүйлдээ анхаарна. Гэвч алтадсан бэхний савтай болох гэж бүү яар. Ажлын байранд зарим нэг хуучин хэрэглэж байсан эд зүйлсийг ашиглаж болох тухай бодоорой. Та түүхий эд нийлүүлэгчидтэй төлбөрөө урьдчилан хийж байгаа тохиолдолд хямдралтай үнээр тохиролц.

## 4. Хэтрүүлэн үнэлэх

Аливаа зүйлийн үнийг нь хэтрүүлж тооцоолох нь сэтгэл зүйн дасгал хийж байна гэж ойлгож болно. Энэхүү сэтгэлгээг ирээдүйн аж ахуйн нэгж эрхлэгч эхнээсээ л ойшоож авч үзэх хэрэгтэй. Энэ нь хүрэх газраа очих замын хугацаан дээр хагас цаг нэмж тооцоолохтой л адил зүйл юм. Нийт тооцоогоо арай өндөр үнээр бодож хийх нь зардал нэмэгдсэн тохиолдолд таны сэтгэлийг гонсойлгохоос сэргийлнэ. Нэгэнт урьдчилан тооцоолоод сурах юм бол Та энэ зарчмыг үргэлж баримталж байх болно.

## 5. Сурталчилгаа, сурталчилгаа, бас дахин сурталчилгаа

Та бизнесийн аль ч шугамыг барьж байсан хамаагүй, хамгийн гол нь бизнес хийхийн тулд бүтээгдэхүүнээ зарах ёстой. Ингэж

бүтээгдэхүүнээ борлуулахын тулд боломжийн үйлчлүүлэгч нарт өөрийн бараа үйлчилгээний талаар сурталчилгаа хийх хэрэгтэй. Бизнесээ тогтвортой байлгахын тулд анхны худалдан авагчидтайгаа холбоо тогтоож, тэднийг дахин өөрт чинь хандахыг нь дэмжин урамшуул. Үйлчлүүлэгч байхгүй бол Та бизнес эрхлээгүйтэй адил гэдгийг санаж яв.

## 6. Ашиг орлогоо нэмэгдүүл

Зарлагаа хянаж сурах ухаанд суралцах нь амжилттай бизнесийн хаалгыг нээх түлхүүр болно. Ашгийн хэмжээгээ нэмэгдүүлэх арга нь энгийн томъёон дээр суурилдаг. Санаачлагатай байж, давтан бизнесийг дэмжин, өөрийн бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг нэмэгдүүлэх. Олон хүнд хүрч үйлчлэх тохиолдолд үнээ бага зэрэг өсгөхөд л бизнесийн өсөлтийг үзнэ.

## 7. Таны стратеги үйлчилж байна уу?

Энэ асуултад хариулахын тулд Та сурталчилгааныхаа амжилтыг мөшгиж үзэх хэрэгтэй. Сонинд өгсөн таны зар хэр зэрэг үр өгөөжтэйг мэдэхгүй бол орон нутгийн сонинд ийнхүү зар сурталчилгаагаа оруулсан хэвээр байх уу, үгүй юу гэдгээ ухаалгаар шийдэж чадахгүй. Бизнесэ олигтой үйлчилдэггүй сурталчилгаанд маш их хөрөнгө мөнгө үрэх тохиолдол байдаг. Энэ нь бизнес эрхлэгчийн өөрийн мэдлэг муу байгаатай холбоотой. Үйлчлүүлэгчдээсээ Та болон таны компанийн талаар хаанаас, яаж олж мэдсэнийг нь асуу.

## 8. Суралцах агшин

Дөнгөж хөлд орж байгаа хүүхэд унаж тусдаг нь энэхүү үйл явцын зайлшгүй нэг хэсэг мөн. Шинээр бизнес эрхлэгч Та олон удаа бүдэрч унаад байхыг хүсэхгүй ч суралцах нь бизнесийн үйл явц мөн гэдгийг сайтар ойлгох хэрэгтэй. Шинээн бизнесмэнд туршлага дутах явдал гардаг ч Та суралцаж, мэдлэгээ зузаатгаж чадахгүй гэсэн үг биш юм. Өөрийгөө маш сайн боловсруулж хөгжүүл. Таны бизнестэй ижил төрлийн бизнесийг амжилттай эрхлэгчдийн түүхийг унш. Бусдын алдаанаас суралцах нь таныг өөрөө алдаа гаргахаас сэргийлнэ.

## 9. Буяны үйл ажиллагаа явуулаад байна уу...

Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг бууруулах нь борлуулалтыг сайжруулж, худалдан авагчдын анхаарлыг зүй ёсоор татдаг ч бизнесийн ертөнцөд анх хөл тавьж байгаа хүнд бол дандаа хамгийн сайн алхам нь биш юм. Үнээ буулгана гэдэг нь Та өөрийн олох ашгаа золиосонд гаргаж байна гэсэн үг. Шинээр бизнес эрхэлж байгаа хүнд төдийлэн тийм ч тохиромжтой зүйл биш юм. Харин үүний оронд бараа үйлчилгээндээ үнэ цэнийг нэмэхийг оролд. Жишээ нь, Та цайны газар ажиллуулдаг бол үйлчлүүлэгчдэд зориулж карт нээгээд, тухайн үйлчлүүлэгчээ танайхаар үйлчлүүлэх бүрт тамга дарж өгч байх. Тэгээд танайхаар таван удаа үйлчлүүлсэн тохиолдолд нэг удаа үнэгүй цай, кофе уух эрхийн бичиг хийж өгөөд үз.

## 10. Зөвлөгч олж ав

Та бизнесээ анх эхлэхэд заавал мэргэжлийн бизнесийн зөвлөгч байгууллагын үйлчилгээг ашиглах албагүй. Гэхдээ хэн нэгнээс зөвлөгөө авах нь маш чухал. Та өөрийн төсөл, урам зоригтоо хөтлөгдсөн байхад таны бизнесийг өөр нүдээр, хажуугаас харсан хүн илүү бодитоор дүгнэх чадвартай байдаг. Иймээс бусдын зөвлөгөө чухал үүрэгтэй. Тухайлбал, таны хүүхэд залуучуудын арьсанд зориулж үйлдвэрлэсэн нүүр цэвэрлэх шингэн дээр хөгшин хүний зураг байж таарахгүй. Төвийг сахсан үзэлтэй зөвлөгч таны чухам юугаа буруу хийгээд байгааг зааж өгнө.

Эх сурвалж: Gaebler.com ■

## Бизнесийн завсарлага

## Та ямар ном уншиж байна вэ?


Жэм дэ Бурбон Парм:

/Нидерланд улсын Гадаад явдлын яамны байгалийн баялаг хариуцсан тусгай элч, Хан хүү/

-Өнгөрсөн үеийн түүхэн үйл явдлыг харуулсан роман унших дуртай. Одоогоор Карол Хилленбрандын бичсэн маш сонирхолтой “Загалмайтны аян дайн: Ислам шашинтны үзэл бодлоор” зохиолыг уншиж байгаа гэж манай улсад дэлхийн залуу удирдагчидтай хамт хийсэн айлчлалынхаа үеэр хэлсэн билээ.

Загалмайтнууд Йерусалем хотыг байлдан эзэлж авсны дараа 900 жил өнгөрсөн хойно зохиолч энэхүү үйл явдлыг соёлын талаас нь авч үзсэнээрээ онцлогтой. Түүх соёлын

арвин эх сурвалжийг багтаасан энэхүү бүтээлд загалмайтнуудыг лалын шашинтай ард түмэн хэрхэн хүлээж авч ойлгож байсныг тэдний нүдээр дүрсэлсэн байна. Түүнчлэн загалмайтнууд, исламын шашны ертөнцөд цэрэг, соёл, сэтгэл зүйн хувьд хэрхэн нөлөөлснийг тод томруун гаргажээ. Өнөөг хүртэл зөвхөн нэг талаас нь авч үзэж байсан Дундад зууны зөрчилтэй түүхэн үйл явдлыг Исламын түүхийн профессор Карол Хилленбранд урьд өмнө нь ил гаргаж байгаагүй өнцгөөс харуулсан байна.



С.Намжилмаа:

/Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны Хот байгуулалт хариуцсан мэргэжилтэн/

-Б.Даваажав багшийнхаа бичсэн гурван дэвтэртэй номыг уншиж байгаа. “Монголчуудын оюун сэтгэлгээний нууц” нэртэй тэргүүн дэвтэрт нүүдэлчин болон суурин соёлтой ард түмний оюун санааны ялгааг харуулжээ. Мөн монголчууд эртнээс охор агшин, агшин, тан, хоног, сар гэх цаг хугацааны нарийн нэгжтэй байсан байна. Хүн гэдэг ойлголтыг гүн ухааны үүднээс тайлбарласан байдаг. Жишээ нь “Дархан хүн бурхан ухаантай” гэдгийг юу гэж ойлгох вэ? “Монголчуудын нүүдэл иргэншил” нэртэй дэд дэвтэрт бэлчээрийн мал аж ахуй, хүн болон байгалийн зохицол, уялдаа холбоог

харуулсан. “Эзэн Богд Чингисийн улс тохинуулсан нууц” хэмээх гутгаар дэвтэрт монголчууд төрийг яаж үзэж, төрийн бодлого, зохион байгуулалтыг хэрхэн хэрэгжүүлж байсныг дүрсэлжээ. Жишээ нь зөвхөн дайн байлдаан бус, байгалийн гамшгийн үед ямар төрийн бодлоготой байсан тухай. Ер нь төрийг эрдэм гэж үзэж байсан. Тус гутгаар дэвтэр миний ширээний ном болсон. Урьд нь уншиж байсан ч одоо өөр өнцгөөс харж, боловсруулан тунгаан уншиж байгаа гэв.

2008 онд анх хэвлэгдэн гарсан энэхүү гурван дэвтэр ном нь архитектурын ухааны доктор Б.Даажавын бүтээл аж.




А.Оюунчимэг:

/“Инкомнет” компанийн ерөнхийлөгч/

- Америкийн эрдэмтэн, анагаах ухааны доктор, нэрт мэдрэл судлаач Дэвид Пэрлмуттэрийн “Сайн тархины тухай: Ой санамж болон оюуны чадвараа сайжруулж, тархиа хөгшрөлтөөс хамгаалах нь” номыг хамгийн сүүлд уншсан. Ихэнх хүмүүс эрт орой хэзээ нэгэн цагт, түлхүүрээ юм уу барьж явсан зүйлээ хаашаа хийснээ санахгүй байх, урьдчилан бичиж тэмдэглээгүй л бол дэлгүүрээс юу авах ёстойгоо мартаж, оройн зоог дээр ч юм уу, ажил албаны уулзалт дээр дөнгөж сая танилцсан хүний нэрийг эргээд санахгүй байх, эсвэл зүгээр л юу ярьж байснаа, юу хэлэх гэснээ мартчих гэх мэт тийм ч тааламжтай биш зүйлсийг анзаарч эхэлдэг. За тэгээд ганц сонсоход л хангалттай байдаг утасны дугаар гэх мэт залуу хүний оюун ухааны тухай санах

ч хэрэггүй болсон мэт санагдах үе байдаг даа. Уг нь энэ бүхэн нас ахихын зайлшгүй үр дагавар биш юмсанж. Нөгөө талаар иймэрхүү шинж тэмдгийг “насны эрх” хэмээн хүлээн зөвшөөрч, зөнд нь орхиж болохгүй нь. Анхны шинж тэмдэг нь салгалахаас эхлээд биеэ хянаж чадахгүй болтлоо хүндэрдэг Паркинсоны өвчин, тархины бор гадаргын хатингиршлаас үүдэлтэй Альцхаймерийн өвчнөөс авахуулаад манайхны хэлдгээр “цус харвах” гэх мэт ноцтой үр дагаварт хүргэх эрсдэлийг бий болгодог аж.

Анх 2005 онд “Риверхэд Букс” хэвлэлийн газраас эрхлэн гаргасан энэхүү ном нь оюун санаагаа хурц, сэргэг байлгах үүднээс хоол хүнс, дасгалаар тархиа хэрхэн дэмжиж болох тухай дэлгэрэнгүй өгүүлсэн зөвлөмжийг багтаажээ. ■



[www.mongolianeconomy.mn](http://www.mongolianeconomy.mn)

